


АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ТАЙЛАН



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗАР

2004 он



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ГАЗАР



АЗИЙН ХӨГЖЛИЙН
БАНК

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ТАЙЛАН 2002-2003

**2002 оны 10 сараас 2003 оны 9 сарыг дуусталх
хугацаанд улирлаар явуулсан
Ажиллах Хүчний Судалгааны нэгдсэн тайлан**

Улаанбаатар
2004

DDC
331.1 021 8
A-315

Санал хүсэлт байвал доорхи хаягаар холбоо барина уу.
Энэхүү тайлан нь англи хэлээр хэвлэгдсэн болно.

Хаяг:

Засгийн Газрын III байр
Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 44
Улаанбаатар, Монгол улс

E-mail: nso@magicnet.mn
Website: <http://www.nso.mn>
Факс: 976-11-324518
Утас: 976-11-326414

ISBN 99929-83-08-6

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ
ӨМНӨХ ҮГ
ТАЛАРХАЛ
Товчилсон үгийн жагсаалт

V
VIII
X
XI

Бүлэг 1. ЕРӨНХИЙ ТОЙМ 1

Нийтлэг зүйл
Тайлангийн бүтэц
Хүн ам зүйн үзүүлэлтүүд
Тухайн үеийн эдийн засгийн идэвхитэй болон идэвхигүй хүн ам
Тухайн үед ажил эрхэлсэн хүн ам
Улирлын хэлбэлзэл
Ажил эрхлээгүй хүн ам
Байнгын идэвхитэй хүн ам
Тухайн үеийн эдийн засгийн үйл ажиллагаа
Эдийн засгийн бус үйл ажиллагаа
Албан бус сектор
Хүүхдийн эдийн засгийн идэвхи

Бүлэг 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 11

Нийтлэг зүйл
Судалгааны зорилго
Үндсэн зорилго
Тодорхой зорилтууд
Судалгааны хамрах хүрээ
Судалгааны хугацаа
Судалгааны түүвэрлэлт
Судалгааны асуулгын хуудас
Туршилтын судалгаа
Үр дүнгийн хүснэгт
Мэдээллийн нууцлал
Судалгааны зохион байгуулалт
Судалгааны ахлагч, тоологч нарын сургалт
Мэдээлэл цуглуулалт
Мэдээлэл боловсруулалт

Бүлэг 3. СУДАЛГААНЫ ДҮН 21

Нийтлэг зүйл
Хүн ам зүйн үзүүлэлтүүд
Хүн амын тоо, байршил, бүс нутгаар
Хүн амын нас, хүйсийн бүтэц
Хүн ам зүйн ачаалал
Гэрлэлтийн байдал
Өрхийн бүтэц

Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх
Боловсролын түвшин
Сургуульд хамрагдалт
Бичиг үсгийн мэдлэгийн түвшин

Бүлэг 4. ТУХАЙН ҮЕИЙН ИДЭВХИ 31

Өрхийн гишүүдийн тухайн үеийн үйл ажиллагаа
Эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг
Тухайн үеийн эдийн засгийн бус үйл ажиллагаа /гэрийн ажил/
Эдийн засгийн бус үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг
Ус авах, түлээ түлш бэлтгэх

Бүлэг 5. АЖИЛЛАХ ХҮЧ 41

Ажиллах хүч
Ажиллах хүчний тооцоо
Ажиллах хүчний оролцооны түвшин
Насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшин
Эдийн засгийн идэвхигүй хүн ам

Бүлэг 6. ТУХАЙН ҮЕИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ 49

Ажил эрхлэлт
Тухайн үеийн ажил эрхлэлт, улирлаар
Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар
Ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангиллаар
Ажиллагчдын тоо, ажил эрхлэлтийн байдлаар
Ажиллагчдын тоо, байгууллагын төрлөөр
Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангиллаар
Давхар ажил эрхлэлт
Бүрэн бус ажил эрхлэлт

Бүлэг 7. АЖИЛГҮЙДЭЛ 59

Ажилгүйчүүдийн тоо
Ажилгүйчүүдийн тоо, хот хөдөөгөөр
Ажилгүйдлийн түвшин
Ажилгүйчүүдийн тоо, насны бүлгээр
Ажилгүйчүүдийн ажилгүй байсан хугацаа

Ажилгүйчүүдийн боловсролын түвшин
Ажилгүйчүүдийн хийхийг хүсч байгаа ажил
Ажилгүйчүүдийн ажил хайсан хэлбэр
Ажилгүйчүүдийн ажил хайгаагүй шалтгаан

Бүлэг 8. БАЙНГЫН ИДЭВХИ67

Нийтлэг зүйл
Насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшин
Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар
Ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангиллаар
Ажилгүйдэл
Тухайн үеийн идэвхи болон байнгын идэвхийн уялдаа, холбоо
Хүүхдийн хөдөлмөр

Бүлэг 9. АЛБАН БУС СЕКТОР ДАХЬ АЖИЛ ЭРХЛЭЛТ75

Нийтлэг зүйл
Тодорхойлолт
ХАА-н салбарын ажил эрхлэлт
ХАА болон ХАА-н бус салбар дахь ажил эрхлэлт
Албан бус сектор дахь аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо
Албан бус секторыг судалгаанд тодорхойлсон байдал
Албан бус секторын ажил эрхлэлтийн тооцоо
Үндсэн болон давхар ажил эрхлэлт, хүйсээр
Албан бус секторт ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангиллаар
Албан бус секторт ажиллагчдын боловсролын түвшин

Бүлэг 10. ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ ...83

Нийтлэг зүйл
Сургууль завсардалт
Эдийн засгийн тухайн үеийн үйл ажиллагаа
Эдийн засгийн бус үйл ажиллагаа
Хүүхдийн хөдөлмөр
Хүүхдийн хөдөлмөр, ажил мэргэжлийн ангиллаар
Хүүхдийн ажил эрхлэлтийн байдал
Хүүхдийн хөдөлмөр, байнгын идэвхийн аргачлалаар

Бүлэг 11. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ... 91

Нийтлэг зүйл
Хүн амын тоо, улирлаар
Эдийн засгийн идэвхитэй хүн ам
Ажиллагчдын тоо
Ажил эрхлээгүй хүн ам
Тухайн үеийн үйл ажиллагаа
Ажилласан цаг

Бүлэг 12. ТҮҮВРИЙН АЛДАА 99

Хавсралт 1. ХҮСНЭГТҮҮД
Хавсралт 2. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ
Хавсралт 3. ТҮҮВЭРЛЭЛТ
Хавсралт 4. АСУУЛГЫН ХУУДАС
Хавсралт 5. Судалгаанд оролцогчдын нэрс

Хүснэгт 1. 15 ба түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, хүйс, улирлаар	4
Хүснэгт 2. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлт, сонгосон үзүүлэлтүүдээр, улирлаар	5
Хүснэгт 3. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажилгүйдэл, сонгосон үзүүлэлтүүдээр, улирлаар	6
Хүснэгт 4. Байнгын идэвхитэй 15 ба түүнээс насны хүн амын ажил эрхлэлт, сонгосон үзүүлэлтүүдээр, улирлаар	7
Хүснэгт 5. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, дүнд эзлэх хувь, улирлаар	8
Хүснэгт 6. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, улирлаар	8
Хүснэгт 7. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, улирлаар	9
Хүснэгт 8. Сүүлийн 7 хоногт албан бус секторт ажилласан хүн амын тоо, байгууллагын төрөл, үндсэн болон давхар ажил эрхлэлтийн байдал, хүйсээр	9
Хүснэгт 9. Бүс нутагт ногдох түүврийн хэмжээ	16
Хүснэгт 10. Ажиллах хүчний 1 дүгээр улирлын судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрхийн тоо: 2002 оны 10-12 сар	16
Хүснэгт 11. Ажиллах хүчний 2 дугаар улирлын судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрхийн тоо: 2003 оны 1-3 сар	16
Хүснэгт 12. Ажиллах хүчний 3 дугаар улирлын судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрхийн тоо: 2003 оны 4-6 сар	16
Хүснэгт 13. Ажиллах хүчний 4 дүгээр улирлын судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрхийн тоо: 2003 оны 7-9 сар	16
Хүснэгт 14. Ажиллах хүчний судалгаанд хамрагдсан тооллогын нийт нэгж болон өрхийн тоо: 2002 оны 10 сараас 2003 оны 9 сар	17
Хүснэгт 15. Өрх, хүн амын тоо, хот хөдөө, бүсээр	24
Хүснэгт 16. 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөө, бүсээр	24
Хүснэгт 17. Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр	25
Хүснэгт 18. Хүн амын нас, хүйсийн бүтэц, хүйсийн харьцаа	25
Хүснэгт 19. Хүн ам зүйн ачааллын харьцаа, хот, хөдөө, бүсээр	26
Хүснэгт 20. Хүн амын гэрлэлтийн байдал, хот, хөдөө, бүсээр	26
Хүснэгт 21. Өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоо, хот, хөдөө, бүсээр	27
Хүснэгт 22. Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор	27
Хүснэгт 23. 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хот, хөдөө, хүйс, дүнд эзлэх хувиар	28
Хүснэгт 24. 7-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр	28
Хүснэгт 25. Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, хот, хөдөө, бүсээр	29
Хүснэгт 26. Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр	29
Хүснэгт 27. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүн амын тоо, дүнд эзлэх хувь	34
Хүснэгт 28. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, насны бүлэг, хүйс, байршлаар	35
Хүснэгт 29. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн 5 ба түүнээс дээш насны хүмүүсийн тоо, дүнд эзлэх хувь	36
Хүснэгт 30. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр	37
Хүснэгт 31. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцсон 15, түүнээс дээш насны хүн амын тоо, зарцуулсан цаг, хүйс, хот, хөдөөгөөр	38
Хүснэгт 32. Ус авсан хүн амын тоо, насны бүлэг, хүйс, эдийн засгийн идэвхийн байдлаар	39
Хүснэгт 33. Мод, түлээ бэлтгэсэн хүн амын тоо, насны бүлэг, хүйс, эдийн засгийн идэвхийн байдлаар	40
Хүснэгт 34. 15, түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн байдал, хот, хөдөө, хүйсээр	44
Хүснэгт 35. 15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний байдал/сүүлийн үеийн судалгаануудын дүнгээр/	45
Хүснэгт 36. 15, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин тухайн насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр	46
Хүснэгт 37. 5-17 настай хүүхдүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр	47

Хүснэгт 38. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхигүй хүн амын дүнд эзлэх хувь, идэвхигүй байгаа шалтгаан, хүйс, байршлаар	48
Хүснэгт 39. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр	51
Хүснэгт 40. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, хүйсээр	52
Хүснэгт 41. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	52
Хүснэгт 42. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар	53
Хүснэгт 43. Тухайн үед ажил эрхэлсэн 15, түүнээс дээш насны хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, бүс нутгаар	54
Хүснэгт 44. Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар	55
Хүснэгт 45. Давхар ажил эрхэлж буй хүн амын тоо, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр	55
Хүснэгт 46. Бүрэн бус ажил эрхлэлт, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр	56
Хүснэгт 47. Бүрэн бус ажил эрхлэлт, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр	57
Хүснэгт 48. Ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшин, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр	61
Хүснэгт 49. Ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшин, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр	62
Хүснэгт 50. Ажилгүйчүүдийн насны бүтэц	63
Хүснэгт 51. Ажилгүйчүүдийн хөдөлмөр эрхлээгүй хугацаа, хот, хөдөө, хүйсээр	63
Хүснэгт 52. Ажилгүйчүүдийн боловсролын түвшин, хот, хөдөө хүйсээр	64
Хүснэгт 53. Ажилгүйчүүдийн тоо, хийхийг хүсч буй ажил, ажил мэргэжлийн ангиллаар	64
Хүснэгт 54. Ажилгүйчүүдийн ажил хайсан хэлбэр, хот, хөдөө, хүйсээр	65
Хүснэгт 55. Ажилгүйчүүдийн сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй шалтгаан, хот, хөдөө, хүйсээр	66
Хүснэгт 56. 15, түүнээс дээш насны байнгын идэвхитэй хүн амын тоо, хот, хөдөө, хүйсээр	70
Хүснэгт 57. 15, түүнээс дээш насны байнгын идэвхитэй хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр	70
Хүснэгт 58. Сүүлийн 12 сард ажил эрхэлсэн 15, түүнээс дээш насны хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр	71
Хүснэгт 59. Сүүлийн 12 сард ажил эрхэлсэн хүн амын тоо, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр	71
Хүснэгт 60. Байнгын идэвхитэй хүн амын ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр	72
Хүснэгт 61. 15, түүнээс дээш насны хүн амын тоог тухайн үеийн болон байнгын идэвхийн байдлаар харьцуулан гаргасан нь	72
Хүснэгт 62. 5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхи, сүүлийн 7 хоног болон 12 сарын байдлаар	73
Хүснэгт 63. ХАА болон ХАА-н бус салбарт тухайн үед ажиллаж байгаа 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр ..	78
Хүснэгт 64. ХАА болон ХАА-н бус салбарт тухайн үед ажиллаж байгаа 15, түүнээс дээш насны хүн амын тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр ..	79
Хүснэгт 65. Тухайн үед ажил эрхэлж байгаа 15, түүнээс дээш насны хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, ажиллагчдын тоогоор ..	79
Хүснэгт 66. Тухайн үед ажил эрхэлж байгаа 15, түүнээс дээш насны хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, ажиллагчдын тоогоор ..	80
Хүснэгт 67. Тухайн үед албан бус секторт ажиллаж байгаа ажиллагчдын тоо, байгууллагын төрөл, үндсэн болон давхар ажил эрхлэлтийн байдлаар	81
Хүснэгт 68. Албан бус секторт ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангилал, байгууллагын төрлөөр	81
Хүснэгт 69. Албан бус секторт ажиллагчдын тоо, боловсролын түвшин, байгууллагын төрлөөр	82
Хүснэгт 70. 5-17 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүй шалтгааны дүнд эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр	85
Хүснэгт 71. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн тоо, эзлэх хувь, хүйсээр	86
Хүснэгт 72. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн тоо, эзлэх хувь, хүйсээр	87
Хүснэгт 73. 5-17 насны ажиллаж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, хүйсээр	87
Хүснэгт 74. 5-17 насны ажиллаж байгаа хүүхдийн ажил эрхлэлтийн байдал, хүйс, насны бүлгээр	88
Хүснэгт 75. 5-17 насны хүүхдийн ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, хүйс, сүүлийн 7 хоног болон 12 сарын байдлаар	89

Хүснэгт 76. 5-17 насны хүүхдийн ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, байршил, сүүлийн 7 хоног болон 12 сарын байдлаар	89
Хүснэгт 77. Өрх, хүн амын тоо, улирлаар	93
Хүснэгт 78. 15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, улирлын тооцоогоор	94
Хүснэгт 79. Тухайн үеийн идэвхээр тодорхойлогдсон 15, түүнээс дээш насны ажил эрхэлсэн хүн амын тоо, улирлаар	94
Хүснэгт 80. Байнгын идэвхээр тодорхойлогдсон 15, түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд, улирлаар	95
Хүснэгт 81. Байнгын болон тухайн үеийн идэвхийн байдал, улирлаар	96
Хүснэгт 82. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүн амын тоо, улирлаар	97
Хүснэгт 83. Сүүлийн 7 хоногт ажилласан дундаж цаг, насны бүлэг, улирлаар	98
Хүснэгт 84. Стандарт алдааны тооцоо	102
Хүснэгт 85. Стандарт алдааны тооцоо	103
Хүснэгт 86. Стандарт алдааны тооцоо	103
Хүснэгт 87. Стандарт алдааны тооцоо	104
Хүснэгт 88. Стандарт алдааны тооцоо	105
Хүснэгт 89. Стандарт алдааны тооцоо	105
Хүснэгт 90. Стандарт алдааны тооцоо	106
Хүснэгт 91. Стандарт алдааны тооцоо	107
Зураг 1. Хүн амын насны бүтэц, 1979, 1989, 2000 оны ХАОСТ, АХС-ны дүнгээр	25
Зураг 2. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 15 ба түүнээс дээш насны хүн ам, зарцуулсан цагаар	35
Зураг 3. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, улирлаар	45
Зураг 4. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр	46
Зураг 5. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр	46
Зураг 6. 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхигүй хүн амын бүтэц, шалтгаанаар	47
Зураг 7. Ажиллагчдын тоо, улирлын тооцоогоор	52
Зураг 8. Тухайн үеийн ажиллагчдын ажил эрхлэлтийн байдлын бүтэц, хувиар	53
Зураг 9. Ажилгүйдлийн түвшин, улирлаар	62
Зураг 10. Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр	63
Зураг 11. Ажилгүйчүүдийн ажил хайгаагүй шалтгаан, бүтцээр	65
Зураг 12. 15, түүнээс дээш насны хүн амын тухайн үеийн болон байнгын эдийн засгийн идэвхийн хоорондох уялдаа, холбоо	73
Зураг 13. Албан бус секторт ажиллагчдын байршлын бүтэц, хувиар	81
Зураг 14. Албан бус секторт ажиллагчдын боловсролын түвшний бүтэц, хувиар	82
Зураг 15. 5-17 насны ажиллаж байгаа хүүхдийн дүнд эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллаар	88
Зураг 16. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, улирлаар	95
Зураг 17. Ажилгүйдлийн түвшингийн улирлын тооцоо, хүйсээр, хувиар	96
Зураг 18. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүн амын эдийн засгийн үйл ажиллагааны бүтэц, улирлаар	97



Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн он жилүүдэд хүн амын амьжиргааны түвшин, ажил эрхлэлт, амьдралын хэв маягт ихээхэн өөрчлөлт орж богино хугацаанд хувьсан өөрчлөгдөж байгааг дагалдан ажиллах хүч, ажил эрхлэлт, ажилгүйдлийн талаарх бодит мэдээллийн хэрэгцээ байнга өсөн нэмэгдэж байна.

Засаг захиргааны бүртгэлд үндэслэн нилэнхүй ажиглалтаар цуглуулдаг “Ажил эрхлэлтийн жилийн тайлан”, Хөдөлмөр эрхлэлтийн албадаар дамжин гардаг “Ажилгүйдлийн сарын” мэдээ, мэдээлэл цуглуулах давтамж зэрэг нь хөдөлмөр эрхлэлтийн олон хэв маягийн төлөв байдлыг бүрэн илэрхийлж хэрэглэгчдийн энэ талын мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг тэр бүр хангаж чадахгүй байснаас хүн амын ажиллах хүч, ажилгүйдлийн түвшинг тооцож тодорхойлох арга зүйг боловсронгуй болгох, түүнчлэн хүн амын ажил эрхлэлтийн хэв шинжийг бүрэн хамруулсан судалгааг улсын хэмжээнд явуулж, үнэн бодитой тоо баримттай болох, цаашдаа улирал, жилээр дээрх судалгааны тоо мэдээг хянаж тодотгох ажлыг байнга хийж байх шаардлага зүй ёсоор гарч ирсэн билээ.

Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны техник, санхүүгийн туслалцаатайгаар Монгол Улсын Үндэсний Статистикийн Газарт хэрэгжүүлсэн **“Нийгмийн статистикийг боловсронгуй болгох”** төслийн хүрээнд судлан шийдвэрлэхээр төлөвлөсөн олон талт арга хэмжээний нэн чухал бүрдэл хэсэг нь үндэсний хэмжээнд явуулсан **Ажиллах хүчний түүвэр судалгаа** байсан юм. Үг судалгааг 2002 оны 10 дугаар сард эхэлж нэг жилийн туршид явуулсан тайлангийн нэгдсэн үр дүнгийн талаар танилцуулж байгаадаа нэн таатай байна.


Нийгмийн статистикийн мэдээллийн цөм болсон ажиллах хүчний судалгаа (АХС) нь Монгол Улсын хувьд хүн амын ажил эрхлэлтийн талаар Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүн амын эдийн засгийн идэвхийг 2 арга/“тухайн үеийн” болон “байнгын” гэсэн/-аар тооцсон ажил эрхлэлтийн талаархи анхны томоохон түүвэр судалгаа юм. Энэхүү судалгаа нь хамрах хүрээ, багтаамж, агуулгаараа ч, тоо мэдээлэл нь бүтэн нэг жилийг хамарч улирлын нөлөөллийг бүрэн тусгасан жилийн дүнг гаргаж байгаагаараа ч, олон улсын аргачлалын дагуу хийснээрээ ч төр, засаг, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач нарт байнгын хэрэглэгдэхүүн болох ач холбогдол бүхий судалгаа болсон байна.

АХС нь хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжүүд болон ажилгүйдлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгч байгаагаараа нийгэм, иргэдийн амьдралд тулгарч байгаа хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд нэн ач холбогдол бүхий суурь, бодит мэдээллийн шинэ эх үүсвэрүүдийг илрүүлснээрээ ихээхэн ач холбогдолтой. Энэ нь зөвхөн шилжилтийн үеийн нэг хэсэг бэрхшээлийг шийдэх төдий бус улс орны хөгжлийн тулгуур асуудлыг шийдэх, цаашдын бодлогыг тодорхойлоход ч үндсэн мэдээлэл болж өгнө гэж үзэж байна. Мөн АХС-ны явцад албан бус секторын ажил эрхлэлтийн шинж төлөв, хандлагыг тодорхойлох зорилго тавьсан нь нүүдлийн болон суурин амьдралын хосолмол хэв шинжтэй манай орны хувьд сонирхол татахуйц, тэр бүр анхаарал төвлөрөхгүй явж ирсэн зарим асуудлын үр дагаварыг гүнзгийрүүлэн судлах боломжийг нээж өгч байгаа юм.

АХС-тай хамтруулан хүүхдийн хөдөлмөр эрхлэлт (ХХС)-ийн талаар улсын хэмжээнд анх удаа өргөн хэмжээний мэдээлэл цуглуулсан нь хүүхдийн эдийн засгийн идэвхи, хүүхдийн ажил, хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаархи мэдээллийн баялаг санг бүрдүүлж байгаагаараа онцлог юм.

Энэ удаагийн түүвэр судалгааны бас нэг онцлог нь Монгол хүний голлон эрхэлдэг ажил, орлого олдог эх үүсвэрийг илрүүлээд зогсохгүй хүний хүчин зүйлийн нөөц боломжийн ашиглалтын шалгуур үзүүлэлтийн түвшин ямархуу байгааг нарийвчлан тодорхойлсонд оршино.

Монгол орны хөдөлмөрийн статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулж боловсронгуй болгох, хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэх, хөдөлмөрийн холбогдолтой мэдээ, мэдээлэл, тайлангийн үзүүлэлтийн тогтолцоо, давтамж, арга зүйг боловсронгуй болгох, ажиллах хүчний ашиглалтын үр ашгийн шалгуур үзүүлэлтийг оновчтой зөв тооцож гаргадаг байх зэрэгт чиглэгдсэн олон дэвшилтэд санаа зөвлөмжүүдийг судалгааны үр дүнгээр дэвшүүлэн тавьсан байна. Энэ утгаар нь авч үзвэл, олон улсын арга зүйн дагуу хийгдсэн АХС, ХХС болон тэдгээрээр илрүүлэн гаргаж ирсэн дэвшилтэд санаа, зөвлөмж, шинэ мэдээллүүд нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, бизнес эрхлэгчид, шинжлэн судлаачид, төр захиргааны албаны ажилтан хэн бүхний ажил хэрэгт туйлын эрэлттэй, үнэ цэнэтэй гарын авлага, мэдээллийн эх сурвалж болон ашиглагдана гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна.


П.БЯМБАЦЭРЭН

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН ДАРГА



Азийн Хөгжлийн Банк болон Монгол Улсын Засгийн Газрын хооронд байгуулсан Хамтын Ажиллагааны Түншлэлийн Гэрээнд Монгол Улсын эдийн засаг өсч байгаа боловч ажлын байр, орлогын эх үүсвэрийн хомсдолын улмаас ядуурлын түвшин буурахгүй байгаа талаар дурьдагдсан байдаг билээ. Иймд хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай тоо мэдээний эрэлт хэрэгцээ, түүний нийгмийн ач холбогдол чухал болохыг харгалзан үзэж, Азийн Хөгжлийн Банк(АХБ)-ны дэмжлэгтэйгээр Монгол Улсын ҮСГ-т Нийгмийн Статистикийг Боловсронгуй Болгох 3684 Төсөл хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд түүний нэг үндсэн бүрдэл хэсэг болгон Ажиллах Хүчний Судалгаа(АХС)-г явуулахаар төлөвлөсөн юм.

Монгол Улс анх удаагаа АХС-г өрхөд суурилан нийт улсыг төлөөлөхүйц хэмжээнд явууллаа.

Ажиллах хүчний улирлын хэлбэлзлийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг 2002 оны 10-р сараас 2003 оны 9-р сарыг дуустал хугацааг хамруулан жилийн турш дөрвөн улирлаар явуулсан юм. Монголын ажиллах хүчний нэлээд хэсэг нь хөдөө аж ахуйн салбарт байгааг харгалзан асуулгыг боловсруулж, сүүлийн 7 хоногийн байдлаар буюу тухайн үеийн идэвхийн аргачлалаар, мөн сүүлийн 12 сарын байдлаар буюу байнгын идэвхийн аргачлалаар мэдээлэл цуглуулав. Улаанбаатар хот болон дөрвөн бус нутгийг хот, хөдөөгөөр нь ангилж нийт 12800 өрхийг хамруулсан АХС нь сүүлийн жилүүдэд ҮСГ-аас явуулсан судалгаануудаас цар хүрээ, хамралтын хувьд томоохонд тооцогдох ач холбогдолтой судалгаа болсон байна.

Судалгааны аргачлал, асуулгыг боловсруулах явцад хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгааны хэсгийг тусгайлан оруулж, улмаар Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага(ОУХБ)-аас санхүү, техникийн нэмэлт туслалцааг үзүүлсэн болно. АХБ нь энэхүү судалгааг амжилттай хэрэгжүүлэхэд ОУХБ-аас оруулсан хувь нэмрийг талархан тэмдэглэхийн сацуу энэ нь хоёр байгууллагын хооронд тогтоосон хамтын үйл ажиллагааны нэгэн тод жишээ боллоо гэж үзэж байна.

ҮСГ болон аймаг, дүүргийн статистикийн холбогдох ажилтнууд хүч чармайлтаа дайчлан, чин сэтгэлээс дэмжин ажиллаж байсны дүнд АХС амжилттай хэрэгжиж дууссаныг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ төслийн хэрэгжилтийг хянах, удирдан чиглүүлэхэд хамтран ажиллаж, ихээхэн дэмжлэг туслалцаа үзүүлж байсан ҮСГ-ын Дарга П.Бямбацэрэн болон ҮСГ-ын даргаар ажиллаж байсан Ч.Даваасүрэн нарт чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Түүнчлэн судалгааны түүвэр, аргачлалыг боловсруулах, судалгааны тоо мэдээнд дүн шинжилгээ хийх, тайлан боловсруулах хийгээд ҮСГ, түүний орон нутгийн статистикийн мэргэжилтнүүдийг ажиллах хүчний судалгааны чиглэлээр сургахад үнэтэй хувь нэмэр оруулсан АХБ-ны зөвлөх Ража Корале болон судалгаа, төслийн ажлыг хэрэгжүүлэх үйл явцыг зохицуулж байсан төслийн үндэсний зохицуулагч Б.Мөнхжаргалд талархал илэрхийлье.

Ажиллах хүчний судалгааны үндсэн тайланд зориулан өмнөх үгийг бичих энэхүү эрхэм завшааныг ашиглан 2004 оны 7-р сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо төрийн ордонд зохион байгуулсан судалгааны үндсэн үр дүнгийн тархаалтын семинарт Засгийн Газар, төрийн бус байгууллага, Олон улсын байгууллага болон судлаачдын хамт миний бие оролцох боломж олдсоныг тэмдэглэж хэлэхэд таатай байна. Монгол Улс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад нэн тэргүүний ач холбогдол өгч буй энэ үед АХС-ны үр дүн ихээхэн чухал ач холбогдолтой байх нь дамжиггүй юм. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, арга хэмжээг төлөвлөх, ядуурлын дүн шинжилгээ, хяналт үнэлгээ хийхэд шаардлагатай олон чухал тоо мэдээ, үзүүлэлт, баялаг агуулга бүхий мэдээллийн эх үүсвэрийг энэхүү тайланд багтаасан бөгөөд эдгээр мэдээлэл нь хэрэглэгч олон түмний эрэлт, хэрэгцээнд нийцнэ хэмээн найдаж байна.

БИШНУ ДЭВ ПАНТ
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, БОДЛОГЫН
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ СТАТИСТИКЧ

ТАЛАРХАЛ

Монгол Улсад 2002-2003 онд анх удаа “Ажиллах хүчний судалгаа”-г Хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгаатай хамтруулан улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон билээ. Судалгаагаар ажил эрхлэлт, бүрэн бус ажил эрхлэлт, ажилгүйдэл, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт зэрэг үзүүлэлтүүдийг бүс нутаг, байршил, нийгэм, эдийн засгийн ангиллаар өргөн хэмжээнд тооцон гаргахад шаардлагатай иж бүрэн тоо мэдээллийг цуглуулахад энэхүү судалгаа чиглэгдсэн. Судалгааны эцсийн зорилт нь ажил эрхлэлт болон нийгэм, эдийн засгийн бусад түүвэр судалгааг өрхөд суурилан явуулах үндэсний чадавхийг бий болгож, улс орны хөгжил, нийгмийн сайн сайхны төлөө бодлого, хөтөлбөр боловсруулахад судалгааны тоо мэдээллийг ашиглахад оршино.


Олон улсын практикт ажиллах хүчний ийм томоохон хэмжээний судалгааг ихээхэн хөрөнгө, хүн хүч, цаг хугацаа зарцуулан байж явуулдаг учир харьцангуй өртөг өндөртэйд тооцогддог байна. Нөгөө талаар мэргэжлийн өндөр ур чадвар шаардагддаг нь тодорхой юм. Улс орон бүхэн ч тэр бүрий ийм төрлийн томоохон судалгааг дангаараа хийгээд байж чаддаггүй ажээ.

Монгол улсын хувьд хөрөнгө санхүүгийн боломж хомсын дээр ийм төрлийн судалгаа явуулах мэдлэг, дадлага туршлага багатайн улмаас судалгаа явуулах хүсэл байсан ч бодит боломж огтхон ч байгаагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Ийм нөхцөлд системийн өөрчлөлт, шилжилтийн хүнд бэрхшээлтэй үеийн тулгамдсан олон асуудлуудын нэг болох Ажиллах хүчний судалгааг манай орны түүхэнд анх удаа олон улсын аргачлалаар үндэсний хэмжээнд явуулахад Азийн хөгжлийн банк техник, санхүүгийн туслалцаа үзүүлэхээр шийдвэрлэн уг судалгааг явуулах бэлтгэлийг хангах, судалгааны үйл ажиллагааны үе шат бүхэнд бидэнтэй ажил хэрэгчээр нягт хамтран ажиллаж, уян хатан зохицуулалтыг хийж, мэргэжлийн өндөр түвшний зөвлөгөө, арга зүйн удирдлагаар хангаж байсны үр дүнд төлөвлөсөн үндсэн болон хавсарга, туслах судалгаанууд бүхэлдээ амжилттай, үр дүнтэй хийгдэх нөхцлийг бүрдүүлсэн гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Энэхүү боломжийг ашиглан АХБ, түүний Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, АХБ-ны ахлах мэргэжилтэн Бишнү Дэв Пант, АХБ-ны ОУ-ын зөвлөх Ража Корале нарт чин сэтгэлийн гүн талархал илэрхийлж байна.

Түүнчлэн АХС-г баяжуулан хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгаа явуулах боломжийг бүрдүүлсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөрийн газарт талархаж байгаагаа илэрхийлье. Мөн энэхүү судалгааг гардан зохион байгуулан явуулах ачааны хүндийг үүрч санаачлагатай ажилласан ҮСГ-ын “Ажиллах хүчний судалгаа”-ны ажлын хэсгийн ахлагч Б.Даваахүү (ХАНСГ-ын ахлах мэргэжилтэн), ажлын хэсгийн гишүүд З.Нансалмаа, Н.Должинсүрэн, Ц.Гарьд, Д.Насандэлгэр, М.Лувсан болон төслийн зохицуулагч Б.Мөнхжаргал нарын хичээл зүтгэл ихээхэн хувь нэмэр оруулсан гэдгийг цохон тэмдэглэж байна. Судалгааны асуулга боловсруулах, тайлан бичих ажилд үнэтэй санал, зөвлөгөө өгч ажилласан судалгааны удирдлагын зөвлөлийн гишүүд, ҮСГ-ын даргын зөвлөлийн гишүүд болон судалгааг орон нутагт зохион байгуулах, мэдээллийг цуглуулах, боловсруулалтанд бэлтгэх ажилд идэвхи зүтгэлтэй оролцож, дэмжлэг үзүүлсэн төв, орон нутгийн статистикийн албадын нийт ажилтнууд, орон нутгийн засаг, захиргааны удирдлага, нийт хүмүүст талархал илэрхийлэхийг хүсч байна.

Судалгааны үр дүнг боловсруулан, тайланг хянан тохиолдуулах ажилд мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан Монгол Улсын гавьяат эдийн засагч, ахмад статистикч Р.Ойдовданзан, эдийн засгийн ухааны доктор (Ph) Ч.Дагвадорж нарт мөн талархал илэрхийлье.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.


П.БЯМБАЦЭРЭН


МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН ДАРГА

ҮСГ	Үндэсний статистикийн газар
ҮТС	Үндэсний тооцооны систем
АХС	Ажиллах хүчний судалгаа
АХБ	Азийн хөгжлийн банк
АХОТ	Ажиллах хүчний оролцооны түвшин
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ХХС	Хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгаа
ХХУОУХ	Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
ХАНСГ	Хүн ам, нийгмийн статистикийн газар
ХЭА	Хөдөлмөр эрхлэлтийн алба
ТАШН	Түүврийнн анхан шатны нэгж
ТХШН	Түүврийн хоёр дахь шатны нэгж
ТББ	Төрийн бус байгууллага
IMPS	Integrated Microcomputer Processing System (Мэдээлэл боловсруулах нэгдсэн систем)

Судалгааг явуулж мэдээлэл цуглуулсан хугацаа

Судалгааны 1 дүгээр улирал	2002 оны 10, 11, 12 сар
Судалгааны 2 дугаар улирал	2003 оны 1, 2, 3 сар
Судалгааны 3 дугаар улирал	2003 оны 4, 5, 6 сар
Судалгааны 4 дүгээр улирал	2003 оны 7, 8, 9 сар

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ЗУРАГ, БҮСЭЭР



б ү л э г 1

ЕРӨНХИЙ ТОЙМ



Бүлэг 1

ЕРӨНХИЙ ТОЙМ

Нийтлэг зүйл

1.1 Монгол Улсад анх удаа Ажиллах Хүчний Судалгаа (АХС) -г түүврийн аргаар явуулж, хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлтүүдийг улирлаар тооцсон үр дүнг танилцуулж байна.

1.2 АХС-г ажиллах хүчний улирлын хэлбэлзлийг судлах зорилгоор 2002-2003 оны 4 улирлыг хамруулан хоёр шатлалт, санамсаргүй түүврийн аргыг ашигласан нь Улсын Их Хурлаас баталсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Улаанбаатар хот болон 4 бүс нутгаар (хот, хөдөөгөөр) бүлэглэлт хийж, нийт 9 бүлгээр үр дүнг тооцох боломжтой болсон юм. Судалгааны нэг улиралд 3,200 өрх, нийт 12,000 гаруй өрхийн гишүүдийг түүвэрлэн сонгосон нь ажиллах хүчний үндсэн үзүүлэлтүүдийг жилийн дөрвөн улирлаар статистикийн аргачлалаар бодитой тооцоход хангалттай түүврийн хэмжээ байв. Хүн амын дийлэнх нь мал аж ахуй болон газар тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж буй нөхцөл байдлыг харгалзан үзэж ажиллах хүчний талаарх мэдээллийг судалгааны өмнөх сүүлийн 7 хоног буюу "тухайн үеийн идэвхи", сүүлийн 12 сар буюу "байнгын идэвхи"-ийн аргачлал, тодорхойлолтоор цуглуулав.

1.3 Судалгаанд нийт 12,800 өрх сонгогдсоноос 12,787 өрх судалгаанд хамрагдаж, хамрагдалтын түвшин 99,9 хувьтай гарав. Судалгаанд нийтдээ 49,948 хүн хамрагдаж асуулганд хариулсан.

1.4 Судалгааны мэдээллийг 2002 оны 10 дугаар сараас 2003 оны 9 дүгээр сарыг дуустал хугацаанд 4 улирлаар цуглуулав. Судалгааны эхний буюу 1 дүгээр улиралд 2002 оны 10-12-р сар, судалгааны 2 дугаар улиралд 2003 оны 1-3-р сар, судалгааны 3 дугаар улиралд 2003 оны 4-6-р сар, харин судалгааны сүүлийн буюу 4 дүгээр улиралд 2003 оны 7-9-р сарууд хамрагдсан болно.

Тайлангийн бүтэц

1.5 Тайлангийн бүтцийг танилцуулбал Бүлэг 2-т судалгааны аргачлал, зохион байгуулалтын талаар, Бүлэг 3-т Монголын хүн ам зүйн гол үзүүлэлтүүдийг, Бүлэг 4-т хүн амын сүүлийн 7 хоногт эрхэлсэн үйл ажиллагаа буюу эдийн засгийн болон

эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь оролцоо, Бүлэг 5-д сүүлийн 7 хоногийн байдлаар ажиллах хүчний үзүүлэлтүүдийг тооцсоныг, Бүлэг 6-д хүн амын ажил эрхлэлтийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлийн ангиллаар болон бүрэн бус ажил эрхлэлт, давхар ажил эрхлэлтийг тооцсоныг, Бүлэг 7-д ажилгүйдлийг нарийвчлан тооцож, гол үр дүнг танилцуулсныг, Бүлэг 8-д хүн амын байнгын идэвхитэй, идэвхигүй байдлыг сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн идэвхийн байдалтай харьцуулсан үзүүлэлтүүдийг, Бүлэг 9-д албан бус секторын тодорхойлолт болон албан бус сектор дахь хөдөлмөр эрхлэлтийг сүүлийн 7 хоногийн байдлаар тооцон байршил, насны бүлэг, ажил мэргэжлээр харуулсныг, Бүлэг 10-д хүүхдийн эдийн засгийн идэвхи, хүүхдийн хөдөлмөрийн талаар, Бүлэг 11-д ажиллах хүчний үндсэн үзүүлэлтүүдийг 4 улирлаар тооцож, ажиллах хүчний улирлын хэлбэлзлийн үр дүнг, Бүлэг 12-д улсын хэмжээнд болон бүс нутаг, хот, хөдөөгийн түвшинд ажиллах хүчний хэд хэдэн үзүүлэлтээр түүврийн алдааг тооцсоныг тус тус танилцуулав.

1.6 Энэ тайлангийн дүнг ашиглах, бусад судалгаа, тоо мэдээтэй харьцуулахдаа Судалгааны аргачлал, зохион байгуулалт гэсэн 2-р бүлэг дэх судалгааны хамрах хүрээ болон Хавсралт 2-д танилцуулсан ойлголт, тодорхойлолтыг ашиглах нь зүйтэй.

СУДАЛГААНЫ ТОВЧ ДҮН

Хүн ам зүйн үзүүлэлтүүд

1.7 2002-2003 оны АХС-ны түүврийн тархаалтын тооцоогоор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй иргэдийг оруулаад Монгол Улсын нийт хүн ам 2.4 сая байв. Энэ тооцоонд дотуур байр, эмнэлэг, цэргийн хуаран, засан хүмүүжүүлэх газар зэрэг нийтийн байранд байгаа хүмүүсийг хамруулаагүй болно.

1.8 Хүн амын 30.9 хувийг 0-14 насны хүүхэд, 65.3 хувийг 15-64 насны, 3.8 хувийг 65 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байлаа. 15 хүртэлх насны хүн ам болон 65, түүнээс дээш насны хүн амын нийлбэрийг 15-64 насны хүн амд

харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг хүн ам зүйн ачаалал нь 53,3 хувьтай байна.

1.9 Монголын эмэгтэй хүн амын тоо эрэгтэй хүн амынхаас илүү байна. 100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүний тоо буюу хүйсийн харьцаа улсын хэмжээнд 98.5 хувь, хотод 95.8 хувьтай байна. Харин хөдөөд 101.9 хувь буюу эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс илүү байна.

1.10 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 56.2 хувь нь гэрлэсэн, 33.3 хувь нь огт гэрлээгүй, 6.7 хувь нь бэлбэсэн байна. Эрэгтэйчүүдтэй харьцуулахад бэлбэсэн эмэгтэйчүүдийн тоо улсын хэмжээнд өндөр байгаа бөгөөд ийм дүр төрх хот, хөдөөд төстэй байна.

1.11 Судалгааны дүнгээр улсын хэмжээнд нийт 568,800 өрх байгаа бөгөөд өрхийн ам бүлийн дундаж тоо 4.2 байна. Хот, суурин газар болон Улаанбаатар хотын өрхийн ам бүлийн дундаж тоо нь бусад 4 бүс нутгаас харьцангуй доогуур байна. Өрхийн ам бүлийн дундаж тоонд 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг оруулж тооцсон бөгөөд өрхийн ам бүлийн дундаж тоо бүс нутгаар 3.9(Улаанбаатар хот) - 4.8(Баруун бүс) –ын хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт 15-ыг үзнэ үү).

1.12 Манай улсын нийт өрхийн 16.4 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн ам бүлийн тоо цөөхөн, нэг ам бүлтэй хоёр өрхийн нэг, 2 ам бүлтэй гурван өрхийн нэгийг нь эмэгтэйчүүд тэргүүлж байна.

1.13 Судалгааны түүврийн тархаалтаар 7-19 насны 689,800 хүүхдийн 79.0 хувь буюу 545,500 нь сургуульд суралцаж байна. Эдгээр насны эрэгтэй хүүхдүүдийн 76.7 хувь нь, эмэгтэй хүүхдүүдийн 81.6 хувь нь сургуульд хамрагджээ. Бүх насанд эмэгтэй хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин эрэгтэй хүүхдийнхээс өндөр байна. Хөдөөгийн хөвгүүдийн

сургуульд хамрагдалт 10 насандаа охидынхоос 4 пунктээр доогуур байсан бол 16 насанд энэ ялгаа 14 пункт болж өсчээ.

1.14 Бичиг үсгийн мэдлэгийн хувь өндөр, хүн амын (15 ба түүнээс дээш насны) 97.0 хувь нь бичиг үсэгт тайлагдсан байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин хот, хөдөөд аль алинд нь ойролцоо байна. Тухайн үеийн эдийн засгийн идэвхитэй болон идэвхигүй хүн ам

1.15 Ажиллах хүч буюу 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо судалгааны дүнг тархаасан тооцоогоор 1,004,800 байгаагаас 52.1 хувь нь буюу 523,500 нь эрэгтэй, 47.9 хувь буюу 481,300 нь эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн идэвхитэй хүн амыг ажил эрхэлж байгаа болон ажилгүй, ажил хайж буй хүмүүс бүрдүүлдэг. Ажиллах хүч дөрвөн улирлаар бага зэрэг хэлбэлзсэн нь түүврийн алдааны тооцооноос хамааралтай байж болох юм.

1.16 Ажиллах хүчний оролцооны түвшин /АХОТ/-г хөдөлмөрийн насны нийт хүн амд эдийн засгийн идэвхитэй хүн амын эзлэх хувиар тодорхойлдог. АХОТ нь улсын хэмжээнд 65.3 хувь, хотод 56,0 хувь байгаа бөгөөд харин хөдөөд үүнээс нэлээд өндөр 76,0 хувьтай байна. Хот, суурин газарт сургуульд хамрагдалтын түвшин хөдөө орон нутгийнхаас өндөр байгаатай холбоотой юм.

1.17 15 ба түүнээс дээш насны 1,539,200 хүний 34.7 хувь буюу 534,400 нь эдийн засгийн идэвхигүй бүлэглэлд багтаж байгаагийн 227,400 нь эрэгтэйчүүд, 307,000 нь эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн идэвхигүй хүн амаас 207,000 нь суралцаж байгаа, 152,000 нь өндөр настан, тэтгэврийнхэн, 54,300 нь гэрийн ажилтай, 27,000 нь тахир дутуу хүмүүс, 24,500 нь хүүхэд асарч байгаа ба 15,300 нь өвчтэй, 11,800 нь ажил хийхийг хүсээгүй, 5,900 нь хөдөлмөрийн нас хүрээгүй буюу 15 настай, бусад шалтгаантай 36,600 хүн байна.

Эдийн засгийн байдал	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
		2002.X-2003.IX	X – XII сар	I – III сар	IV – VI сар
Ажиллах хүч	1,004,800	1,002,600	986,800	1,020,000	1,014,100
Эрэгтэй	523,500	527,700	514,500	526,800	525,900
Эмэгтэй	481,300	474,900	472,300	493,200	488,200
АХОТ, %	65.3	66.6	65.1	64.9	65.0
Эрэгтэй	69.7	72.2	69.4	68.9	68.7
Эмэгтэй	61.1	61.4	60.9	61.0	61.4
АХОТ, %					
Хот	56.4	59.9	55.8	55.3	55.1
Хөдөө	76.3	75.1	77.1	76.8	76.8
Эдийн засгийн идэвхигүй хүн ам	534,400	502,200	529,300	552,400	546,100

Хүснэгт 1.

15 ба түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, хүйс, улирлаар

1.18 Судалгаагаар 1 дүгээр улиралд эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо 502,200 байснаа 3 дугаар улиралд 552,400 болсны шалтгаан нь нэг талаас ажиллах хүчний эрэлт хэрэгцээний улирлын өөрчлөлт нөгөө талаас тооцооны түүврийн алдаатай холбоотой юм.

1.19 Хөдөө орон нутагт эдийн засгийн идэвхи өндөр байгаа нь хөдөөгийн тухайн үеийн эдийн засгийн идэвхигүй хүн амын тоог багасгажээ. Өөрөөр хэлбэл хөдөө орон нутгийн эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо хот, суурин газрын эдийн засгийн идэвхигүй хүн амын хагаст нь ч хүрэхгүй доогуур байна. Хөдөө орон нутагт АХОТ хотынхоос өндөр байгаа нь өрхийн аж ахуйд суурилсан нүүдлийн мал аж ахуйн онцлог, мөн сургууль боловсролын үйлчилгээний хүртээмж харьцангуй бага байдагтай холбоотой байж болох юм.

Тухайн үед ажил эрхэлсэн хүн ам

1.20 Тухайн үед ажил эрхэлсэн нийт 897,100 хүн байгаагийн дотор 34,600 нь өөрийн гэр орондоо түр эзгүй байгаа гишүүд байна.

1.21 Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тооцоог хийхдээ сургуулийн дотуур байр, цэргийн хуаран, эмнэлэг зэрэг нийтийн байранд амьдрагчдыг хамруулаагүй. Хүн ам орон, сууцны 2000 оны тооллогоор 779.1 мянган хүн ажил эрхэлж байна гэж тоологдсон бол 2003 оны Ажил эрхлэлтийн жилийн тайлангаар 926.5 мянган хүн ажил эрхэлж байна гэсэн дүн гарчээ.

Сонгосон үзүүлэлтүүд	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	2002.X-2003.IX	X - XII	I - III	IV - VI	VII-IX
Тухайн үеийн ажиллагчдын тоо	862,500	822,300	838,700	885,600	906,000
Эрэгтэй	448,900	433,900	435,000	455,900	471,000
Эмэгтэй	413,600	388,400	403,700	429,700	435,000
Хот	392,300	393,700	384,700	393,500	395,900
Хөдөө	470,200	428,600	454,000	492,100	510,100
Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар					
Хөдөө аж ахуй	402,700	363,300	382,100	424,500	445,400
Үйлдвэрлэл	102,900	106,300	102,800	98,100	104,100
Үйлчилгээ	356,900	352,700	353,800	363,000	356,500
Ажил эрхлэлтийн байдлаар					
Гэрээгээр ажиллагч	338,600	350,000	343,400	339,400	321,800
Ажил олгогч	5,500	5,400	6,100	5,600	5,000
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	303,400	271,600	276,100	313,900	350,500
Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	215,000	195,300	213,100	226,700	228,700
Давхар ажил эрхлэлт – бүгд	23,900	24,700	21,100	24,000	27,200
Эрэгтэй	14,600	14,100	13,400	14,100	17,600
Эмэгтэй	16,300	10,800	13,900	17,800	24,300
Бүрэн бус ажил эрхлэлт – бүгд	58,200	78,500	53,100	58,900	42,400
Эрэгтэй	34,400	46,100	30,700	37,000	23,900
Эмэгтэй	23,800	32,400	22,400	21,900	18,500

Хүснэгт 2.

15 ба түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлт, сонгосон үзүүлэлтүүдээр, улирлаар

Улирлын хэлбэлзэл

1.22 Судалгааны 1 дүгээр улиралд 822,300 хүн ажил хийсэн бол 4 дүгээр улирал буюу 7-9-р сард энэ тоо 83,700-гаар өсч, 906,000-д хүрсэн нь хөдөө орон нутагт ажил эрхэлсэн хүний тоо нэмэгдсэнтэй холбоотой. Хүснэгт 2-оос харахад судалгааны 1 дүгээр улиралд хөдөө орон нутагт 428,600 хүн ажиллаж байсан бол 4 дүгээр улиралд 510,100 болж нэмэгдсэн байна.

1.23 Тухайн үед ажил эрхэлсэн нийт хүн амын 46.7 хувь буюу 402,700 /үүний 216,500 нь эрэгтэй, 186,200 нь эмэгтэй/ хүн хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллажээ.

1.24 Судалгааны 1 болон 4 дүгээр улирлын хооронд хөдөө аж ахуйн салбарт ажил эрхэлсэн хүн амын тоо 82 мянгаар

нэмэгдэж байгаа нь судалгааны 4 дүгээр улирал буюу 7-9-р саруудад манай орны хувьд хөдөө аж ахуйн салбар дахь эдийн засгийн үйл ажиллагаа (мал аж ахуй, газар тариалан, ойн аж ахуйн холбогдолтой) өргөжих таатай боломж бүрдэж, өвлийн улирлаас зун, намрын улирлын хүн амын ажил эрхлэлтийн хэлбэлзэл их байгааг харуулж байна. Хүснэгт 2-оос харахад үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажил эрхлэлтийн улирлын хэлбэлзэл нэг их ажиглагдахгүй байна.

1.25 Ажил эрхэлсэн хүн амыг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд нийт ажиллагчдын 45.0 хувь буюу 392,000 нь хөдөө аж ахуйн ажилчид, 12.0 хувь буюу 103,300 нь мэргэжилтэн, 3.9 хувь буюу 33,300 нь хууль тогтоогч, удирдах ажилтан болон менежер байна.

1.26 Тухайн үеийн ажиллагчдын 39,3 хувийг гэрээгээр ажиллагчид, 35,0 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 24,8 хувийг өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчид эзэлж байна. Хоршооллын гишүүд болон ажил олгогчид дөнгөж 0.2-0,6 хувийг эзэлж байна. Тухайн үед өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын ихэнх нь буюу 61.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

1.27 Нийт ажил эрхлэгчдийн дөнгөж 3.0 хувь нь давхар ажил хийжээ. Давхар ажил хийх эрэлт хэрэгцээ улирлаар бараг хэлбэлзэхгүй байгаа бөгөөд судалгааны 2 дугаар улиралд 21,100 хүн, 4 дүгээр улиралд 27,200 хүн давхар ажил эрхэлсний дээр хоёр хүн тутмын нэг нь хөдөө аж ахуйн болон үйлчилгээ, худалдаа наймааны ажил хийжээ.

1.28 Эндээс харахад давхар ажил эрхлэх эрэлт хэрэгцээ, бололцоо хязгаарлагдмал байгаа бөгөөд ажил эрхлэлтээс олох орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй. Гэхдээ ажиллах хүчний нийлүүлэлт эрэлтээсээ их хэмжээгээр давж байгаа нөхцөлд давхар ажил хөдөлмөр эрхлүүлэх замаар нэг хүний орлогыг нэмэгдүүлэхээс илүү бүх нийтийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж нийт хүний орлогыг нэмэгдүүлэх бодлого зохистой байдаг тал бий.

1.29 Тухайн хугацаанд нэмэлт ажил хайж байгаа болон нэмэгдэл ажил эрхлэх боломжтой гэсэн 58,200 хүн байна. Ийм ажил хийж буй 100 хүний долоо нь л нэмэлт ажил хийх

боломжтой, тийм хүсэлтэй байгаа юм. Эдгээр хүний 18,000 нь буюу гурван хүн тутмын нэг нь хөдөлмөрийн болон иргэний гэрээгээр ажиллагчид байна.

Ажил эрхлээгүй хүн ам

1.30 Судалгааны дүнг тархаасан тооцоогоор 142,300 хүн ажил эрхлээгүй байгаагийн 74,600 нь эрэгтэй, 67,700 нь эмэгтэйчүүд байна. Судалгааны хугацаанд ажилгүйдлийн түвшин 14.2 хувьтай байгаа бөгөөд хүйсээр задлан харвал эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 14.2 хувь, эмэгтэйчүүдийнх 14.1 хувь байна (Хүснэгт 3-ыг харна уу). Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор ажилгүйдлийн тоо 164,900 байсан бөгөөд ажилгүйдлийн түвшин улсын дунджаар 17.5 хувь байв.

1.31 Ажил эрхлээгүй хүн амын тоо хот, хөдөөгөөр ялгаатай байна. Ажил эрхлээгүй хүн амаар тооцсон ажилгүйдлийн түвшин хот, суурин газарт өндөр байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн хувьд 19.3 хувь, эмэгтэйчүүдийн хувьд 18.1 хувь байгаа бол харин хөдөө орон нутагт энэ үзүүлэлт 9,7 болон 10,3 хувьтай байна.

1.32 Ажиллах хүчний эрэлт, хэрэгцээ улирлаар хэлбэлзэж байгаатай холбоотойгоор ажилгүйдлийн түвшин судалгааны 1 дүгээр улиралд 18.0 хувьтай байснаа 4 дүгээр улиралд /7-9 саруудад/ буурч 10,7 хувь болсон байна.

Сонгосон үзүүлэлтүүд	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
Ажилгүйдлийн тоо	142,300	180,300	148,100	134,400	108,100
Эрэгтэй	74,600	93,800	79,500	70,900	54,900
Эмэгтэй	67,700	86,500	68,600	63,500	53,200
Ажилгүйдлийн түвшин, %	14.2	18.0	15.0	13.2	10.7
Эрэгтэй	14.2	17.8	15.4	13.5	10.4
Эмэгтэй	14.1	18.2	14.5	12.9	10.9
Хот	18.7	22.0	19.4	18.3	15.1
Хөдөө	10.0	14.0	10.8	8.6	6.9

Хүснэгт 3.

15 ба түүнээс дээш насны хүн амын ажилгүйдэл, сонгосон үзүүлэлтүүдээр, улирлаар

1.33 Ажил эрхлээгүй хүн амыг насны бүтцээр нь харахад ихэвчлэн залуу хүмүүс, ялангуяа ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орогчид ажилгүйдэлд илүү өртөж байна. Нийт ажил эрхлээгүй хүн амын 57.4 хувь нь 15-34 насныхан, 18.4 хувь нь ажиллах хүчинд шинээр элсэн орсон 20-24 насныхан байв.

1.34 Таван ажил эрхлээгүй хүний бараг гурав нь 1 сар хүртэлх хугацаанд ажилгүй байсан байна. Ажил эрхлээгүй хүн амын 22.8 хувь буюу бараг дөрөвний нэг нь 3 болон түүнээс дээш жилийн хугацаагаар ажил хийгээгүй байна.

1.35 Судалгааны тархаалтын тооцоогоор нийт ажилгүйдлийн дөрвөн хүний нэг нь тусгай мэргэжлийн

дунд/бүрэн бус дээд/-аас дээш боловсролтой хүмүүс байна. Ажилгүй хүн амын ердөө 9.0 хувь нь боловсролгүй буюу бага боловсрол эзэмшсэн хүмүүс байна.

1.36 Ажил эрхлээгүй хүмүүсээс ямар ажил хийхийг хүсч байна гэсэн асуулт асууж, үр дүнг тооцон үзэхэд ажлын байр болон ажил хийх хүсэлтэй хүмүүсийн сонирхол, сонголт хоёрын хооронд зөрүү их байна. Ажиллах хүчний 47.0 хувийг шингээж байгаа хөдөө аж ахуйн салбарт ажилгүйдлийн зөвхөн 4.1 хувь нь ажил хийхийг хүсч байгаа нь хүмүүсийн боловсролын түвшин нэмэгдэж, тэдний хүсэл, эрмэлзэл өөрчлөгдсөнийг илтгэсэн байна.

1.37 Арван хүний нэг нь хууль тогтоогч, удирдах ажилтан, менежер болон мэргэжилтэн хийх ажил мэргэжлийг сонирхож байхад, бараг таван хүний нэг нь үйлчилгээ, худалдаа эрхлэх ажил хайсан байна. Ажил хайсан эрэгтэй хүмүүсийн 61.2 хувь нь үйлдвэр, худалдааны ажилтан, машин тоног, төхөөрөмжийн операторч, угсрагчийн ажил хайжээ. Эндээс харахад дийлэнх ажлын байрыг хангаж буй ХАА-н салбарт ажлын орон тоо гарлаа ч энэ нь ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орогчдын сонирхол, эрмэлзэлтэй нийцэхгүй байх төлөвтэй байна.

Байнгын идэвхитэй хүн ам

1.38 Ажиллах хүчний эрэлт хэрэгцээ, хангамжийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй болохын тулд хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 12 сараар хэмжиж тооцов. Эдийн засагт хөдөө аж ахуй, албан бус сектор зонхилж, ажил эрхлэлт нь улирлын чанартай хэлбэлзэж буй нөхцөлд эдийн засгийн идэвхийг сүүлийн 12 сараар хэмжиж тооцох нь ажил эрхлэлтийн байдлыг бодитойгоор тодорхойлоход нэн чухал ач холбогдолтой арга юм.

1.39 Сүүлийн 12 сарын байдлаар буую байнгын идэвхитэй хүн амын ойлголт, аргачлалаар авч үзвэл ажилтай болон ажилгүй хүн амын тоо буурсан нь эдийн засгийн байнгын идэвхийг хүн амын тоог нэмэгдэхэд хүргэжээ.

1.40 Эдийн засгийн байнгын идэвхитэй хүн амын ойлголт, аргачлалаар тооцсон АХОТ 61.2 хувь болж, тухайн үеийн эдийн засгийн идэвхийг тооцсон түвшингээс 4 пунктээр доогуур гарч байна.

1.41 Тухайн үеийн эдийн засгийн идэвхитэй 862,500 хүн ажилтай гэж тооцогдсон бол байнгын идэвхитэй хүн амын тоо бага зэрэг буурч 856,600 болсон. Харин ажил эрхлээгүй хүн амын тоо үлэмж буурч, тухайн үеийн эдийн засгийн идэвхийн аргачлалаар 14.2 хувьтай байсан ажилгүйдлийн түвшин байнгын эдийн засгийн идэвхийн аргачлалаар 9.0 хувьтай байна. (Хүснэгт 4-ийг харна уу).

1.42 Судалгааны 1 дүгээр улиралд ажилгүйчүүдийн тоо 119,100 байсан бол 4 дүгээр улиралд 61,900 болж буурчээ. Судалгааны 4 дүгээр улиралын дүн нь тухайн үеийн идэвхийн аргачлалаар ажилгүй гэж тодорхойлогдсон 108,100 хүний 57.0 хувьтай л тэнцэж байгаа юм.

1.43 Тухайн үеийн болон байнгын эдийн засгийн идэвхийг хооронд нь харьцуулан үзэхэд дийлэнх хүмүүсийн хувьд өөрчлөлт ороогүй байна. Тухайлбал, тухайн үеийн эдийн засгийн идэвхийн аргачлалаар 142,300 хүн ажилгүй гэж тодорхойлогдсон бол эдийн засгийн байнгын идэвхийн аргачлалаар эдгээр хүмүүсийн 73,200 хүнийг ажилгүй, 10,700 хүнийг ажилтай, 58,400 хүнийг эдийн засгийн идэвхийг гэж тодорхойлсон байна.

	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
Байнгын идэвхитэй хүн амын тоо	941,500	946,300	914,600	959,800	948,900
Ажиллагчид	856,600	827,200	836,000	877,600	887,000
Ажилгүйчүүд	84,900	119,100	78,600	82,200	61,900
Байнгын идэвхигүй хүн амын тоо	597,800	558,500	601,500	612,600	611,300
Байнгын идэвхитэй хүн амын АХОТ, %	61.2	62.9	60.3	61	60.8
Эрэгтэй	65.5	68.7	64.1	65.2	64.5
Эмэгтэй	57.0	57.4	56.7	57.1	57.2
Байнгын идэвхитэй хүн амын ажилгүйдлийн түвшин, %	9.0	12.6	8.6	8.6	6.5
Эрэгтэй	9.2	12.7	8.6	9.2	6.4
Эмэгтэй	8.8	12.4	8.6	7.9	6.6
Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар					
Хөдөө аж ахуй	396,800	365,100	381,900	416,800	426,900
Үйлдвэрлэл	103,500	108,900	103,300	98,300	103,300
Үйлчилгээ	356,300	353,200	350,800	362,500	356,800
Ажиллагчдын тоо, ажил эрхлэлтийн байдлаар					
Гэрээгээр ажиллагч	340,400	354,200	343,700	338,000	325,900
Ажил олгогч	8,100	12,200	7,900	7,100	4,900
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	281,400	232,700	246,400	306,900	339,400
Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	226,700	228,100	238,000	225,600	216,800

Хүснэгт 4.

Байнгын идэвхитэй 15 ба түүнээс насны хүн амын ажил эрхлэлт, сонгосон үзүүлэлтүүдээр, улирлаар

1.44 Эдийн засгийн байнгын идэвхийн аргачлалаар буюу сүүлийн 12 сарын ажил эрхлэлт болон ажилгүйдлийн улирлын хэлбэлзэл тухайн үеийн эдийн засгийн идэвхийн аргачлалтай буюу сүүлийн 7 хоногийнхтой харьцуулахад бага байна. Сүүлийн 7 хоногт ажил эрхлэгчдийн тоо судалгааны 1-4 дүгээр улирлын хооронд 83,700-аар хэлбэлзэж байсан бол сүүлийн 12 сард ажил эрхлэгчдийнх 59,800 байна. Ажил эрхлээгүй хүн амын хэлбэлзэл ч гэсэн сүүлийн 7 хоногийнхтой харьцуулахад (72,200) доогуур (57,200) байна.

Тухайн үеийн эдийн засгийн үйл ажиллагаа

1.45 15 ба түүнээс дээш насны 800,500 хүн судалгааны өмнөх сүүлийн 7 хоногт ажил хийсэн буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлжээ. Судалгааны 1 дүгээр улиралд

эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүний тоо 748,200 байснаа 2 дугаар улиралд нэмэгдэн 761,700 болж, 4 дүгээр улиралд бүр өсч 856,200 болжээ (5-р хүснэгтийг харна уу). Ийнхүү өвөл, зуны улирлын хооронд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүмүүсийн тоо 108,000 хүнээр буюу 14.4 хувиар өсчээ.

1.46 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүний тоо өсөхөд цалин хөлстэй ажил хамааралгүй байгаа бөгөөд харин ч цалин хөлстэй ажил эрхлэгчдийн тоо судалгааны 4 дүгээр улиралд буурсан байна. ХАА-н салбараас бусад салбарт хувиараа хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн тоо судалгааны 1 болон 4 дүгээр улирлын хооронд 12,600 хүнээр нэмэгдсэн. Гэхдээ түүний нийт дүнд эзлэх хувийн жин нь бага зэрэг буурсан байна.

	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
Цалин хөлстэй ажил	297,900	309,700	299,500	302,300	279,800
Хөдөө аж ахуй	385,900	326,100	355,900	420,900	445,600
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	135,000	138,000	119,600	133,700	147,600
Нийт	800,500	748,200	761,700	838,900	856,200
Цалин хөлстэй ажил	37.2	41.4	39.3	36.0	32.7
Хөдөө аж ахуй	48.2	43.6	46.7	50.2	52.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	16.9	18.4	15.7	15.9	17.2
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0

Хүснэгт 5.

Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, дүнд эзлэх хувь, улирлаар

1.47 Судалгааны 4 дүгээр улиралд ХАА-н салбарт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүний эзлэх хувь судалгааны 1 дүгээр улиралтай харьцуулахад 8.4 пунктээр өсч 52.0 хувь болсон нь энэ салбарын эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүний тоо 119,500 хүнээр нэмэгдсэнийг харуулж байна.

1.48 15 ба түүнээс дээш насны эрэгтэй, эмэгтэй хүмүүс долоо хоногт дунджаар 45.7 цагийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулжээ (Хүснэгт 6-г харна уу). Долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цагийн улирлын хэлбэлзэл бага байна. Судалгааны 1 дүгээр улиралд хамгийн бага буюу 44.2 цаг, 3 дугаар улиралд хамгийн их буюу 47.3 цаг зарцуулсан байна.

	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүний тоо	800,500	748,200	761,700	838,900	856,200
7 хоногт зарцуулсан дундаж цаг	45.7	44.2	45.1	47.3	45.9

Хүснэгт 6. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, улирлаар

1.49 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан дундаж цаг 20-54 насны бүх бүлэгт онцын ялгаагүй, долоо хоногт 44.8-47.8 цагийн хооронд хэлбэлзэж байна.

Эдийн засгийн бус үйл ажиллагаа

1.50 Хөдөөгийн хүн амтай харьцуулахад хотын хүн ам долоо хоногт 2 цагаар илүү ямар нэгэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн байна. Долоо хоногт эмэгтэйчүүд дунджаар 42.3 цаг ямар нэгэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлжээ.

1.51 Судалгааны хугацаанд 15 ба түүнээс дээш насны хүн амын 92.0 хувь буюу 1.419 мянган хүн хоол унд хийх, гэр орон цэвэрлэх, хүүхэд, өндөр настан, өвчтөн асрах зэрэг эдийн засгийн бус үйл ажиллагааг эрхэлжээ. Эдгээр хүмүүсийн 667,800 нь эрэгтэй, 751,400 нь эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн бус үйл ажиллагаанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэй оролцож байна.

1.52 Долоо хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэхэд улсын хэмжээнд дунджаар 25 цаг зарцуулсан байна (7-р хүснэгтийг харна уу). Эрэгтэйчүүд долоо хоногт дунджаар

17.5 цаг, эмэгтэйчүүд 31.8 цаг зарцуулжээ. Энэ нь цалин хөлсгүй ажилд эмэгтэйчүүд илүү олон цаг зарцуулж, жэндерийн тэгш бус байдал үүссэнийг харуулав.

	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн хүний тоо	1,419,200	1,379,700	1,399,500	1,442,900	1,451,300
7 хоногт зарцуулсан дундаж цаг	25.0	29.9	25.0	23.5	22.2

Хүснэгт 7. Сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, улирлаар

1.53 Өвлийн улиралд буюу 10-12-р саруудад өөрөөр хэлбэл судалгааны 1 дүгээр улиралд эдийн засгийн бус үйл ажиллагааг 1,379,700 хүн эрхэлж байсан бол намрын улирал буюу 7-9-р сард буюу судалгааны 4 дүгээр улиралд энэ тоо 71,600 хүнээр нэмэгдэж 1,451,300 болжээ. Ийнхүү ийм үйл ажиллагаа эрхэлсэн хүний тоо өвлийн улиралд хамгийн бага байсан ба дулааны улиралд өсч зун, намрын улиралд хамгийн их болсон байна.

1.54 Өвлийн цагт эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэхэд долоо хоногт дунджаар 29.9 цаг зарцуулсан бол хавар нь 25 цаг, зун, намар 22.2 цаг болж багассан нь энэ улиралд эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цаг нэмэгддэгтэй холбоотой.

Албан бус сектор

1.55 Хувиараа хөдөлмөр эрхлэгч, хувиараа эрхлэх аж ахуй, нөхөрлөлд ажиллаж буй хүмүүсийн 125,100 нь хөдөө аж ахуйн бус салбарт үндсэн ажил мэргэжлээрээ ажил эрхэлж байна. Үүнээс 114,500 нь орон тооны бус ажилчинтай буюу 1-4 ажилчинтай аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байна.

1.56 Орон тооны бус ажилчинтай буюу 1-4 ажилчинтай хувиараа хөдөлмөр эрхлэгч, хувиараа эрхлэх аж ахуй, нөхөрлөлд давхар ажил хийж буй хүмүүсийг албан бус секторт хамруулав. Энэ бүлэгт хамрагдах хүмүүсийн тоо 11,500 байна.

1.57 Албан бус секторт нийтдээ 126,000 хүн үндсэн болон давхар ажил эрхэлж байгаагийн 113,700 нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 11,200 нь хувиараа эрхлэх аж ахуйд, 1,100 нь нөхөрлөлд ажиллаж байна. Үндсэн болон давхар ажил эрхлэгчдийн 70.9 хувь буюу 89,300 нь хот, суурин газарт, 29.1 хувь буюу 36,700 нь хөдөө орон нутагт байна. Албан бус секторт үндсэн болон давхар ажил эрхэлсэн хүмүүсийн 55.2 хувь буюу 69,600 нь эрэгтэй, 44.8 хувь буюу 56,400 нь эмэгтэйчүүд байна.

1.58 Албан бус секторт ажил эрхлэгчдийн 44.9 хувь буюу 56,600 нь үйлчилгээ, дэлгүүр, зах зээл дээр худалдаа, наймааны чиглэлээр, 34.8 хувь буюу 43,900 нь үйлдвэр, худалдааны ажилтан болон машин, тоног төхөөрөмжийн оператор, угсрагчаар ажилласан байна. Энэ 2 ажил мэргэжлийн чиглэлээр ажиллагчид албан бус секторт ажиллагчдын 80.0 орчим хувийг бүрдүүлж байна.

		Бүгд		Албан бус сектор			
		Тоо	%	Эрэгтэй		Эмэгтэй	
				Тоо	%	Тоо	%
	Бүгд	126,000	100.0	69,500	55.2	56,400	44.8
ХАА-н бус	Үндсэн ажил	114,500	100.0	62,500	54.6	52,000	45.4
	Давхар ажил	11,500	100.0	7,100	61.5	4,400	38.5
ХЭАА	Үндсэн ажил	10,600	100.0	5,200	49.6	5,400	50.4
	Давхар ажил	600	100.0	400	69.0	200	31.0
Нөхөрлөл	Үндсэн ажил	900	100.0	400	46.0	500	54.0
	Давхар ажил	200	100.0	100	49.9	100	50.1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Үндсэн ажил	103,000	100.0	56,900	55.2	46,100	44.8
	Давхар ажил	10,700	100.0	6,600	61.3	4,100	38.7

Хүснэгт 8.

Сүүлийн 7 хоногт албан бус секторт ажилласан хүн амын тоо, байгууллагын төрөл, үндсэн болон давхар ажил эрхлэлтийн байдал, хүйсээр

1.59 Албан бус секторт ажиллагчдын 13,500 нь дээд боловсролтой, 17,400 нь тусгай мэргэжлийн дунд/бүрэн бус дээд боловсролтой, 11,500 нь техник мэргэжлийн анхан шатны, 46,500 нь бүрэн дунд, 29,200 нь бүрэн бус дунд, 6,400 нь бага боловсролтой, 1,500 нь боловсролгүй хүмүүс байна. Харин арван хүн тутмын гурав нь бүрэн бус дунд болон түүнээс доош боловсролтой хүмүүс байна.

Хүүхдийн эдийн засгийн идэвхи

1.60 Судалгааны дүнг тархаасан тооцоогоор 5-17 насны 679,000 хүүхэд байгаагийн 347,600 нь эрэгтэй, 331,400 нь эмэгтэй байна. Эдгээрээс 507,200 нь сургуульд суралцаж байна.

1.61 5-17 насны 171,200 хүүхэд /үүний 94,400 нь эрэгтэй, 76,800 нь эмэгтэй/ сургуульд суралцахгүй байгаагийн дотор 64.3 хувь буюу 110,100 нь сургуулийн өмнөх насны хүүхдүүд байна.

1.62 Сургуулийн насны хүүхдүүдээс өрхийн орлогод хувь нэмэр оруулах, мөн гэр орныхоо ажилд туслах зорилгоор 24,000, ном сурах бичиг, сургуулийн дүрэмт хувцас зэрэг сургалтын зардлыг төлөх чадваргүй гэсэн шалтгаанаар 8,300 хүүхэд сургууль завсарджээ. Өвчтэй, тахир дутуугийн улмаас сургуульд яваагүй гэж хариулсан хүүхдүүд 8,400, сургууль хол, сурах сонирхолгүй гэж хариулсан 14,100 хүүхэд, бусад шалтгаанаар сургууль завсардсан 6,300 хүүхэд байна.

1.63 5-17 насны 73,500 хүүхэд эдийн засгийн идэвхитэй байгаагийн 44,600 нь эрэгтэй, 28,900 нь эмэгтэй байна. Эдгээрийн 10,000 хүүхэд нь хот, суурин газарт, 63,500 нь хөдөө орон нутагт амьдарч байна.

1.64 Эдийн засгийн идэвхитэй 73,500 хүүхдээс 68,600 хүүхэд нь ажил эрхэлж, 4,900 хүүхэд нь ажил хайж байна. Ажил эрхэлж байгаа хүүхдүүдийн 41,900 нь эрэгтэй, 26,700 нь эмэгтэй хүүхдүүд байна. Эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдээс илүү олноороо ажил эрхэлж байна.

1.65 Сүүлийн 7 хоногт 5-9 насны 15,300 хүүхэд, 10-14 насны 21,400 хүүхэд, 15-17 насны 31900 хүүхэд тус тус ажил эрхэлсэн байна.

1.66 Ажил хийсэн хүүхдүүдийн 90.0 хувь буюу 61,700 нь өрхийн бизнест цалин хөлстэй оролцогч, 8.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд байна. Ийнхүү ажил хийсэн хүүхдүүдийн дийлэнх нь өрхийн аж ахуйд туслагчид байна.

1.67 Нийт 1,154 хүүхэд, үүнээс 575 эмэгтэй, 579 эрэгтэй хүүхэд цалин хөлстэй хөдөлмөр эрхэлсэн нь ажил хийж байгаа хүүхдийн 2 хувьд ч хүрэхгүй байна. 5-14 насны хүүхдүүдийн дунд цалин хөлстэй ажил эрхэлсэн тохиолдол гарсангүй.

1.68 Цалин хөлстэй ажлын байр хязгаарлагдмал, энэ талаар өрсөлдөөн их зэргээс хүүхдүүдэд цалин хөлстэй ажил олдохгүй байна.

1.69 Нийт ажил эрхэлсэн хүүхдүүдийн 90.8 хувьтай тэнцэх 62,200 хүүхэд (38,000 эрэгтэй, 24,200 эмэгтэй хүүхэд) хөдөө аж ахуйн болон түүний холбогдолтой ажил эрхэлж байна.

1.70 Ажил хийсэн хүүхдүүдийн 4.1 хувь нь үйлчилгээний болон дэлгүүр, зах зээл дээр худалдаа наймааны ажил эрхэлсэн байна.

1.71 5-17 насны нийт хүүхдийн 83.6 хувь болох 567,400 хүүхэд (285,500 эрэгтэй, 281,900 эмэгтэй) гэрийн ажилд оролцжээ. Гэрийн ажилд оролцсон дөрвөн хүүхэд тутмын гурав нь хоол унд хийх, аяга таваг угаах, гэр орон цэвэрлэх ажил хийж, таван хүүхэд тутмын нэг нь дэлгүүр хоршоо явж гэр орныхоо хэрэгцээт зүйлсийг худалдан авах ажил хийсэн байна. Гэрийн ажилд оролцсон хүүхдүүдийн 53.0 хувь нь ус авсан бол 46.7 хувь нь түлээ түлш бэлтгэх ажил хийжээ.

б ү л э г 2

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Бүлэг 2

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нийтлэг зүйл

2.1 Монгол Улсад анх удаа 2002-2003 онд “Ажиллах хүчний судалгаа” (АХС)-г Хүүхдийн хөдөлмөрийн талаархи хавсарга судалгаа (ХХХС)-тай хамтруулан явуулаа. ҮСГ-аас зохион байгуулж явуулсан энэхүү үндэсний хэмжээний томоохон түүвэр судалгаанд Монгол Улсын хот, хөдөөгийн 12 мянга гаруй өрх хамрагдсан бөгөөд хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгахын тулд уг судалгааг дөрвөн улирлаар явуулж, эхний улирлын мэдээллийг 2002 оны 10-12-р сард, сүүлчийн улирлынхыг 2003 оны 7-9-р сард цуглуулав. АХС нь Монгол Улсын хүн амын эдийн засгийн идэвхийг тодорхойлоход олон улсын нийтлэг ойлголт, тодорхойлолт, арга зүйг ашиглан явуулсан ажил эрхлэлтийн анхны түүвэр судалгаа болно.

2.2 АХС нь Монгол Улсад сүүлийн жилүүдэд явуулсан хэд хэдэн түүвэр судалгаа болон Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын үргэлжлэл болж, хөдөлмөр эрхлэлтийн талаар бодлого, хөтөлбөр боловсруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээ, төслүүдэд үнэлгээ дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх болон Монголын хүн амын ядуурлыг аажмаар бууруулж, түүнээс ангижруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай тоон мэдээ, мэдээллээр хангах үндсэн зорилгыг агуулсан. Азийн Хөгжлийн Банк (АХБ) болон Монгол Улсын Засгийн Газрын хооронд байгуулсан Ядуурлыг Бууруулах Түншлэлийн Гэрээнд “...ажлын орон тоо, орлогын эх үүсвэрийн хомсдол нь ядуурлын үндсэн шалтгаан болж байгааг” тэмдэглэсэн билээ.

2.3 1990 оноос эхэлсэн зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явц болон энэ үеэс төлөвлөн хэрэгжүүлж буй улс төр, эдийн засгийн шинэчлэл нь хуучин тогтолцооны үед харьцангуй сайн хөгжсөн нийгмийн үйлчилгээ, дэд бүтэцтэй, хүн ам нь боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд жигд хамрагдаж байсан Монгол орны хувьд нийгэм, эдийн засгийн гэнэтийн бөгөөд хүнд хэцүү үр дагаврыг авчирсан билээ. Шилжилтийн өнгөрсөн жилүүдэд ажилгүйдэл ихэсч, өрхийн амьжиргаа доройтож, хүүхдүүд олноороо хөдөлмөр эрхлэх болсноор сургуульд суралцагчдын тоо буурч, сургуульд хамрагдалтын түвшин

багассан юм. Үүнтэй зэрэгцэн нийгмийн хамгааллын систем доголдсон нь өрхүүдийн амьжиргаанд хүндээр тусч, улмаар өрхийн орлогын эх үүсвэрт нэмэр болох зорилгоор хөдөлмөр эрхлэгч хүүхдийн тоог нэмэгдүүлж байна. Ийнхүү ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлт, хүүхдийн хөдөлмөр зэрэг шилжилтийн үед гарч ирсэн нийгэм, эдийн засгийн сөрөг асуудалд Монгол Улсын Засгийн Газар анхаарал хандуулж, энэ талаарх тоо мэдээллийг бүрдүүлэх, холбогдох байгууллага, бодлого боловсруулагч нарыг шаардлагатай тоо мэдээллээр хангах зорилгоор судалгааг явуулсан болно.

2.4 Монгол улсын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаар үнэлгээ өгөх, бодлого боловсруулахад хэрэгцээтэй ажил эрхлэлт болон ажилгүйдлийн тодорхой тоон мэдээ, мэдээлэл зохих түвшинд хангалтгүй байгаа тул энэхүү судалгаа нь дээрх асуудалтай холбогдолтой мэдээллийн хоосон орон зайг нөхөхөд чиглэгдэж байна. Сүүлийн жилүүдэд хийгдсэн тооллого, судалгаа, ажил эрхлэлтийн жилийн тайлангийн ажил эрхлэлт, ажилгүйдлийн холбогдолтой үзүүлэлтүүдийг тооцсон аргачлал, заавар нь өөр байгаа учраас гарч байгаа үр дүн нь ялгаатай, хооронд нь шууд харьцуулах боломжгүй байгаа билээ. Харин энэ судалгаа нь дээрх ялгааг арилгаж, нэгдсэн аргачлалаар дэлгэрэнгүй тоо мэдээ гаргахад чухал хувь нэмэр болох юм. Энэ судалгаанаас гарах тоо мэдээ нь бодлого, төлөвлөлтөнд хэрэглэх мэдээллийн эх үүсвэр болохоос гадна Монгол Улсын үндэсний тооцооны системийн үнэлгээ тооцоо хийхэд ашиглагдах юм. АХС нь ажиллах хүчний холбогдолтой мэдээллийн сангийн эх суурийг бүрдүүлж, хүн амын ажиллах хүч, ажил эрхлэлт, ажилгүйдлийг насны бүлэг, хүйс, боловсролын түвшин, байршил, ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдлаар, мөн хүн амын үндсэн ажил эрхлэлт, давхар болон бүрэн бус ажил эрхлэлт, өмнөх үеийн ажил эрхлэлт, цалин, хөлстэй хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн цалин хөлсний талаарх мэдээллийг цуглуулсан. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаархи хавсарга судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ, тархалт, төлөв байдал, хөдөлмөр эрхэлж буй шалтгаан, үр дагаврын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж, эдгээр мэдээлэл нь хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй

болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг үнэн бодитойгоор тодорхойлон улмаар тэднийг хамгаалах, хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн богино болон урт хугацааны арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд чухал материал болох юм.

2.5 АХС -г Үндэсний Статистикийн Газарт хэрэгжиж байгаа “Нийгмийн статистикийг боловсронгуй болгох нь” (ТА:3684 MON) төслийн хүрээнд Азийн Хөгжлийн Банкны санхүү, техникийн дэмжлэгтэйгээр явууллаа. Түүнчлэн Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын дэргэдэх Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр (ХХУОУХ) нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаархи хавсарга судалгааны зардлыг санхүүжүүлсэн. Судалгааны бэлтгэл ажил 2002 оны 3 дугаар сараас эхэлсэн бөгөөд судалгааг удирдан зохион байгуулж явуулах зорилготойгоор “Ажиллах хүчний судалгаа”-ны ажлын хэсэг байгуулан ажиллав.

Судалгааны зорилго

2.6 АХС -ны үндсэн зорилго болон зорилтуудыг дор дурьдвал:

Үндсэн зорилго

2.7 Судалгааны үндсэн зорилго нь Монгол Улсад ядуурлыг аажмаар бууруулж, түүнээс ангижрахад чиглэсэн бодлого боловсруулах, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн талаар хөтөлбөр, арга хэмжээ боловсруулахад шаардлагатай хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлт, ашиглалт болон хүн амын ажил эрхлэлттэй холбоотой тоон мэдээллийг хот, хөдөөгийн өрхүүдээс цуглуулах явдал юм. Түүнчлэн ажил эрхлэлт, бүрэн бус ажил эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлтүүдийг бүс нутаг, байршил, нийгэм, эдийн засгийн ангиллаар өргөн хэмжээнд тооцон гаргахад шаардлагатай иж бүрэн тоо мэдээллийг цуглуулахад энэхүү судалгаа чиглэгдсэн. Судалгааны эцсийн зорилго нь ажил эрхлэлт болон нийгэм, эдийн засгийн бусад түүвэр судалгааг өрхөд суурилан явуулах үндэсний чадавхи бүрдүүлэх болон улс орны хөгжил, нийгмийн сайн сайхны төлөө бодлого, хөтөлбөр боловсруулахад дээрх судалгаануудын тоо мэдээг ашиглах явдлыг нэмэгдүүлэхэд оршино.

Тодорхой зорилтууд:

2.8 Үндсэн зорилгод хүрэхийн тулд дараах тодорхой зорилтуудыг тавьсан болно. Үүнд:

1. 5 ба түүнээс дээш насны хүн амын судалгааны өмнөх 7 хоногт буюу тухайн үед эрхэлсэн эдийн засгийн

болон эдийн засгийн бус үйл ажиллагааны талаарх мэдээллийг ажил эрхлэлтийн байдал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал зэрэг дэлгэрэнгүй үзүүлэлтээр гаргах;

2. Хүн амын байнгын идэвхийн талаарх мэдээллийг жилийн турш буюу сүүлийн 12 сарын байдлаар судалж, байнгын ажил эрхэлсэн, эрхлээгүй болон эдийн засгийн идэвхигүй байдлаар тодорхойлох;
3. Ажлын ур чадвар, өмнө эрхэлж байсан ажил, дадлага туршлага, ажилгүй байсан хугацаа, ирээдүйд хийхийг хүсч буй ажил мэргэжил, авахыг хүсч буй цалин хөлсний хэмжээний талаархи мэдээлэл цуглуулах;
4. 5-17 насны хүүхдийн эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа, гэрийн ажилд оролцож буй байдал, ажил эрхэлж эхэлсэн нас, өрхөөс гадуур ажил хийж байгаа эсэх, хийж буй ажлын улмаас өвдөж гэмтсэн эсэхийн талаархи мэдээлэл авах;
5. Үндэсний тооцооны системийн үнэлгээ тооцоо хийх болон хөдөлмөр эрхлэлт, боловсролын чиглэлээр хөтөлбөр, бодлого боловсруулахад ашиглах зорилгоор ажил эрхэлж буй хүмүүсийн ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдлын талаар мэдээлэл цуглуулах;
6. Цалин хөлстэй ажил эрхэлж буй хүмүүсийн цалин хөлс, орлогын хэмжээг судлах;

Судалгааны хамрах хүрээ

2.9 АХС-ны хамрах хүрээг ажиллах хүч, ажилгүйдлийн тоон мэдээллийн хоосон орон зайг нөхөх, тухайн үеийн тоо мэдээллийн хэрэгцээг хангахад чиглүүлэн явуулахаар төлөвлөсөн. Монгол Улсад ажиллах хүчний түүвэр судалгааг өмнө нь хийж байсангүй. Ажиллах хүч, ажил эрхлэлт, ажилгүйдлийн холбогдолтой мэдээллүүдийг хүн ам, орон сууцны болон аж ахуйн нэгж, байгууллагын тооллого, засаг захиргааны нэгжид үндэслэсэн статистикийн тайлан мэдээ, нийгэм, эдийн засгийн түүвэр судалгаанууд зэрэг олон төрлийн эх үүсвэрээр гарган авч байгаа юм. Эдгээр мэдээлэл нь өөр өөрийн эрэлт, хэрэгцээг хангах, тодорхойлох зорилготойгоор хийгдсэн, түүнчлэн судалгаанд хэрэглэгдсэн ажиллах хүч, ажилгүйдлийн үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолт ялгаатай тул үр дүн нь харилцан адилгүй гардаг. Иймд дээрх мэдээллийн зөрүүг арилгаж, үндсэн эх сурвалж судалгаанаас нэгдсэн мэдээлэл гаргаж авах нь нэн тэргүүний тулгамдсан зорилго болохын зэрэгцээ эдийн засгийн салбарууд төрөлжин олширч, боловсрол, сургалтын үйл ажиллагаа нэмэгдсэн боловч ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлт нь бодитойгоор оршин байгаа тул хөдөлмөр

эрхлэлтийн хэв шинжийг бүрэн хамруулсан тодорхой мэдээлэл бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн стратеги, хөтөлбөрийг боловсруулахад ашиглах зорилгоор АХС-г явуулах шаардлага бий болсон юм.

2.10 Иймд дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд энэхүү судалгааг байршлын хувьд Монгол Улсыг бүхэлд нь хамруулан өргөн цар хүрээнд явуулахаар төлөвлөж, хот, хөдөөгийн хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдэл, хүүхдийн хөдөлмөрийн талаарх бодитой тоо мэдээг цуглуулахад улсын хэмжээнд 4 бүс нутаг, Улаанбаатар хотын нийт 12,800 өрхөөс асуулга авахад хангалттай гэж үзсэн. Энэ нь хүн амын ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг бодитой тооцоход хангалттай төлөөлж чадах хүрээ болно гэж үзсэн.

2.11 Цалин хөлстэй ажил эрхэлж буй хүмүүсийн эзлэх хувь их биш буюу нийт ажиллах хүчний 40 орчим хувийг эзэлж байна. Ажиллах хүчний дийлэнх нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа тул байнгын идэвхийг тодорхойлох аргачлалыг ашиглах нь ажиллах хүчний байдлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж, ажиллах хүчний улирлын хэлбэлзлийг тодруулж болохын зэрэгцээ түүнийг боловсролын түвшинтэй уялдуулан илүү хэрэгтэй мэдээлэл гаргаж авах, бүрэн бус ажил эрхлэлтийн талаар тодорхой мэдээлэл цуглуулах зэрэг давуу талуудтай байгаа юм. Иймд энэ судалгаанд сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн идэвхийн аргачлалыг сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийг тодорхойлох аргачлалтай хослуулан ашиглалаа.

2.12 Ажиллах хүч, ажил эрхлэлт, ажилгүйдлийг нас, хүйс, боловсролын түвшин, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар судлахын зэрэгцээ үндсэн ажил, давхар ажил, бүрэн бус ажил эрхлэлт, өмнөх үеийн ажил эрхлэлт, цалин, хөлс, хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн эдийн засгийн идэвхийн талаарх мэдээллийг цуглуулахад чиглүүлэн судалгааны хамрах хүрээг тодорхойлов.

2.13 Судалгаа нь өрхөд суурилан явагдаж байгаа тул цэргийн хуаран, дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, сүм хийд зэрэг нийтийн байруудад түр амьдрагчид, байнгын орон гэргүй хүмүүсийг хамруулаагүй болно. Нийтийн байрууд нь байнгын оршин суух газарт тооцогддоггүйгээс гадна байнгын орон гэргүй хүмүүсийг тодруулан судалгаанд хамруулахад бэрхшээлтэй байдаг зэрэг шалтгаанаар өрхийн судалгаануудад хамруулдаггүй.

Судалгааны хугацаа

2.14 Энэ судалгаа нь нэг удаагийн улирлын түүвэр судалгаа юм. Судалгааны хамралтын хугацаа нь 4 улирал буюу 2002 оны 10 дугаар сараас 2003 оны 9 дүгээр сарыг дуусталх нэг жилийг хамарсан. Судалгааны эхний улирлын мэдээллийг 2002 оны 10-12-р сард, хоёрдугаар улирлынхыг 2003 оны 1-3-р сард, гуравдугаар улирлынхыг 2003 оны 4-6-р сард, харин сүүлчийн буюу дөрөвдүгээр улирлын мэдээллийг 2003 оны 7-9-р дүгээр саруудад цуглуулсан болно. АХБ-наас хэрэгжүүлж буй “Нийгмийн статистикийг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд энэхүү судалгааг явуулсан тул уг төсөл 2003 оны 11 дүгээр сард дуусахаар төлөвлөж байсантай холбогдуулан мэдээлэл цуглуулах ажлыг 2003 оны 1 дүгээр сард бус харин 2002 оны 10 дүгээр сард эхлүүлэхээр шийдсэн юм. Иймд судалгааны улирлын хугацаа цаг тооллын улирлын хугацаатай таарахгүй байгааг анхаарах хэрэгтэй.

Судалгааны түүвэрлэлт

2.15 Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнг ашиглан дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, цэргийн хуаран зэрэг газруудыг оруулалгүйгээр Монголын нийт өрхөд үндэслэн АХС-ны түүврийн хүрээг тогтоосон. Судалгааны нутаг дэвсгэрийн үндсэн нэгжийг тогтооходоо Улсын Их Хурлаас баталсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан үндсэн 5 бүсийг (Улаанбаатар хот болон төв, зүүн, баруун, хангайн бүс) дотор нь хот, хөдөө гэж нийт 9 бүлэг болгон авсан. Түүвэрлэлтийг хийхдээ 2 шатат түүврийн аргыг хэрэглэсэн. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын нэгжийг түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-ээр, өрхийн түүврийн хоёр дахь нэгж (ТХШН)-ээр сонгосон. Эхний шатанд түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-ийг хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар, хоёр дахь шатанд ТАШН-ийг сонгосны дараа тооллогын нэгж бүрээс түүвэр олонлогийг бүрдүүлэх өрхүүдийг энгийн санамсаргүй системчилсэн цикл түүврийн аргаар сонгосон. Бүс нутаг бүрд ногдох түүврийн хэмжээг Хүснэгт 9-д харуулав. Түүвэрлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 3 - т үзүүлсэн. Нийт түүврийн хэмжээг 4 улирлаар хуваан мэдээлэл цуглуулсан ба судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрхийн тоог улирал тус бүрээр Хүснэгт 10-13-т, нийт дүнгээр нь Хүснэгт 14-т тус тус харуулав.

Бүс	Хот		Хөдөө		Нийт дүн	
	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо
1 Улаанбаатар	320	3,200			320	3,200
2 Төв	80	800	160	1,600	240	2,400
3 Зүүн	80	800	160	1,600	240	2,400
4 Баруун	80	800	160	1,600	240	2,400
5 Хангай	80	800	160	1,600	240	2,400
Дүн	640	6,400	640	6,400	1,280	12,800

Тайлбар: Тооллогын нэгж бүрээс 10 өрх түүвэрлэгдэнэ.

Хүснэгт 9.

Бүс нутагт ногдох түүврийн хэмжээ

Бүс	Хот		Хөдөө		Нийт дүн	
	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо
1 Улаанбаатар	81	809			81	809
2 Төв	20	200	35	347	55	547
3 Зүүн	18	178	42	420	60	598
4 Баруун	22	218	39	390	61	608
5 Хангай	22	220	39	390	61	610
Дүн	163	1,625	155	1,547	318	3,172

Тайлбар: Тооллогын нэгж бүрээс 10 өрх түүвэрлэгдэн судалгаанд хамрагдах ёстой боловч зарим тооллогын нэгжээс 10 – аас бага өрх судалгаанд хамрагдсан байна.

Хүснэгт 10.

Ажиллах хүчний 1 дүгээр улирлын судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрхийн тоо: 2002 оны 10-12 сар

Бүс	Хот		Хөдөө		Нийт дүн	
	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо
1 Улаанбаатар	81	809			81	809
2 Төв	16	158	39	390	55	548
3 Зүүн	21	210	40	400	61	610
4 Баруун	16	160	46	458	62	618
5 Хангай	20	200	42	420	62	620
Дүн	154	1,537	167	1,668	321	3,205

Хүснэгт 11.

Ажиллах хүчний 2 дугаар улирлын судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрхийн тоо: 2003 оны 1-3 сар

Бүс	Хот		Хөдөө		Нийт дүн	
	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо
1 Улаанбаатар	80	800			80	800
2 Төв	19	190	44	440	63	630
3 Зүүн	25	250	36	360	61	610
4 Баруун	18	180	40	400	58	580
5 Хангай	17	170	42	420	59	590
Дүн	159	1,590	162	1,620	321	3,210

Хүснэгт 12.

Ажиллах хүчний 3 дугаар улирлын судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрхийн тоо: 2003 оны 4-6 сар

Бүс	Хот		Хөдөө		Нийт дүн	
	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо
1 Улаанбаатар	78	780			78	780
2 Төв	21	210	46	460	67	670
3 Зүүн	16	160	42	420	58	580
4 Баруун	24	240	35	350	59	590
5 Хангай	19	190	39	390	58	580
Дүн	158	1,580	162	1,620	320	3,200

Хүснэгт 13.

Ажиллах хүчний 4 дүгээр улирлын судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрхийн тоо: 2003 оны 7-9 сар

Бүс	Хот		Хөдөө		Нийт дүн	
	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо	Тооллогын нэгжийн тоо	Өрхийн тоо
1 Улаанбаатар	320	3,198	0	0	320	3,198
2 Төв	76	758	164	1,637	240	2,395
3 Зүүн	80	798	160	1,600	240	2,398
4 Баруун	80	798	160	1,598	240	2,396
5 Хангай	78	780	162	1,620	240	2,400
Дүн	634	6,332	646	6,455	1,280	12,787

Хүснэгт 14.

Ажиллах хүчний судалгаанд хамрагдсан тооллогын нийт нэгж болон өрхийн тоо: 2002 оны 10 сараас 2003 оны 9 сар

Тайлбар: Тооллогын нэгж бүрээс 10 өрх түүвэрлэгдэх ёстой боловч зарим тооллогын нэгжээс 10 – аас бага өрх түүвэрлэгдсэн.

Судалгааны асуулгын хуудас

2.16 Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээг харгалзан судалгааны асуулгын хуудас, зааврыг боловсруулсан. Тухайн үеийн болон байнгын эдийн засгийн идэвхийн тодорхойлолт, аргачлалыг ашиглан асуулгыг боловсруулж, төгсгөлийн бүлэгт хүүхдийн хөдөлмөрийн талаарх асуултуудыг хавсаргасан. Сургалтанд хамрагдсан тоологч нар сонгогдсон бүх өрхөд очиж асуулга авч, тэдний эдийн засгийн идэвхитэй, идэвхигүй байдлын талаар иж бүрэн мэдээлэл цуглуулсан. Судалгааны асуулгын тухайн үеийн идэвхийн талаарх хэсэгт өрхийн 5 ба түүнээс дээш насны бүх хүнээс сүүлийн 7 хоногт эрхэлсэн эдийн засгийн үйл ажиллагааны талаар асууж бөглөсөн. Эдийн засгийн идэвхийг бодитой тооцохын тулд сонгогдсон өрхийн гишүүдийн эрхэлсэн эдийн засгийн бүх үйл ажиллагаа, түүний дотор өрхийн мал аж ахуй, газар тариалан, хүнсний ногоо зэрэг аж ахуйн ажлууд дахь оролцооны талаар нарийвчлан асуусан.

2.17 Манай орны эдийн засгийн үйл ажиллагаанд мал аж ахуй зонхилох үүрэгтэй байдаг. Иймд сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийг тодорхойлох аргачлалаар хүн амын жилийн турш эрхэлсэн үндсэн болон бусад үйл ажиллагаа, улирлын хэлбэлзлийн талаарх мэдээллийг авсан.

2.18 ОУХБ-ын ХХУОУХ нь АХС-нд хүүхдийн хөдөлмөрийн талаархи хавсарга судалгааг оруулж, судалгааг хамтран санхүүжүүлсэн. ХХХС -ны асуулга нь хүүхдийн өрх, өрхөөс гадуурх эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь оролцооны талаарх мэдээллийг цуглуулахад чиглэсэн. Тухайлбал 5-17 насны хүүхэд нь гэрийн ажилд оролцож буй эсэх, хэдэн наснаасаа эхлэн өрхөөс гадуур ажил хийж эхэлсэн, ажлаас болж өвдөж гэмтсэн эсэх талаар нарийвчлан судалсан. Олон улсын стандартын дагуу АХС-ны асуулга авах өрхийн гишүүдийн насны доод хязгаарыг 5 насаар тогтоосон нь тэдний эдийн засгийн үйл ажиллагаа, боловсролын талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах зорилготой байв.

2.19 Энэ судалгааг зохион байгуулан явуулах ажлын хэсэг нь асуулгын хуудас, зааврыг боловсруулахдаа удирдлагын зөвлөлийн гишүүд болон холбогдох яамд, ТББ, ОУБ-уудтай зөвшилцөх, саналыг нь авах, хоёр удаа турших замаар асуулгыг хэд хэдэн удаа шинэчлэн боловсронгуй болгож эцэслэсэн. (Хавсралт 4-ыг үзнэ үү). Асуулгаар дараах мэдээллийг цуглуулсан. Үүнд:

А Хүн ам зүйн үзүүлэлтүүд

- а. Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох
- б. Хүйс
- в. Төрсөн он сар өдөр, нас
- г. Сургуульд суралцсан, суралцаж байгаа эсэх
- д. Боловсролын түвшин
- е. Бичиг үсгийн мэдлэг
- ё. Гэрлэлтийн байдал

Б. Сүүлийн 7 хоног болон сүүлийн 12 сарын байдлаар тодорхойлох ажиллах хүчний үзүүлэлтүүд

Тухайн үеийн идэвхи, түүнд зарцуулсан цаг

- а. Сүүлийн 7 хоногийн (тухайн үеийн) эдийн засгийн үйл ажиллагааны идэвхи
- б. Сүүлийн 7 хоногийн (тухайн үеийн) эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цаг
- в. Сүүлийн 7 хоногийн (тухайн үеийн) эдийн засгийн бус үйл ажиллагаа
- г. Сүүлийн 7 хоногийн (тухайн үеийн) эдийн засгийн бус үйл ажиллагаанд зарцуулсан цаг
- д. Сүүлийн 7 хоногийн эдийн засгийн идэвхитэй, идэвхигүй байдал
- е. Сүүлийн 7 хоногт (тухайн үеийн) эрхэлсэн үндсэн болон давхар ажил эрхлэлт
- ё. Үндсэн болон давхар ажил эрхлэлтийн ажилласан хугацаа
- ж. Сүүлийн 7 хоногт үндсэн болон давхар ажил эрхэлсэн дундаж цаг

- з. Үндсэн болон давхар ажил эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангиллаар
- и. Үндсэн болон давхар ажил эрхлэлт, ажил эрхлэлтийн байдлаар
- й. Ажил эрхлэлт, байгууллагын төрлөөр
- к. Үндсэн болон давхар ажил эрхлэлтэнд зарцуулсан дундаж цаг
- л. Сүүлийн 7 хоногт (тухайн үеийн) эрхэлсэн цалин, хөлстэй үндсэн болон давхар ажил эрхэлсэн хүний тоо
- м. Сүүлийн 7 хоногт (тухайн үеийн) цалин, хөлстэй үндсэн болон давхар ажил эрхэлсэн ажиллагчдын цалин, орлого
- н. Нэмэгдэл ажил хийх хүсэл, боломж
- о. Нэмэгдэл ажил хийх хүсэл боломжгүй байгаа шалтгаан
- ө. Бүрэн бус хөдөлмөр эрхэлсэн хугацаа
- п. Нэмэгдэл ажил хэрхэн хайсан

V. Ажилгүйдэл

- а. Ажил хийхэд бэлэн байсан эсэх
- б. Эдийн засгийн идэвхигүй байсан шалтгаан
- в. Ажил хайсан хугацаа
- г. Ямар төрлийн/ажил мэргэжлийн ажил хийх бодолтой байгаа
- д. Хичнээн төгрөгний цалин хөлс (өдрийн, сарын) авах бодолтой байгаа
- е. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн эсэх
- ё. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хугацаа
- ж. Ажил хайсан хэлбэр
- з. Ажилгүй байсан хугацаа

Г. Байнгын эдийн засгийн идэвхи

- а. Сүүлийн 12 сарын эдийн засгийн идэвхи
- б. Сүүлийн 12 сарын хугацааны үндсэн болон давхар ажил эрхлэлт
- в. Сүүлийн 12 сарын хугацааны үндсэн ба давхар ажил эрхлэлтийн байдал, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар
- г. Ажилгүй байсан хугацаа
- д. Ажил хайсан хэлбэр
- е. Сүүлийн 12 сарын хугацааны үндсэн болон давхар ажил эрхлэлт, ажил эрхлэлтийн байдлаар
- ё. Сүүлийн 12 сард үндсэн болон давхар ажил эрхлэлтээс авсан дундаж цалин хөлс, орлого

Д. Өмнөх үеийн ажил эрхлэлт

- а. Өмнөх үеийн ажил эрхлэлтийн ажил мэргэжил, ажиллаж байсан эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын төрөл
- б. Хамгийн сүүлийн ажлаа хир удаан хийсэн
- в. Хамгийн сүүлийн үеийн ажил эрхлэлтийн байдал
- г. Өмнөх үеийн ажил эрхлэлтийн хамгийн сүүлчийн өдөр, хугацаа
- д. Ажиллаж байсан салбар, байгууллагын төрөл
- е. Хамгийн сүүлчийн ажлаа хийхээ больсон шалтгаан
- ё. Ажилгүй байх хугацаандаа ямар орлого, тусламжаар амьдарч байгаа

Е. Хүүхдийн эдийн засгийн идэвхи (5-17 насны)

- а. Гэрийнхээ ажилд тусалж байгаа хэлбэрүүд
- б. Сургуульд хамрагдалт
- в. Сургуульд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа шалтгаан
- г. Өрхийн аж ахуйн ажилд оролцдог эсэх
- д. Анх хэдэн настайгаасаа эхэлж ажиллаж эхэлсэн
- е. Өрхөөс гадуур ямар нэг ажил хийх болсон шалтгаан
- ё. Хэний удирдлага, хяналтын дор ажиллаж байгаа
- ж. Хүүхдүүд ажлын байрныхаа нөхцөлд сэтгэл ханамж ямар байдаг
- з. Хийж буй ажил нь хүүхдэд бие болон сэтгэлийн дарамт учруулдаг эсэх
- и. Шөнө оройн цагаар ажилладаг эсэх, хэр олон удаа
- й. Хүүхэд ажлаасаа болж өвдөж гэмтсэн эсэх
- к. Ямар өвчин гэмтэл авсан
- л. Олсон орлогоо юунд зарцуулдаг
- м. Өдөрт өөрт нь чөлөөт цаг гардаг эсэх

Туршилтын судалгаа

2.20 ҮСГ-ын ажиллах хүчний судалгааны ажлын хэсэг АХС-ны асуулга, зааврыг эцэслэж боловсруулахын өмнө асуулга, зааврын боловсруулалт, программын ажиллагааг шалгах зорилгоор 2002 оны 4-7 сард 2 удаа туршилтын судалгааг Төв аймаг болон Улаанбаатар хотын дүүргүүдэд хийсэн. Туршилтын дүнд үндэслэн асуулгын найруулга, асуултуудын хоорондын уялдаа холбоог сайжруулсны дараагаар хэрэглэгчид буюу холбогдох, яам, ТББ-ын төлөөлөгчдөд тараан өгч санал авсан. Ийнхүү хэрэглэгчдийн саналыг авч тусгасны дараагаар туршилт судалгааг дахин явуулж, асуулгыг улам боловсронгуй болгосон. Туршилт судалгаанууд болон хэрэглэгчдийн санал зөвлөмжинд



үндэслэн асуултуудын найруулга, уялдаа холбоо, дараалал, асуулгад хэрэглэгдэх ангилал, кодуудыг эцэслэн боловсруулсан.

Үр дүнгийн хүснэгт

2.21 Асуулгын хуудасны асуултуудад үндэслэн үр дүнгийн олон хүснэгтийг боловсруулах боломжтой байв. Асуулгын хуудсыг эцэслэх үед хэрэглэгчдэд хэрэгцээтэй, мөн тайланд орох үр дүнгийн хүснэгтүүдийн анхны хувилбарыг боловсруулсан. Түүнчлэн тоо мэдээний үнэн бодит байдлыг шалгах хэд хэдэн хүснэгтийг боловсруулсан болно. Ажлын хэсэг нэмэлт хүснэгтүүдийг шинээр боловсруулсны сацуу эхний хагас жилийн тайлангийн дүнг хэрэглэгчдэд танилцуулж, тэднээс гарсан саналын дагуу зарим шинэ хүснэгтийг нэмж боловсруулан гаргасан.

Мэдээллийн нууцлал

2.22 Энэхүү судалгааг явуулахдаа “Статистикийн тухай” Монгол Улсын хуулинд мэдээллийн нууцыг хамгаалах талаархи заалтуудыг мөрдсөн. Үүний дагуу сонгогдсон өрхөөс цуглуулсан мэдээллийг зөвхөн статистикийн зорилгоор буюу нийгэм, эдийн засгийн бодлого, төлөвлөлт гаргахад ашиглах бөгөөд мэдээллийг татвар, мөрдөн байцаалт болон бусад зорилгын дагуу хэрэглэхгүй байх болно. Мэдээллийн нууцлалыг хадгалах энэхүү заалтыг тоологчид болон ахлагч нар, мэдээлэл боловсруулагчид чанд сахин мөрдөнө. Ажил эрхлэлт, түүнээс олох орлоготой холбоотой мэдээллийг цуглуулж буй энэ судалгааны тоо мэдээллийн нууцлалыг сахин хамгаалж чадсанаар судалгаанд хамрагдагчид асуулганд бодитой, үнэн зөв мэдээлэл өгөхөд чухал хувь нэмэр болсон.

Судалгааны зохион байгуулалт

2.23 АХС-ны ажлын хэсгийг ҮСГ дээр байгуулж судалгааг зохион байгуулан явуулах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгүүлсэн. Судалгааны өдөр тутмын ажлыг төлөвлөх, хэрэгжилтэнд хяналт тавих, судалгааг жигд явуулахтай холбогдсон шийдвэр гаргах ажлыг ҮСГ-ын дарга болон ҮСГ-ын дэд даргын хяналттайгаар АХБ-ны төслийн зохицуулагч хэрэгжүүлж байв. Төслийн зөвлөхүүдийн туслалцаатайгаар асуулгыг боловсруулах, турших, эцэслэн баталгаажуулах, түүврийн дизайныг боловсруулах, түүвэрлэлт хийх, аймаг, нийслэлийн статистикийн ажилтнуудаас сонгогдсон тоологч, ахлагч нарыг сургах ажлыг зохион байгуулав. Тоо мэдээ цуглуулах ажлыг амжилттай хийх зорилгоор аймаг, нийслэлийн статистикийн ажилтнуудаас ахлагч, тоологч нарыг сонгон ажиллуулсан. Ахлагч, тоологч нар нь тоо мэдээлэл цуглуулахаас гадна мэдээллийг кодлох, засвар хийх, шивж ирүүлэх үүрэгтэй ажилласан.

Судалгааны ахлагч, тоологч нарын сургалт

2.24 Олон өрхийг хамарсан томоохон хэмжээний АХС-г ҮСГ-ын хэмжээнд анх удаа явуулж байгаа тул ахлагч, тоологч нарын сургалтыг төвлөрсөн хэлбэрээр зохион байгуулсан. Асуулгын зааварт судалгаанд ашиглах ойлголт, тодорхойлолт, аргачлалыг нарийвчлан тусгасан. Ажлын хэсэг, олон улсын зөвлөхүүдтэй хамтран тоологч, ахлагч нарын сургалтыг 2002 оны 10-р сарын 6-наас 13-ны өдрүүдэд зохион байгуулж, Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүргийн хороодод асуулга авах дадлага сургуулилтыг удирдан хийлгэсэн. Мөн аймаг, нийслэлийн ажиллах хүчний судалгааны ахлагч нарыг нэгдсэн сургалтын үеэр судалгааны бөглөгдсөн асуулгыг кодлох, компьютерт шивж оруулах IMPS программын сургалтанд хамруулсан.

Мэдээлэл цуглуулалт

2.25 Судалгааны тоологч, ахлагч нар сонгогдсон өрхүүдэд очиж 5 ба түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан. Судалгааны нэгдүгээр улирлын мэдээллийг цуглуулах ажил 2002 оны 10-12 сард, хоёрдугаар улирлынх 2003 оны 1-3 сард, гуравдугаар улирлынх 2003 оны 4-6 сард, дөрөвдүгээр улирлынх 2003 оны 7-9 сард хийгдэж дууссан. Тоологч бүрт 5-6 тооллогын нэгжийн 50-60 өрх ногдсон бөгөөд энэ судалгаа нь улирлаар явагдсан тул улирал бүрийн дараагийн сард илүү ачаалалтай ажиллаж байв. Монгол Улсад хүн

амын шилжих хөдөлгөөн их байгааг харгалзан судалгаа авах үеэр өрх эзгүй байх тохиолдолд судалгаанд сонгогдсон өрхөө бүрэн хамруулахын тулд тухайн өрхөд 2-3 удаа дахин очиж, судалгаанд хамруулах ажилд хяналт тавьж ажиллав. Үүний дүнд нийт 4 улирлын хэмжээнд 12,787 өрхөөс асуулга бүрэн авч чадав. Судалгааны ажлын хэсгийн гишүүд, байгууллагын удирдлагуудаас бүрдсэн хяналтын баг АХС-ны ажлын явцыг нийт 13 аймаг болон Улаанбаатар хотод хянаж шалган, гарсан ололт, дутагдлыг тухай бүр нь танилцуулж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан. Нийслэл, аймгийн статистикийн албадын ажилтнуудыг тоологч, ахлагчаар авч ажиллуулсан нь тэдний мэдлэг чадварыг нь нэмэгдүүлэхэд тодорхой үр дүн үзүүлсэн.

Мэдээлэл боловсруулалт

2.26 АХС-ны мэдээлэл боловсруулах ажлыг 2 үе шаттайгаар явуулсан. Судалгааны асуулгын загвар болон мэдээллийг компьютерт бэлтгэн оруулах, бүрдэлтийг шалган хүлээн авах, хянах, засварлах, боловсруулах, нэгдсэн үр дүнг гарган авах ажлуудыг ҮСГ-т, харин өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт

шивж оруулах, шалгах, засварлан төвд дамжуулах ажлыг аймаг, нийслэлийн статистикийн ажиллах хүчний судалгааны баг хийж гүйцэтгэсэн. АНУ-ын Тооллогын Товчооноос боловсруулан гаргасан IMPS программыг ҮСГ-ны мэдээлэл боловсруулалтын газрын ажилтнууд хүн амын тооллого болон бусад түүвэр судалгаануудад өргөнөөр ашиглаж тодорхой туршлага дадлага эзэмшсэн тул АХС-ны мэдээллийг IMPS багц программаар боловсруулж, мэдээллийг шалгахдаа Сонсог-ын засварын модулыг ашигласан. Судалгааны мэдээллийг боловсруулж дууссаны дараа ажлын хэсэг зөвлөхийн хамт тодорхой үзүүлэлтүүд дээр статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнгийн үндсэн үзүүлэлтүүдийг бусад эх сурвалжаас авсан мэдээлэлтэй харьцуулж үзэх, судалгааны боловсруулалтын үр дүнг хянах, илэрсэн алдааг засварлах, зарим үзүүлэлтийн боловсруулалтанд хэрэглэсэн томьёолол, агуулгыг лавлан тодруулсны үндсэн дээр ажлын баримт бичиг болох материалуудыг бэлтгэн гаргаж тайлан бичихэд хэрэглэв. Түүврийн алдааг IMPS программын хүрээнд CENVAR модулыг ашиглан тооцсон.

бүлэг 3

СУДАЛГААНЫ ДҮН



Бүлэг 3

СУДАЛГААНЫ ДҮН

Хүн ам зүйн болон ерөнхий үзүүлэлтүүд

Нийтлэг зүйл

3.1 Энэ бүлэгт АХС-ны дөрвөн улиралын турш хийсэн (2002 оны 10 дугаар сараас 2003 оны 9 дүгээр сарыг дуустал) тооллогын нийт 1,280 нэгжийн 12,800 өрхөөс цуглуулсан мэдээлэл, түүн дээр үндэслэн тооцсон судалгааны үр дүнг танилцуулж байна. Түүвэрлэлтийн загварын дагуу тооллогын нэгж бүрээс 10 өрх, нийт 12800 өрх сонгогдож хамрагдах ёстойгоос нийт 12,787 өрх хамрагдаж, хамралтын түвшин 99.9 хувьтай байна.

3.2 АХС нь ОУХБ-аас гаргасан нийтлэг ойлголт, тодорхойлолт, арга зүйн дагуу хийгдэж байгаа ажиллах хүчний анхны түүвэр судалгаа юм. ҮСГ-аас энэхүү судалгааны тоо мэдээ, үр дүнг улирал тус бүрээр болон хагас, бүтэн жилээр нэгтгэн боловсруулсан. Өөрөөр хэлбэл энэ тайлан нь улирал бүрээр болон дөрвөн улирлаар нэгтгэн боловсруулсан тоо мэдээ, үр дүнд үндэслэсэн бөгөөд тайланд зөвхөн үндсэн үр дүнг харуулсан хүснэгтүүдийг оруулсан болно.

3.3 Хавсралт 1-д судалгааны үндсэн үзүүлэлт, үр дүнгийн зарим нарийвчилсан хүснэгтийг оруулав.

Хүн ам зүйн үзүүлэлтүүд

3.4 “Ажиллах хүчний судалгаа”-гаар хүн амын тоо, насны бүлэг, хүйс, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, бичиг үсгийн мэдлэг, өрхийн ам бүлийн тоо, гэрлэлтийн байдал гэх мэт хүн ам зүйн холбогдолтой үндсэн мэдээлэл гарч байна. Судалгаанд 2 шатат түүврийн аргыг ашиглан бүлэглэлт хийсэн тул хүн ам зүйн үзүүлэлтүүдийг дөрвөн бүс нутаг, хот, хөдөө, Улаанбаатар хот гэсэн ангиллаар гаргав. Хүн ам зүйн үзүүлэлтүүдийг эдгээр ангиллаар тооцон гаргахад түүврийн нийт хэмжээ хангалттай гэж үзэж дөрвөн улирлын нэгдсэн тоонд үндэслэн дэлгэрэнгүй хүснэгтүүдийг байршил болон бүсээр боловсруулан гаргав. Үндсэн

үзүүлэлтийг улирлын хэлбэлзлээр тооцож гаргасныг зарим хүснэгтэнд танилцуулсан.

Хүн амын тоо, байршил, бүс нутгаар

3.5 Судалгааны үр дүнг тархаасан тооцоогоор манай орны 568,800 өрхөд нийт 2.403 мянган хүн ам байгаагийн дотор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо 174.0 мянга байна. Өрхийн ам бүлийн дундаж тоо 4.2 байна. Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амыг тооцоходоо сургуулийн хүүхдийн дотуур байр, цэргийн хуаран, засан хүмүүжүүлэх газар, эмнэлэг зэрэг нийтийн байранд амьдрагчдыг хамруулаагүй болно. Өрхийн хүн амын тоог байршил, бүсээр Хүснэгт 15-д харуулав. Нийт хүн амын 52.3 хувь буюу 1,256 мянган хүн хотод амьдарч байна. Хөдөөгийн өрхийн ам бүлийн дундаж тоо хотынхоос өндөр буюу 4.4 байна. Нийт өрхийн 30 орчим хувь нь Улаанбаатар хотод байгаа бөгөөд нийслэлийн өрхийн ам бүлийн дундаж тоо улсын дундажаас нилээд доогуур буюу нэг өрхөд 3.9 хүн ногдож байна. Хүн амын суурьшлыг бүс нутгаар авч үзэхэд харилцан адилгүй байгаа бөгөөд зүүн бүсэд хамгийн бага, тухайлбал нийт хүн амын 8.4 хувь нь амьдарч байна.



Байршил/Бүс	Өрх		Хүн ам Тоо	Өрхөөс гадуур байгаа Тоо	Нийт хүн амын тоо		Өрхийн ам бүлийн дундаж тоо
	Тоо	%			Тоо	%	
Хот	311,000	54.7	1,198,300	57,800	1,256,100	52.3	4.0
Хөдөө	257,800	45.3	1,030,500	116,200	1,146,700	47.7	4.4
Төв	114,700	20.2	445,300	36,300	481,600	20.0	4.2
Зүүн	48,500	8.5	173,000	30,000	203,000	8.4	4.2
Баруун	97,900	17.2	425,500	40,200	465,700	19.4	4.8
Хангай	138,900	24.4	541,800	55,800	597,600	24.9	4.3
Улаанбаатар	168,800	29.7	643,200	11,700	654,900	27.3	3.9
Дүн	568,800	100.0	2,228,800	174,000	2,402,800	100.0	4.2

Хүснэгт 15.

Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр

3.6 Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын үр дүнгээс харахад Монгол Улсын нийт суурин хүн амын тоо цэрэг, хоригдол, асрах газар, дотуур байр, нийтийн байранд амьдарч байгаа 35,855 хүнийг оролцуулан 2,373,000 гэж тоологдсон бөгөөд 541,000 өрхөд 2,338 мянган хүн амьдарч, өрхийн ам бүлийн дундаж тоо 4.3 байв. Засаг захиргааны нэгжээс гаргуулан авдаг хүн амын ажил эрхлэлтийн 2003 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээр суурин хүн амын тоо 2,488 мянга байна.

3.7 АХС-нд нийтийн байранд амьдрагчид болон 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг хамруулаагүй болно. 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдийн тоог хот, хөдөө, бүсээр нь гаргаж Хүснэгт 16-д үзүүлэв.

3.8 Ойролцоогоор таван өрх тутмын нэг өрхийн 1 ба түүнээс дээш гишүүн нь өрхөөс гадуур амьдарч байна. Тухайн өрхийн гишүүн боловч 6 сараас дээш хугацаагаар эзгүй байсан өрхийн гишүүд нийт хүн амын 7.0 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр хүмүүсийг судалгаанд хамруулах эсэхээс хамаарч нийт хүн амын тоо болон өрхийн ам бүлийн дундаж тоог газар зүйн байршлаар тооцож гаргасан нь үр дүнд нөлөөлж байна. Ямар нэг сургууль, курст суралцан өрхөөс гадуур амьдарч байгаа хүн 121,000 байхад ажил эрхлэн өрхөөс гадуур амьдарч байгаа хүн 34,600 байна. Судалгаагаар 6 сараас дээш хугацаагаар эзгүй байсан өрхийн гишүүдийн талаарх мэдээллийг цуглуулаагүй болно.

Хот, хөдөө/ Бүс	Өрхийн тоо	Өрхийн гишүүдийн тоо	Өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо	Үүнээс:		
				Суралцаж байгаа	Ажиллаж байгаа	Бусад
Хот	36,500	131,400	57,800	32,200	19,100	6,500
Хөдөө	64,600	245,500	116,200	88,800	15,500	11,900
Төв	20,800	75,000	36,300	25,000	8,000	3,300
Зүүн	15,400	52,000	30,000	21,800	5,400	2,800
Баруун	24,700	106,600	40,200	28,700	5,900	5,600
Хангай	31,600	113,200	55,800	42,200	8,100	5,500
Улаанбаатар	8,600	30,100	11,700	3,300	7,200	1,200
Дүн	101,100	376,900	174,000	121,000	34,600	18,400

Хүснэгт 16.

6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөө, бүсээр

Иймээс судалгааны тайланд орсон хүснэгтүүд нь өрхөөс гадуур амьдарч байгаа цэрэг, хоригдол, дотуур байранд амьдарч байгаа хүмүүс, 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг оруулахгүйгээр тооцсон хүн амын

тоонд үндэслэн хийгдсэн болно. Үүнийг судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийхдээ анхаарах шаардлагатай. Хүснэгт 17-д судалгаанд хамрагдсан хүн амын тоог бүс нутаг, хот, хөдөөгөөр харуулав.

Байршил/ Бүс	Өрх		Өрхийн ам бүлийн дундаж тоо	Бүгд		Эрэгтэй %	Эмэгтэй %
	Тоо	%		Тоо	%		
Хот	311,000	54.7	3.9	1,198,300	100.0	48.9	51.1
Хөдөө	257,800	45.3	4.0	1,030,500	100.0	50.5	49.5
Төв	114,700	20.2	3.9	445,300	100.0	49.6	50.4
Зүүн	48,500	8.5	3.6	173,000	100.0	50.8	49.2
Баруун	97,900	17.2	4.3	425,500	100.0	50.2	49.8
Хангай	138,900	24.4	3.9	541,800	100.0	49.9	50.1
Улаанбаатар	168,800	29.7	3.8	643,200	100.0	48.7	51.3
Улсын дүн	568,800	100.0	3.9	2,228,800	100.0	49.6	50.4

Хүснэгт 17.


Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр

Хүн амын нас, хүйсийн бүтэц

3.9 Хүн амын нас, хүйсийн бүтцийг Хүснэгт 18-д харуулав. Нийт хүн амын дотор 0-14 насны хүүхэд 30.9 хувийг эзэлж байгаа бөгөөд хүйсээр нь авч үзэхэд эрэгтэйчүүдийн 32.1

Зураг 1.

Хүн амын насны бүтэц, 1979, 1989, 2000 оны ХАОСТ, АХС-ны дүнгээр



хувь, эмэгтэйчүүдийн 29.8 хувь нь энэ насны бүлэгт хамрагдаж байна. Зураг 1-д хүн амын насны бүтцийг хүн ам, орон сууцны сүүлийн 3 тооллого болон АХС-гаар харуулав. Энд харагдаж байгаа гол өөрчлөлт болох сүүлийн 30 гаруй жилд 15-64 насны хүн амын эзлэх хувь тогтвортой нэмэгдэж, харин 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувь буурч байгаа хандлага энэ судалгааны дүнгээр ч бас харагдаж байна.

Судалгаагаар нийт хүн амын 65.3 хувийг 15-64 насны хүн ам, 3.8 хувийг 65 ба түүнээс дээш насны хүн ам тус тус эзэлж байна. Хүснэгт 18-аас харахад хүйсийн харьцаа 20-24 наснаас дээш бүлэгт (60-64 насны бүлгийг оруулахгүйгээр) 100-гаас бага байна. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор гарсан хүн амын насны бүтцийг авч үзэхэд мөн ийм байдал ажиглагдсан.

Насны бүлэг	Дүн		Эрэгтэй		Эмэгтэй		Хүйсийн харьцаа*
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	
00 – 04	182,700	8.2	94,100	8.5	88,600	7.9	106.2
05 – 09	212,100	9.5	109,200	9.9	102,900	9.2	106.1
10 – 14	294,800	13.2	152,000	13.7	142,800	12.7	106.4
15 – 19	265,300	11.9	134,700	12.2	130,600	11.6	103.1
20 – 24	191,500	8.6	96,000	8.7	95,500	8.5	100.5
25 – 29	178,500	8.0	87,000	7.9	91,500	8.1	95.1
30 – 34	175,200	7.9	84,100	7.6	91,100	8.1	92.3
35 – 39	171,000	7.8	79,700	7.2	91,300	8.2	87.3
40 – 44	161,600	7.2	76,800	6.9	84,800	7.6	90.6
45 – 49	116,000	5.2	57,000	5.2	59,000	5.2	96.6
50 – 54	76,600	3.4	35,900	3.2	40,700	3.7	88.2
55 – 59	58,400	2.6	27,800	2.5	30,600	2.7	90.8
60- 64	59,700	2.7	31,700	2.9	28,000	2.5	113.2
65-69	34,200	1.5	16,400	1.5	17,800	1.6	92.1
70+	51,200	2.3	23,700	2.1	27,500	2.4	86.2
Дүн	2,228,800	100.0	1,106,100	100.0	1,122,700	100.0	98.5

* 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо

Хүснэгт 18.

Хүн амын нас, хүйсийн бүтэц, хүйсийн харьцаа

Хүн ам зүйн ачаалал

3.10 Хүн ам зүйн ачааллыг 15 хүртэлх насны хүүхэд болон 65, түүнээс дээш насны хүн амын тооны нийлбэрийг 15-64 насны хүн амын тоонд харьцуулж гаргах бөгөөд судалгаагаар энэ үзүүлэлт манай улсын хувьд 53.3 хувь гарлаа. Хүснэгт 19-д Хүн ам зүйн ачааллыг хот, хөдөө, бүсээр харуулснаас үзэхэд Улаанбаатар хотод хамгийн бага 44.0 хувь, баруун бүсэд

хамгийн өндөр 66.0 хувь гарав. Өөрөөр хэлбэл баруун бүсийн хөдөлмөрийн насны 100 хүн тутамд ажил хийхэд нас нь бага, эсвэл нас нь өндөр 66 хүн ногдож байна гэсэн үг юм. Өмнө дурьдсанчлан сургууль, курст суралцах зорилгоор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа 121,000 залуучуудыг хамруулаагүйгээс энэ харьцаа доогуур гарсан.

Хүн ам зүйн ачаалал	Бүгд %	Хот %	Хөдөө %	Төв %	Зүүн %	Баруун %	Хангай %	УБ %
Залуу насны (0-14)	47.4	42.5	53.6	48.0	45.8	60.0	50.9	37.6
Ахимаг насны (65+)	5.9	5.9	5.9	6.0	8.0	6.0	4.6	6.2
Улсын дундаж	53.3	48.4	59.5	54.0	53.8	66.0	55.5	43.8

Хүснэгт 19.

Хүн ам зүйн ачааллын харьцаа, хот, хөдөө, бүсээр

Гэрлэлтийн байдал

3.11 Судалгаагаар 15, түүнээс дээш насны бүх хүмүүсийн гэрлэлтийн байдлыг гэрлэсэн, огт гэрлээгүй, хамт амьдардаг, тусгаарласан, салсан, бэлбэсэн гэсэн 6 бүлэгт хувааж авч үзсэн. Монгол Улсын 15, түүнээс дээш насны нийт хүн амын 56.2 хувь нь гэрлэсэн, 33.3 хувь нь огт гэрлээгүй, 6.7 хувь нь бэлбэсэн байна. Гэрлэлтийн мэдээллийн үнэн зөвийг гэрлэсэн эрэгтэйчүүдийн тоо, гэрлэсэн эмэгтэйчүүдийн тоотой ойролцоо тэнцүү байдлаар үнэлдэг.

Ингэж шалгаж үзэхэд гэр бүл болсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо хот, хөдөөд адил гарч байгаа нь судалгааны энэ асуултад өгсөн хариулт үнэн бодитой болохыг харуулж байна. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүнгээр гэр бүлтэй эрэгтэйчүүд 58.5 хувь, эмэгтэйчүүд 57.1 хувийг эзэлж байсан бол энэ судалгаагаар үүнтэй ойролцоо дүн гарсныг хүснэгт 20-оос харж болно.

Гэрлэлтийн байдал	Бүгд			Хот		Хөдөө	
	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Эрэгтэй %	Эмэгтэй %
Огт гэрлээгүй	33.3	36.3	30.4	36.7	31.3	35.9	29.3
Гэрлэсэн	56.2	57.4	55.2	55.5	51.8	59.6	59.6
Хамт амьдардаг	0.7	0.7	0.7	0.9	0.9	0.4	0.5
Тусгаарласан	0.9	0.7	1.2	1.0	1.8	0.2	0.4
Салсан	2.2	1.3	2.9	1.9	4.0	0.7	1.5
Бэлбэсэн	6.7	3.6	9.6	4.0	10.2	3.2	8.7
Дүн, %	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0
15, түүнээс дээш насны хүн амын тоо	1,539,200	750,800	788,400	408,600	446,500	342,200	341,900
Гэрлэсэн хүний тоо	865,600	430,700	434,900	226,600	231,100	204,100	203,800

Хүснэгт 20.

Хүн амын гэрлэлтийн байдал, хот, хөдөө, бүсээр

Өрхийн бүтэц

3.12 Хүснэгт 21-д нийт өрхийн тоог ам бүлийн тоо, хот, хөдөө, бүс нутгаар харууллаа. Судалгаагаар гарсан өрхийн ам бүлийн тоо нь түр эзгүй байсан өрхийн гишүүдийг оруулаагүйгээс шалтгаалан доогуур гарсан байна. Нийт өрхийн 6.5 хувь нь ганц бие өрх байна. Харин 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрх улсын дүнгээр 2.8 хувьтай байна. Баруун бүсэд ийм өрхийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 4.0 хувь

байгаа бөгөөд энэ бүсэд өрхийн ам бүлийн дундаж тоо 4.3 байна. Бараг зургаан өрх тутмын нэг өрх нь 6 болон түүнээс дээш ам бүлтэй байна. Өрхөөс түр эзгүй байгаа гишүүдийг оруулж тооцсоноор өрхийн ам бүлийн дундаж тоо Улаанбаатар хотод 3.9 байхад баруун бүсэд 4.8 (Хүснэгт 15-г үзнэ үү) байна. Өрхийн ам бүлийн тоог бүс нутгаар авч үзэхэд ялгаа бага байна.

Өрхийн ам бүлийн тоо	Улсын дүн	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ
	%	%	%	%	%	%	%	%
1	6.5	6.8	6.2	6.5	8.5	4.2	6.8	7.2
2	13.8	13.9	13.7	15.1	18.2	10.6	12.6	14.6
3	21.4	22.5	20.2	21.5	24.3	17.8	21.2	22.9
4	25.4	25.6	25.2	24.8	24.0	22.8	27.6	26.0
5	17.2	17.0	17.1	0	14.0	20.7	17.6	15.4
6	8.5	7.9	9.3	7.9	6.2	13.5	7.6	7.5
7	4.4	3.8	5.0	4.1	3.1	6.2	4.2	3.9
8+	2.8	2.5	3.3	3.1	1.7	4.2	2.4	2.5
Дүн , %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
	568,800	311,000	257,800	114,700	48,500	97,900	138,900	168,800
Түр эзгүй байгаа хүнийг оруулаагүй өрхийн ам бүлийн дундаж тоо	3.9	3.9	4.0	3.9	3.6	4.3	3.9	3.8

Хүснэгт 21.

Өрхийн дүнд эзлэх хувь, ам бүлийн тоо, хот, хөдөө, бүсээр

Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх

3.13 Судалгааны үр дүнгээр нийт өрхийн 16.4 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байгаа бөгөөд энэ харьцаа хөдөөд буурч

11.9 хувь болж байна. Хүснэгт 22-т эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийг ам бүлийн тоо болон хот, хөдөөгөөр харууллаа.

Өрхийн ам бүлийн тоо	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх		
	Бүгд	Хот	Хөдөө
	%	%	%
1	44.1	44.8	43.2
2	30.1	36.0	22.8
3	18.7	23.6	12.1
4	9.7	12.5	6.2
5	9.0	11.0	6.6
6	9.0	12.0	5.8
7	8.7	10.9	6.8
8+	7.9	14.5	2.0
Улсын дундаж , %	16.4	20.2	11.9

Хүснэгт 22.

Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор

Ер нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд гол төлөв цөөхөн ам бүлтэй байна. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь багасч байна. Тухайлбал ганц бие өрхийн 44.0 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байхад, ойролцоогоор 3 ам бүлтэй таван өрхийн нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй байна. Хотод 3 ам бүлтэй өрхийн дөрөвний нэг нь, хөдөөд наймны нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй байна. Харин 4 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн 8.0-10.0 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байна.

Боловсролын түвшин

3.14 Судалгаагаар хүн амын эзэмшсэн боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, бичиг үсгийн мэдлэгийн талаархи мэдээллийг цуглуулсан. 15, түүнээс дээш насны хүмүүсийн эзэмшсэн боловсролын түвшинг хүснэгт 23-д харуулав. Хүснэгтээс харахад хот, хөдөөгийн алинд ч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзэмшсэн боловсролын түвшин бараг ойролцоо, гэхдээ эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс

арай дээгүүр байна. Хүснэгт 23-т эрэгтэйчүүдийн 4.6 хувь, эмэгтэйчүүдийн 5,0 хувь нь сургуульд огт сурч байгаагүй, эрэгтэйчүүдийн 17.8 хувь, эмэгтэйчүүдийн 16.2 хувь нь бага боловсролтой байгаа нь хөдөлмөрийн насны таван хүн тутмын нэг нь бага боловсролтой эсвэл боловсролгүй байгааг харуулж байна. Хөдөөд энэ харьцаа нилээд өндөр буюу 8.0 хувь нь огт сурч байгаагүй, 25-29 хувь нь бага боловсрол эзэмшсэн байна. Улсын хэмжээнд найман хүн тутмын нэг нь их дээд сургууль төгссөн байна. Хотын хүн амын бараг 20.0 хувь нь бакалаврын болон магистрийн цол эзэмшсэн байхад энэ нь хөдөөд 3.0 хүрэхгүй хувьтай байна. Хүн амын боловсролын түвшинг хот, хөдөөгөөр харьцуулж үзэхэд хөдөөд доогуур гарч байна.

Боловсролын түвшин	Бүгд			Хот		Хөдөө	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
	%	%	%	%	%	%	%
Боловсролгүй	4.8	4.6	5.0	2.0	2.6	7.8	8.1
Бага	16.9	17.8	16.2	8.7	9.1	28.6	25.3
Бүрэн бус дунд	27.7	30.4	25.1	23.4	18.0	38.8	34.3
Бүрэн дунд	24.3	22.9	25.7	31.1	31.7	13.1	17.8
Мэргэжлийн анхан шатны	5.1	5.7	4.5	6.5	5.1	4.6	4.0
Тусгай мэргэжлийн/ бүрэн бус дээд	9.3	7.2	11.2	9.5	13.9	4.5	7.7
Дээд	11.9	11.4	12.3	18.8	19.6	2.6	2.8
Дүн, %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15, түүнээс дээш насны хүн амын тоо	1,539,200	750,800	788,400	408,600	446,500	342,200	341,900

Хүснэгт 23.

15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хот, хөдөө, хүйс, дүнд эзлэх хувиар

Сургуульд хамрагдалт

3.15 Судалгааны үр дүнгээр 7-19 насны хүн амын 79.1 хувь нь, үүнээс эрэгтэйчүүдийн 76.7 хувь, эмэгтэйчүүдийн 81.6 хувь нь сургуульд суралцаж байна. Сургуулийн насанд хүрсэн хүүхдүүд сургуульд оройтож орж байгаа нь сургуульд хамрагдалтын түвшинг бууруулахад нөлөөлж байгааг Хүснэгт 24-өөс үзэж болно. Хот, хөдөөгийн алинд ч охидын сургуульд хамрагдалтын хувь хөвгүүдийнхээс дээгүүр байгаа сонирхолтой дүр зураг харагдаж байна. Хотод сургуулийн бага ангид охид, хөвгүүдийн сургуульд хамрагдалтын түвшин бараг адил байснаа 10 наснаас эхлэн өөрчлөгдөж эхэлдэг. Хөдөөд анх сургуульд орохоос эхлэн сургууль төгсөх хүртэлх бүх шатанд охидын сургуульд хамрагдалтын түвшин

хөвгүүдийнхээс өндөр байна. Ялангуяа хөдөөгийн өсвөр насны охидын сургуульд хамрагдалтын түвшин мөн насны хөвгүүдийнхээс нилээд дээгүүр байгаа нь бусад хөгжиж буй орнуудаас нэлээд ялгаатай байна. Хөдөөд мал аж ахуйд туслах зорилгоор хөвгүүд сургууль завсардаж, мөн боловсрол эзэмшсэн залуучууд ажил олоход хэцүү болж байгаа зэрэг нь сургуульд хамрагдалтын түвшинд нөлөөлж байгаа юм. Хотод 16 настай хөвгүүд, охидын 90.0 гаруй хувь нь сургуульдаа үргэлжлүүлэн суралцаж байхад хөдөөд энэ үзүүлэлт харьцангуй доогуур байгаа нь хөвгүүд, охидын сургууль завсардалт их байгаатай холбоотой юм.

Бүтэн нас	Одоогоор сургуульд сурч байгаа								
	Улсын дүн			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	%	%	%	%	%	%	%	%	%
7	39.4	38.2	40.7	51.3	48.2	54.5	29.5	30.1	28.9
8	81.0	80.2	81.8	88.5	89.3	87.7	73.8	71.4	76.2
9	94.8	94.2	95.5	97.9	99.4	96.3	91.7	89.0	94.6
10	96.8	95.7	97.7	98.7	98.5	98.8	94.6	92.6	96.6
11	95.8	95.2	96.3	97.9	97.5	98.5	92.8	92.2	93.4
12	94.9	93.0	97.2	98.7	98.2	99.3	90.0	85.9	94.6
13	92.1	90.8	93.5	97.0	97.1	97.0	85.2	82.2	88.7
14	90.3	87.9	92.7	96.6	96.2	97.0	81.4	76.9	86.4
15	86.9	83.8	89.8	95.7	94.9	96.5	76.1	70.4	81.6
16	78.3	74.4	82.4	91.9	90.5	93.4	59.7	53.0	66.9
17	70.5	65.4	75.8	87.2	83.2	91.2	50.5	43.8	57.3
18	47.8	43.5	52.2	67.1	62.7	71.4	25.2	22.1	28.5
19	41.3	37.1	46.2	61.2	58.3	64.3	15.6	10.6	21.5
07-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь	79.1	76.7	81.6	88.6	87.5	89.7	67.6	62.8	71.7
Сургуульд хамрагдсан хүүхдийн тоо	545,500	270,400	275,100	333,900	167,900	166,000	211,600	102,500	109,100
Нийт хүн ам	689,800	352,600	337,200	377,100	192,000	185,100	312,700	160,600	152,100

Хүснэгт 24.

7-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр

Бичиг үсгийн мэдлэгийн түвшин

3.16 Судалгаагаар бичиг үсэг мэддэг эсэхийг тодорхойлохын тулд энгийн захиа уншиж бичиж чадах уу гэж асуусан. Энгийн бичиг захиаг уншиж, бичиж чадаж байвал бичиг үсэгт тайлагдсанд тооцсон. Харин зөвхөн өөрийнхөө нэрийг унших эсвэл тоо уншиж чаддаг боловч бичиж чаддаггүй бол тэр хүнийг бичиг үсэгт тайлагдсанд тооцоогүй. Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын хувийг тодорхойлохдоо 15, түүнээс дээш насны нийт хүн амын дотор энгийн бичиг захиа уншиж, бичиж чаддаг хүний эзлэх хувиар тооцлоо. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин 97.8 хувь гарсан бол энэ удаагийн судалгаагаар эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин ойролцоо 97.0 хувьтай байна. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүнтэй харьцуулахад бичиг үсгийн мэдлэгийн түвшин нь суралцах, ажиллах зорилгоор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа хүмүүсийг оруулаагүйгээс шалтгаалан арай доогуур гарсан байна.

3.17 Хүснэгт 25-д хөдөөд бичиг үсгийн мэдлэгийн түвшин 95,0 хувь байхад хотод үүнээс 3.5 пунктээр дээгүүр байгааг харуулж байна. 26-р хүснэгтээс харахад 64 хүртэлх насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин 95-аас дээш хувьтай байна.



Хот, хөдөө/бүс	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %
Хот	98.5	98.7	98.3
Хөдөө	95.0	94.9	95.0
Төв	97.1	96.9	97.3
Зүүн	95.1	95.5	94.7
Баруун	94.7	94.8	94.6
Хангай	96.4	96.5	96.4
Улаанбаатар	98.9	99.1	98.7
Улсын дүн	96.9	97.0	96.9

Хүснэгт 25.

Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, хот, хөдөө, бүсээр

Насны бүлэг	Улсын дүн			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
15 – 24	97.3	96.8	97.8	99.3	99.2	99.4	94.8	93.9	95.9
25 – 34	99.0	98.7	99.2	99.6	99.5	99.7	98.2	97.9	98.6
35 – 44	98.9	98.7	99.1	99.5	99.4	99.6	98.0	97.7	98.2
45 – 54	98.3	98.6	98.1	99.4	99.5	99.2	97.0	97.4	96.6
55 – 64	95.3	96.4	94.3	97.7	98.4	96.9	92.1	93.7	90.4
65+	78.0	81.4	74.9	84.8	88.4	81.9	69.4	73.6	65.2
Дүн	96.9	97.0	96.9	98.5	98.7	98.3	95.0	94.9	95.0

Хүснэгт 26.

Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр

бүлэг 4

ТУХАЙН ҮЕИЙН
ИДЭВХИ



Бүлэг 4

ТУХАЙН ҮЕИЙН ИДЭВХИ

Өрхийн гишүүдийн тухайн үеийн үйл ажиллагаа

4.1 Судалгаагаар өрхийн 5 ба түүнээс дээш настай гишүүдээс сүүлийн 7 хоногт хийсэн эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагааны талаар асуусан. Энэ нь асуулга явуулах өдрөөс өмнөх 7 хоногийг хамарсан тул нэгд, тэр үед ямар үйл ажиллагаа эрхэлсэн, хичнээн цаг зарцуулсан талаар асуулганд хамрагдсан өрхийн гишүүд сайн санаж байх, хоёрт, өрхийн гишүүд тухайн хугацаанд эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаанд хэрхэн оролцсон байдал дээрээ үндэслэн ажиллах хүчний байдлыг өөрсдөө тодорхойлж, улмаар бодитой тооцоход дөхөмтэй байв. Гуравт тус судалгааны асуулгыг олон улсын ойлголт, тодорхойлолтын дагуу боловсруулсан учраас судалгааны тоологчид өрхийн гишүүдийн эрхэлсэн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж, дүгнэлт хийх, өрхийн гишүүдэд ажиллах хүчний байдлаа зөв тодорхойлоход нь туслах, ажил эрхлэлт болон ажилгүйдлийн талаар мэдээлэл авахад чиглэгдсэн юм. Дөрөвт, судалгааг өвлийн улиралд буюу 10 дугаар сараас эхэлсэн бөгөөд Монголын хөдөө орон нутагт мал аж ахуй зонхилж, хөдөлмөр эрхлэлт улирлаар их хэлбэлздэг нөхцөлд сүүлийн 7 хоногийн байдлаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах нь өрхийн гишүүдийн эрхэлсэн үйл ажиллагаа, зарцуулсан цагт үндэслэн тэдний ажил эрхлэлтийн байдлыг бодитойгоор тодорхойлох боломжийг олгосон.

4.2 Сүүлийн 7 хоногт цалин хөлстэй ажил, худалдаа үйлчилгээ, МАА, ан агнуур, газар тариалан эрхлэх, хувиараа хичээл заах зэрэг эдийн засгийн нийт 13 төрлийн үйл ажиллагааг эрхэлсэн эсэх, эдгээр үйл ажиллагаанд нийт хичнээн цаг зарцуулсныг асууж, тухайн үеийн идэвхийг тодорхойлсон. Хүснэгт 27-д сүүлийн 7 хоногт эдийн засгийн ямар нэг үйл ажиллагаа эрхэлсэн хүн амын тоог 5 ба түүнээс дээш, 15 ба түүнээс дээш насны бүлгээр харуулав. Зарим хүн эдийн засгийн нэгээс илүү төрлийн үйл ажиллагаа эрхэлсэн нь ажил хийж буй нийт хүн амын эдийн засгийн үйл ажиллагааны ерөнхий төлөв байдлыг харуулж байгаа юм.

4.3 Сүүлийн 7 хоногт 15 ба түүнээс дээш настай нийт 800,500 хүн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлснээс 52.3 хувь нь эрэгтэй, 47.7 хувь нь эмэгтэйчүүд байв. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн нийт хүн амын 37.2 хувь буюу 297,900 хүн цалин хөлстэй ажил хийж байсны 146,200 нь эрэгтэй, 151,700 нь эмэгтэйчүүд байна. МАА, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлсэн хүмүүсийн тоо хамгийн олон 368,600 / 46.0 хувь эзэлж/ байсан бөгөөд үүнээс 198,800 нь эрэгтэй, 169,800 нь эмэгтэйчүүд байв. Цалин хөлстэй ажил болон МАА, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүс нийлээд сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн нийт хүн амын 83.2 хувийг эзэлж байна.

4.4 Нийт 79,100 хүн бөөний болон жижиглэн худалдаа, төрөл бүрийн бизнес, үйлчилгээ эрхэлжээ. Эрэгтэйчүүдтэй



харьцуулахад ийм үйл ажиллагаа эрхэлсэн эмэгтэйчүүдийн тоо илүү олон байна. Ачаа тээврийн үйлчилгээ эрхэлсэн хүн 2.6 хувийг, гар урлал, оёдол нэхмэлийн үйл ажиллагаа эрхэлсэн хүн 1.0 хувийг эзэлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагаа	5 ба түүнээс дээш настай			15 ба түүнээс дээш настай		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
а/ Хүн амын тоогоор						
Цалин хөлстэй ажил	298,000	146,300	151,700	297,900	146,200	151,700
Худалдаа, үйлчилгээ	80,700	35,100	45,500	79,100	34,000	45,100
МАА, ан агнуур	400,100	218,200	181,900	368,600	198,800	169,800
Газар тариалан	16,300	10,000	6,300	14,700	8,900	5,800
Ойн аж ахуй, мод бэлтгэх	2,600	2,200	500	2,600	2,100	500
Тээврийн үйлчилгээ	20,800	19,300	1,500	20,800	19,300	1,500
Ашигт алтмал олборлох	5,800	4,500	1,300	5,300	4,100	1,200
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх	2,800	1,300	1,500	2,800	1,300	1,500
Зочид буудал, зоогийн газар	5,200	1,800	3,400	5,000	1,700	3,300
Эд зүйлс, ахуйн жижиг засвар үйлчилгээ	6,700	5,400	1,300	6,700	5,400	1,300
Гар урлал	7,900	1,600	6,300	7,800	1,600	6,200
Барилга барих, их засварын үйлчилгээ	6,400	4,700	1,700	6,400	4,700	1,700
Хөлстэйгээр хүүхэд асрах болон хувиараа хичээл заах	1,100	600	500	1,100	600	500
Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн нийт хүний тоо	835,600	441,000	394,600	800,500	419,000	381,500
Цалин хөлстэй ажил эрхэлсэн	298,000	146,300	151,700	297,900	146,200	151,700
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	537,600	294,700	242,900	502,600	272,900	229,800
б/ Дунд эзлэх хувиар						
	%	%	%	%	%	%
Цалин хөлстэй ажил	35.7	33.2	38.4	37.2	34.9	39.8
Худалдаа, үйлчилгээ	9.7	8.0	11.5	9.9	8.1	11.8
МАА, ан агнуур	47.9	49.5	46.1	46.0	47.4	44.5
Газар тариалан	2.0	2.3	1.6	1.8	2.1	1.5
Ойн аж ахуй, мод бэлтгэх	0.3	0.5	0.1	0.3	0.5	0.1
Тээврийн үйлчилгээ	2.5	4.4	0.4	2.6	4.6	0.4
Ашигт алтмал олборлох	0.7	1.0	0.3	0.7	1.0	0.3
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх	0.3	0.3	0.4	0.3	0.3	0.4
Зочид буудал, зоогийн газар	0.6	0.4	0.9	0.6	0.4	0.9
Эд зүйлс, ахуйн жижиг засвар үйлчилгээ	0.8	1.2	0.3	0.8	1.3	0.3
Гар урлал	0.9	0.4	1.6	1.0	0.4	1.6
Барилга барих, их засварын үйлчилгээ	0.8	1.1	0.4	0.8	1.1	0.4
Хөлстэйгээр хүүхэд асрах болон хувиараа хичээл заах	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1
Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн нийт хүний тоо, %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй ажил эрхэлсэн	35.7	33.2	38.4	37.2	34.9	39.8
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	64.3	66.8	61.6	62.8	65.1	60.2

Хүснэгт 27.

Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүн амын тоо, дүнд эзлэх хувь

Эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг

4.5 Хүснэгт 28-д сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 5 ба түүнээс дээш насны хүн амын тоог нас, хүйс, хот, хөдөөгөөр харуулав. Хүснэгтээс харахад улсын дундажар 15 ба түүнээс дээш насны хүмүүс эдийн засгийн үйл ажиллагаанд 45.7 цаг зарцуулснаас эрэгтэйчүүдэд 48.9 цаг, эмэгтэйчүүдэд 42.3 цаг ногдож байна. 5-9 насны эрэгтэй

хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан дундаж цаг 16 байгаа бөгөөд түүнээс дээшхи насны бүлгүүдэд өсөн нэмэгдсээр 30-34 насны эрэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг 51 цаг болж өсөөд цаашид эргээд буурч байна.

Насны бүлэг	Улсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
05-09	14.8	16.0	12.9	16.2	12.5	21.4	14.7	16.2	12.6
10-14	25.4	27.5	21.6	17.4	17.8	16.2	26.6	29.1	22.1
15-17	37.6	40.9	32.6	34.5	34.8	34.0	38.0	41.7	32.4
18-19	45.0	48.5	39.8	50.5	51.9	48.5	43.6	47.6	37.8
20-24	44.8	48.6	40.2	48.1	49.1	46.8	43.2	48.3	37.1
25-29	46.2	50.1	42.0	47.3	49.1	45.3	45.5	50.8	39.7
30-34	47.8	51.1	44.3	47.9	48.7	47.1	47.7	53.2	41.6
35-39	47.4	50.2	44.7	47.7	48.6	46.7	47.2	52.2	42.2
40-44	46.2	48.9	43.7	46.8	48.1	45.7	45.5	49.9	41.1
45-49	45.6	49.0	42.2	46.2	47.5	45.0	44.9	50.6	39.3
50-54	45.1	47.4	42.5	46.6	47.3	45.8	43.6	47.6	38.8
55-59	43.7	46.7	37.9	45.3	46.6	42.8	42.4	46.8	34.4
60-64	43.1	46.7	36.8	42.4	45.2	37.2	43.4	47.6	36.5
65-69	43.1	45.3	39.5	42.7	43.8	39.2	43.2	46.1	39.5
70+	35.0	41.7	26.5	35.2	40.1	24.3	35.0	42.1	26.8
Дундаж цаг, 5+	44.7	47.6	41.5	46.7	47.7	45.7	43.1	47.5	38.1
Хүний тоо, 5+	835,600	441,000	394,600	359,700	184,200	175,500	475,900	256,800	219,100
Дундаж цаг, 15+	45.7	48.9	42.3	47.0	48.1	45.8	44.7	49.5	39.3
Хүний тоо, 15+	800,500	419,000	381,500	356,600	182,000	174,600	443,900	237,000	206,900


Хүснэгт 28.

Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, насны бүлэг, хүйс, байршлаар

Эдийн засгийн үйл ажиллагаанд залуу эмэгтэйчүүд үе тэнгийн эрэгтэйчүүдээс 6-7 цагаар бага цаг зарцуулжээ. Хот, суурин газрынхтай харьцуулахад хөдөө орон нутагт эрэгтэйчүүд эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд илүү их цагийг зарцуулж байхад эмэгтэйчүүдийн хувьд эсрэгээр буюу хот, суурин газарт илүү их цаг зарцуулж байгаа хандлага ажиглагдлаа.

Зураг 2.

Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 15 ба түүнээс дээш насны хүн ам, зарцуулсан цагаар



Тухайн үеийн эдийн засгийн бус үйл ажиллагаа /гэрийн ажил/

4.6 Хүн амын ажиллах хүчний байдлыг бодитойгоор тодорхойлж, цаг ашиглалтын талаар мэдээлэл цуглуулах зорилгоор өрхийн 5 ба түүнээс дээш насны гишүүдээс сүүлийн 7 хоногт эрхэлсэн эдийн засгийн бус үйл ажиллагаа /гэрийн ажил/, тэдгээрт зарцуулсан цагийн талаар нарийвчлан асуусан. Хоол цай хийх, аяга таваг угаах, гэр орон цэвэрлэх, хувцас угаах, гэр, байшин эд хогшил сэргээн засварлах, гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдан авах, ус авах, түлээ түлш бэлтгэх, хүүхэд асрах, сайн дурын ажилд үнэ хөлсгүйгээр оролцох зэрэг нийт 12 төрлийн эдийн засгийн бус үйл

ажиллагаа эрхэлсэн эсэх, тэдгээрт хичнээн цаг зарцуулсан талаар асууж тооцсон.

4.7 Хэдийгээр НҮБ-аас зөвлөмж болгож буй ҮТС-ийн хүрээнд ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулан тооцдог боловч энэ судалгаагаар дээрх хоёр үйл ажиллагааг гэрийн ажилд оруулан, тусад нь авч үзэх нь зүйтэй гэж үзэв. Монголын хүн амын дийлэнх нь ус авах, түлш түлээ бэлтгэхэд оролцож байдаг тул дан ганц асуултаар энэ хоёр үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, эдийн засгийн үйл ажиллагаанд оруулан тооцох нь үндэслэл муутай тул гэрийн ажил гэсэн ангилалд багтаан өрхийн гишүүдээс мэдээлэл цуглуулсан билээ. Энэ мэдээллийг хэрхэн ашиглахаа судлаачид, хэрэглэгчид өөрсдийн зорилго, судалгааны хүрээ, дүн шинжилгээтэй нийцүүлэн шийдвэрлэх боломжтой болно.

4.8 5 ба түүнээс дээш насны нийт 1.827 мянган хүн буюу 874,400 эрэгтэй, 952,300 эмэгтэйчүүд сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлжээ. 15 ба түүнээс дээш насны 1,539 мянган хүн амын 92.0 хувь буюу 1,419 мянга нь сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн байна. Хүснэгт 29-д эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн хүний тоо болон дүнд эзлэх хувийг хүйсээр гаргаж харуулав.

4.9 Сүүлийн 7 хоногт 15 ба түүнээс дээш насны 713,900 эмэгтэй (95.0 хувь), 377,400 (56.5 хувь) эрэгтэй, бүгд 1.091 мянган хүн хоол цай хийж, аяга таваг угаасан нь бусад үйл ажиллагаатай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн дөрвөн хүн тутмын гурав нь ийм ажил хийжээ гэсэн үг юм.

Эдийн засгийн бус үйл ажиллагаа	5 наснаас дээш			15 наснаас дээш		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
а/ Хүн амын тоо						
Хоол цай хийх, аяга таваг угаах	1,399,000	516,200	882,800	1,091,300	377,400	713,900
Гэр орон цэвэрлэх	1,254,700	419,300	835,400	956,000	288,200	667,800
Хувцас угаах, индүүдэх	1,022,700	322,400	700,300	872,600	265,000	607,600
Гэр байшин, эд хогшил сэргээн засах	296,700	244,800	51,900	280,300	232,500	47,800
Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах	713,000	294,700	418,300	637,300	259,700	377,600
Хувцас бусад нэхмэл сүлжмэл эдлэл оёх, арчлах	291,300	25,400	265,900	274,900	21,800	253,100
Ус авах	818,800	496,400	322,400	611,400	373,600	237,800
Түлээ түлш бэлтгэх	823,100	502,500	320,600	641,100	392,800	248,300
Өндөр настан, өвчтэй хүн асрах	62,600	25,300	37,300	54,800	22,000	32,800
Хүүхэд асрах	248,300	83,000	165,300	210,800	67,400	143,400
Гэрийн тэжээвэр амьтан арчлах, цэцэг тарих	137,300	67,900	69,400	111,800	52,500	59,300
Олон нийтийн болон сайн дурын ажилд үнэ хөлсгүй оролцох	89,500	47,700	41,800	67,100	36,400	30,700
ЭЗ бус үйл ажиллагаа эрхэлсэн нийт хүмүүсийн тоо	1,826,700	874,400	952,300	1,419,200	667,800	751,400
б/ Дүнд эзлэх хувь						
	%	%	%	%	%	%
Хоол цай хийх, аяга таваг угаах	76.6	59.0	92.7	76.9	56.5	95.0
Гэр орон цэвэрлэх	68.7	48.0	87.7	67.4	43.2	88.9
Хувцас угаах, индүүдэх	56.0	36.9	73.5	61.5	39.7	80.9
Гэр байшин, эд хогшил сэргээн засах	16.2	28.0	5.4	19.8	34.8	6.4
Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах	39.0	33.7	43.9	44.9	38.9	50.3
Хувцас бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах	15.9	2.9	27.9	19.4	3.3	33.7
Ус авах	44.8	56.8	33.9	43.1	55.9	31.6
Түлээ түлш бэлтгэх	45.1	57.5	33.7	45.2	58.8	33.0
Өндөр настан, өвчтэй хүн асрах	3.4	2.9	3.9	3.9	3.3	4.4
Хүүхэд асрах	13.6	9.5	17.4	14.9	10.1	19.1
Гэрийн тэжээвэр амьтан арчлах, цэцэг тарих	7.5	7.8	7.3	7.9	7.9	7.9
Олон нийтийн болон сайн дурын ажилд үнэ хөлсгүй оролцох	4.9	5.5	4.4	4.7	5.5	4.1
Дүн %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Хүснэгт 29.

Сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн 5 ба түүнээс дээш насны хүмүүсийн тоо, дүнд эзлэх хувь

Түүнчлэн сүүлийн 7 хоногт гэр орон цэвэрлэхэд 15 ба түүнээс дээш насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоо өндөр буюу эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн /гэрийн ажил/



нийт хүмүүсийн 67.4 хувийг эзэлж, хүйсээр нь авч үзвэл эмэгтэйчүүдийн 88.9 хувь, эрэгтэйчүүдийн 43.2 хувь нь ийм ажил эрхэлжээ. 611,400 хүн ус авах, 641,100 хүн түлш түлээ бэлтгэх ажлыг хийсэн байна. Өөрөөр хэлбэл нийт хүн амын 43.1 нь хувь ус авахад, 45.2 хувь нь түлээ түлш бэлтгэхэд цаг зарцуулжээ. Хүснэгт 29-өөс харахад дээрх хоёр ажилд эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүд илүү оролцоотой байна. Ойролцоогоор эмэгтэйчүүдийн 20.0 хувь, эрэгтэйчүүдийн 10.0 хувь нь хүүхэд асарч, харин олон нийтийн болон сайн дурын ажилд үнэ хөлсгүйгээр оролцсон хувь бага буюу сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн нийт хүмүүсийн 4.7 хувийг эзэлж байна.

Эдийн засгийн бус үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг

4.10 5 ба түүнээс дээш насны хүн амын сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цагийг Хүснэгт 30-д харуулж байна. 15 ба түүнээс дээш насны

хүмүүс эдийн засгийн бус үйл ажиллагаанд дунджаар долоо хоногт 25 цаг зарцуулжээ. Эрэгтэйчүүд 17.5 цаг, эмэгтэйчүүд 31.8 цаг зарцуулсан байна.

4.11 Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн 15 ба түүнээс дээш насны хүмүүсийг ийм үйл ажиллагааг эрхэлсэн нийт хүн амд харьцуулж, түүнд зарцуулсан цагийг Хүснэгт

Насны бүлэг	Улсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
05-09	8.6	8.3	8.9	7.2	7.1	7.4	9.6	9.2	10.1
10-14	14.2	12.6	15.9	13.0	11.4	14.6	15.8	14.1	17.5
15-17	19.3	15.9	22.7	18.1	15.4	20.7	21.0	16.6	25.3
18-19	20.8	16.7	25.1	18.6	16.1	21.0	23.6	17.4	30.5
20-24	25.9	18.1	33.5	22.3	16.3	27.9	30.1	20.1	40.2
25-29	31.2	20.0	41.5	28.2	18.6	36.2	34.2	21.3	46.9
30-34	29.5	19.9	37.8	26.8	18.5	33.3	32.5	21.3	43.6
35-39	26.6	18.1	33.6	23.7	16.2	29.5	30.7	20.5	39.6
40-44	23.8	16.1	30.0	21.6	15.2	26.6	26.7	17.3	35.0
45-49	23.1	15.3	29.8	20.7	14.0	26.4	26.0	16.9	34.0
50-54	24.9	16.2	31.8	23.9	16.5	29.5	26.2	15.9	34.8
55-59	24.9	16.5	31.8	25.0	16.3	31.1	24.8	16.6	32.8
60-64	21.9	16.5	27.5	20.7	16.8	24.9	23.7	16.0	31.1
65-69	21.6	16.4	25.8	19.9	16.0	22.5	23.4	16.7	29.7
70+	18.0	14.5	20.6	17.6	13.8	20.1	18.7	15.4	21.4
Дундаж цаг, 5+	22.2	15.9	27.9	20.2	14.9	24.9	24.5	17.1	31.7
Хүний тоо, 5+	1,826,700	874,400	952,300	996,300	466,000	530,300	830,400	408,400	422,000
Дундаж цаг, 15+	25.0	17.5	31.8	22.6	16.3	27.9	28.0	18.7	36.7
Хүний тоо, 15+	1,419,200	667,800	751,400	782,500	357,700	424,800	636,700	310,100	326,600

Хүснэгт 30.

Сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаанд зарцуулсан дундаж цаг насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр

Зарцуулсан цаг	Улсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
0-9	22.2	35.4	10.5	25.8	39.9	13.8	17.9	30.2	6.3
10-19	26.1	31.1	21.6	27.4	30.0	25.3	24.3	32.3	16.7
20-29	21.0	17.5	24.1	22.1	16.7	26.6	19.8	18.6	20.9
30-39	12.3	7.9	16.2	10.9	6.6	14.6	13.9	9.3	18.3
40-49	7.5	4.4	10.3	6.0	3.5	8.1	9.4	5.3	13.2
50-59	4.2	1.8	6.3	2.7	1.4	3.7	6.1	2.3	9.6
60-69	2.5	0.8	4.1	1.6	0.7	2.5	3.5	1.0	6.0
70+	4.2	1.1	6.9	3.5	1.2	5.4	5.1	1.0	9.0
Дүн %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Гэрийн ажил хийсэн хүний тоо	1,419,200	667,800	751,400	782,500	357,700	424,800	636,700	310,100	326,600

Хүснэгт 31.

Сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцсон 15, түүнээс дээш насны хүн амын тоо, зарцуулсан цаг, хүйс, хот, хөдөөгөөр

Ус авах, түлээ түлш бэлтгэх

4.12 Ус авах, түлээ түлш бэлтгэх үйл ажиллагааг НҮБ-ын ҮТС-ийн хүрээнд эдийн засгийн үйл ажиллагаанд оруулан тооцдог. Үүний дагуу энэ хоёр ажлыг хийсэн хүнийг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байна гэж үзэн ажил эрхэлж байгаа хүмүүст оруулж тооцсоноор эдийн засгийн

идэвхигүй эсвэл ажилгүй хүн амын тоог бууруулж тооцоход хүргэдэг тал бий. Хүснэгт 32, 33-т дээрх хоёр ажлыг хийсэн хүн амын тоог эдийн засгийн идэвхийн байдлаар нь ажилтай, ажилгүй, эдийн засгийн идэвхигүй гэсэн 3 ангиллаар тооцож харуулав.



4.13 Хэрвээ ус авахыг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулж тооцох юм бол Хүснэгт 32-т байгаа 5-17 насны 300,400 гаруй хүнийг (үүнээс 48,900 нь тухайн үед эдийн засгийн идэвхитэйгээс 3,000 хүн нь ажилгүй, 251,500 хүн эдийн засгийн идэвхигүй) эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байна гэж үзэн ажил эрхэлж байгаа хүмүүст оруулбал ажил эрхлэлтийг хэтрүүлэн тооцсон дүн гарах болно. Үүнтэй адил ус авах ажил хийсэн 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхигүй 180,200 (Хүснэгт 32-оос хар) хүнийг ч гэсэн ажил эрхэлсэн гэж үзэн, ажил эрхлэлтийн тоог хэтрүүлэн тооцох болно.

Насны бүлэг	Ус авсан хүний тоо	Идэвхитэй	Үүнээс		Идэвхигүй
			Ажилтай	Ажилгүй	
<i>5 ба түүнээс дээш насны хүн ам</i>					
Бүгд	300,400	48,900	45,900	3,000	251,500
5-9	57,200	8,100	8,100	-	49,200
10-14	150,200	15,900	15,500	400	134,300
15-17	93,000	24,900	22,300	2,600	68,000
Эрэгтэй	176,300	31,100	29,200	1,900	145,200
5-9	33,900	5,000	5,000	-	28,900
10-14	88,900	10,600	10,400	200	78,300
15-17	53,500	15,500	13,800	1,700	38,000
Эмэгтэй	124,100	17,800	16,700	1,100	106,300
5-9	23,300	3,100	3,100	-	20,200
10-14	61,300	5,300	5,100	200	56,000
15-17	39,500	9,400	8,500	900	30,100
<i>15 ба түүнээс дээш насны хүн ам</i>					
Бүгд	611,400	431,200	368,100	63,100	180,200
15-17	93,000	24,900	22,300	2,600	68,100
18-24	137,700	93,700	76,100	17,600	44,000
25-34	170,000	149,600	128,400	21,200	20,400
35-44	105,600	95,200	80,700	4,500	10,400
45-54	52,500	44,700	38,800	5,900	7,800
55-64	34,400	18,000	16,800	1,200	16,400
65+	18,200	5,100	5,000	100	13,100
Эрэгтэй	373,600	273,300	233,100	40,200	100,300
15-17	53,500	15,500	13,800	1,700	38,000
18-24	83,100	57,600	46,900	10,700	25,500
25-34	103,800	94,100	80,900	13,200	9,700
35-44	67,200	61,100	51,700	9,400	6,100
45-54	32,100	28,800	24,500	4,300	3,300
55-64	22,300	12,600	11,800	800	9,700
65+	11,600	3,600	3,500	100	8,000
Эмэгтэй	237,800	157,900	134,900	23,000	79,900
15-17	39,500	9,400	8,500	900	30,100
18-24	54,600	36,100	29,100	7,000	18,500
25-34	66,200	55,500	47,500	8,000	10,700
35-44	38,400	34,100	29,000	5,100	4,300
45-54	20,400	15,900	14,300	1,600	4,500
55-64	12,100	5,300	4,900	400	6,800
65+	6,600	1,600	1,600	-	5,000

Хүснэгт 32.

Ус авсан хүн амын тоо, насны бүлэг, хүйс, эдийн засгийн идэвхийн байдлаар

4.14 Мод, түлээ бэлтгэсэн хүн амын тоог насны бүлэг, хүйс, эдийн засгийн идэвхийн байдлаар нь гаргаж Хүснэгт 33-т харуулав. 5 ба түүнээс дээш насны нийт 265,100 хүн түлээ

түлш бэлтгэхэд оролцжээ. Энэ ажлыг эдийн засгийн үйл ажиллагаа гэж үзэх юм бол мөн л ажил эрхэлсэн хүн амын тоог хэт хөөрөгдөн нэмсэн дүн гарах болно.


Насны бүлэг	Мод, түлээ бэлтгэсэн хүний тоо	Идэвхитэй	Үүнээс		Идэвхигүй
			Ажилтай	Ажилгүй	
<i>5 ба түүнээс дээш насны хүн ам</i>					
Бүгд	265,100	48,600	46,000	2,600	216,500
5-9	58,600	9,300	9,300	-	49,300
10-14	123,400	15,300	15,200	100	108,100
15-17	83,100	24,000	21,500	2,500	59,100
Эрэгтэй	160,600	31,400	29,700	1,700	129,200
5-9	34,200	5,900	5,900	-	28,300
10-14	75,500	9,900	9,900	-	65,600
15-17	50,900	15,600	13,900	1,700	35,300
Эмэгтэй	104,500	17,200	16,300	900	87,300
5-9	24,400	3,400	3,400	-	21,000
10-14	47,900	5,400	5,300	100	42,500
15-17	32,200	8,400	7,600	800	23,800
<i>15 ба түүнээс дээш насны хүн ам</i>					
Бүгд	641,100	462,400	395,700	66,700	178,700
15-17	83,100	24,000	21,500	2,500	59,100
18-24	128,400	91,000	73,700	17,300	37,400
25-34	171,500	150,900	129,400	21,500	20,600
35-44	122,700	110,100	94,600	15,500	12,600
45-54	66,900	55,900	47,900	8,000	11,000
55-64	43,400	23,700	22,000	1,700	19,700
65+	25,100	6,800	6,600	200	18,300
Эрэгтэй	392,800	289,600	245,600	44,000	103,200
15-17	50,900	15,600	13,900	1,700	35,300
18-24	78,700	55,700	44,700	11,000	23,000
25-34	103,200	92,400	78,500	13,900	10,800
35-44	77,700	69,700	59,700	10,000	8,000
45-54	40,300	35,500	29,500	6,000	4,800
55-64	27,400	16,300	15,000	1,300	11,100
65+	14,600	4,400	4,300	100	10,200
Эмэгтэй	248,300	172,800	150,100	22,700	75,500
15-17	32,200	8,400	7,600	800	23,800
18-24	49,700	35,300	29,000	6,300	14,400
25-34	68,300	58,500	50,900	7,600	9,800
35-44	45,000	40,400	34,900	5,500	4,600
45-54	26,600	20,400	18,400	2,000	6,200
55-64	16,000	7,400	7,000	400	8,600
65+	10,500	2,400	2,300	100	8,100

Хүснэгт 33.

Мод, түлээ бэлтгэсэн хүн амын тоо, насны бүлэг, хүйс, эдийн засгийн идэвхийн байдлаар

бүлэг 5

АЖИЛЛАХ ХҮЧ



Бүлэг 5

АЖИЛЛАХ ХҮЧ

Ажиллах хүч

5.1 НҮБ-ын Үндэсний Тооцооны системд тодорхойлсоны дагуу тодорхой цаг хугацаанд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд ажиллах хүчээ оруулж буй нийт хүмүүсийг эдийн засгийн идэвхитэй хүн ам гэж үздэг. НҮБ-ын Үндэсний Тооцооны системийн тодорхойлолтоор үйлдвэрлэл, үйлчилгээ гэдэг нь борлуулах, бараа солилцох болон өөрийн хэрэгцээнд зориулан бараа бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэхийг хэлдэг.

5.2 Тухайн үеийн эдийн засгийн идэвхитэй хүн ам буюу ажиллах хүчийг сүүлийн 7 хоногт ажил эрхэлж байсан болон ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан ажил хөдөлмөр идэвхитэй хайсан, ажилгүй байсан хүмүүс бүрдүүлдэг. Хавсралт 2-т судалгаанд мөрдөгдсөн ажиллагчид болон ажилгүйчүүдийн тодорхойлолтыг хавсаргав. Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажил хийж байгаа, тэтгэвэрт гарсан болон өндөр настан, тахир дутуу зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагчид болон ажилгүйчүүдийн алинд ч хамаарахгүй хүмүүсийг эдийн засгийн идэвхигүй буюу ажиллах хүчинд хамаарагдахгүй хүн ам гэж үздэг.

Ажиллах хүчний тооцоо

5.3 Судалгааны дүнг тархаасан тооцоогоор 1.004,800 хүн сүүлийн 7 хоногт эдийн засгийн идэвхитэй байсан буюу ажиллах хүчийг бүрдүүлж байгаагийн 523,500 (52.1 хувь) нь эрэгтэйчүүд, 481,300 (47.9 хувь) нь эмэгтэйчүүд байна. Нийт ажиллах хүчний 482,600 (48.0 хувь) нь хот, суурин газарт, 522,200 (52.0 хувь) нь хөдөөд байна. Эдийн засгийн идэвхитэй хүн амын 862,500 нь ажиллагчид, 142,300 нь ажилгүй хүмүүс байв. Хэдийгээр Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжоор хөдөлмөр эрхлэх насыг 16-59 нас гэж заасан боловч АХС-нд хүн амын эдийн засгийн идэвхийг 15 ба түүнээс дээш насаар тооцсон нь олон улсын аргачлалд ойртуулах, бусад улс орныхтой харьцуулах боломжийг бүрдүүлж өгч байгаа юм.

5.4 Зарим судалгаа болон Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор ажиллах хүч болон ажил эрхлэлтийн талаарх

зарим тоо мэдээллийг тооцож гаргасан байна. Тухайлбал, Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор Монгол Улсад эдийн засгийн идэвхитэй хүн ам буюу ажиллах хүчийг 944,000 гэж тооцоод үүний 779,100 нь ажил эрхэлж байгаа, 164,900 нь ажил эрхлээгүй хүмүүс байна гэж тоологджээ. Үүнд нийтийн байранд амьдрагчид болон 6 сар ба түүнээс дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг оруулж тооцсон байна. ХАОСТ-оор ажил эрхлээгүй хүмүүст сүүлийн 7 хоногт ажил хийгээгүй, тооллогын үед ажил хайж байгаа болон тохирох ажил олдохгүй байгаа хүмүүс хамрагдсан. ҮСГ-аас засаг захиргааны бүртгэлд үндэслэн жил бүр гаргадаг ажил эрхлэлтийн жилийн тайлангаар 2003 оны байдлаар ажиллах хүчний нийт тоо 959,800 байгаагийн 926,500 нь ажиллагчид, 33,300 нь бүртгэлтэй ажилгүйчүүд байна. Харин хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн амаас хөдөлмөр эрхлэх сонирхолгүй, ХЭА-нд бүртгэлгүй боловч ажил хайж байгаа, тохирох ажил олдохгүй байгаа, тодорхой шалтгаангүй гэх мэт шалтгаанаар ажил идэвхитэй ирж хайхгүй байгаа болон ажил идэвхитэй хайж байгаа ХЭА-нд бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоогоор ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн амыг тооцож үзвэл 1112,5 (926,5+186,0) мянга болж байна. Иймд тодорхойлолт, аргачлалын зөрүүгээс гадна дээр дурьдсан шалтгаанаар энэ удаагийн судалгааны дүнг бусад тооллого, судалгаа, мэдээ тайлангийн дүнтэй шууд харьцуулах боломжгүй байгаа юм.



Байршил/Тухайн үеийн байдал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Улсын хэмжээнд						
Тухайн үеийн идэвхитэй хүн ам	1,004,800	65.3	523,500	69.7	481,300	61.1
Ажиллагчид	862,500	56.0	448,900	59.8	413,600	52.5
Ажилгүйчүүд	142,300	9.2	74,600	9.9	67,700	8.6
Тухайн үеийн идэвхигүй хүн ам	534,400	34.7	227,400	30.3	307,000	38.9
15, түүнээс дээш насны хүн ам	1,539,200	100.0	750,900	100.0	788,300	100.0
Хот						
Тухайн үеийн идэвхитэй хүн ам	482,600	56.4	247,800	60.6	234,800	52.6
Ажиллагчид	392,300	45.9	199,900	48.9	192,400	43.1
Ажилгүйчүүд	90,300	10.6	47,900	11.7	42,400	9.5
Тухайн үеийн идэвхигүй хүн ам	372,500	43.6	160,900	39.4	211,600	47.4
15, түүнээс дээш насны хүн ам	855,100	100.0	408,700	100.0	446,400	100.0
Хөдөө						
Тухайн үеийн идэвхитэй хүн ам	522,200	76.3	275,700	80.6	246,500	72.1
Ажиллагчид	470,200	68.7	249,000	72.8	221,200	64.7
Ажилгүйчүүд	52,000	7.6	26,700	7.8	25,300	7.4
Тухайн үеийн идэвхигүй хүн ам	161,900	23.7	66,500	19.4	95,400	27.9
15, түүнээс дээш насны хүн ам	684,100	100.0	342,200	100.0	341,900	100.0
Улсын хэмжээнд						
АХОТ		65.3		69.7		61.1
Ажил эрхлэлтийн түвшин		85.8		85.8		85.9
Ажилгүйдлийн түвшин		14.2		14.2		14.1
Хот						
АХОТ		56.4		60.6		52.6
Ажил эрхлэлтийн түвшин		81.3		80.7		81.9
Ажилгүйдлийн түвшин		18.7		19.3		18.1
Хөдөө						
АХОТ		76.3		80.6		72.1
Ажил эрхлэлтийн түвшин		90.0		90.3		89.7
Ажилгүйдлийн түвшин		10.0		9.7		10.3

Хүснэгт 34.

15, түүнээс дээш насны хүнамын ажил эрхлэлтийн байдал, хот, хөдөө, хүйсээр

Тэмдэглэл 1: АХОТ = Ажиллах хүчний оролцооны түвшин

Хүснэгт 35-д Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого, жилийн ажил эрхлэлтийн тайлан болон ажиллах хүчний түүвэр судалгаагаар гарсан ажиллах хүчний тоог харуулж байна. АХС нь 5 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний байдлын талаарх мэдээлэл цуглуулах зорилго агуулсан билээ. Тус судалгаанд хүүхдийн хөдөлмөрийн асуулгыг хавсарга болгон оруулсан тул насны доод хязгаарыг 5 насаар авсан.

Ажиллах хүчний оролцооны түвшин

5.5 Ажиллагчид болон ажилгүйчүүдийн нийлбэр нь эдийн засгийн идэвхитэй хүн ам буюу ажиллах хүчийг бүрдүүлдэг. Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ)-г дараах байдлаар тодорхойлно.

$$\text{АХОТ} = \frac{\text{Эдийн засгийн идэвхитэй хүн ам}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} \times 100$$

$$\text{АХОТ} = \frac{\text{Ажиллагчид} + \text{Ажилгүйчүүд}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} \times 100$$

Насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшинг доорх байдлаар тодорхойлно.

$$\text{Насны бүлэг дэх АХОТ} = \frac{\text{Насны бүлэг дэх (Ажиллагчид} + \text{Ажилгүйчүүд)}}{\text{Насны бүлэг дэх нийт хүн ам}} \times 100$$

Эдийн засгийн идэвхийн байдал	Ажиллах хүчний судалгаа 2002-2003		2000 оны ХАОСТ	* 2003 оны АЭТ
	Тухайн үеийн идэвхи	Байнгын идэвхи		
А/ Хүн амын тоо				
15, түүнээс дээш насны хүн ам	1,539.2	1,539.2	1,524.3	1,488.9
Эдийн засгийн идэвхитэй хүн ам	1,004.8	941.4	944.0	959.8
Ажиллагчид	862.5	856.6	779.1	926.5
Ажилгүйчүүд	142.3	84.8	164.9	33.3
Эдийн засгийн идэвхигүй хүн ам	534.4	597.8	580.3	529.1
Б/ Түвшин, хувиар				
Ажиллах хүчний оролцоо	65.3	61.2	61.9	64.5
Ажил эрхлэлт	85.8	91.0	82.5	96.5
Ажилгүйдэл	14.2	9.0	17.5	3.5
1-р улирал				
Ажиллах хүчний оролцоо	66.6	62.9		
Ажил эрхлэлт	82.0	87.4		
Ажилгүйдэл	18.0	12.6		
2-р улирал				
Ажиллах хүчний оролцоо	65.1	60.3		
Ажил эрхлэлт	85.0	91.4		
Ажилгүйдэл	15.0	8.6		
3-р улирал				
Ажиллах хүчний оролцоо	64.9	61.0		
Ажил эрхлэлт	86.8	91.4		
Ажилгүйдэл	13.2	8.6		
4-р улирал				
Ажиллах хүчний оролцоо	65.0	60.8		
Ажил эрхлэлт	89.6	93.5		
Ажилгүйдэл	10.7	6.5		

Хүснэгт 35.

15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний байдал/сүүлийн үеийн судалгаануудын дүнгээр/


* Тэмдэглэл: АЭТ-д хөдөлмөрийн насны доод хязгаарыг 16 насаар авсан. АЭТ нь засаг захиргааны мэдээлэлд үндэслэдэг бөгөөд ажилгүйчүүдийн тоо нь Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо болно.

5.6 15 ба түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин улсын хэмжээнд 65.3 хувь байгаагаас хөдөөд нэлээд өндөр буюу 76.3 хувьтай байна. Харин хотод энэ түвшин нэлээд доогуур буюу 56.4 хувь байна. Хөдөөд АХОТ өндөр байгаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс хөдөө аж ахуйн салбарт олноороо ажиллаж, оролцооны түвшин өндөр байгаатай (эрэгтэй 80.6 хувь, эмэгтэй 72.1 хувь) холбоотой. Харин хотод АХОТ хөдөөгийнхөөс 20 пунктээр доогуур буюу эрэгтэйчүүдийнх 60.6 хувь, эмэгтэйчүүдийнх 52.6 хувь байна.

5.7 Хүснэгт 35-аас харахад АХОТ судалгааны 1 дүгээр улиралд 66.6 хувь, харин 2, 3, 4-р улиралд ойролцоо буюу 65.0 хувьтай байна. Судалгааны 1 дүгээр улиралд ажилгүйчүүдийн тоо болон ажилгүйдлийн түвшин аль аль нь хамгийн өндөр гарсан. Зураг 3-д АХОТ-г нийт дүнгээр болон хүйсээр харуулав.

Зураг 3.

Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, улирлаар



Насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшин

5.8 Ажиллах хүчний оролцооны түвшин хоорондоо ямар ялгаатай байгааг харуулах зорилгоор насны бүлэг дэх оролцооны түвшинг 5 насны бүлгээр тооцож гаргадаг. Үүний дагуу 5 ба түүнээс дээш насны хүмүүсийг 5 насны бүлэгт хуваан ажиллах хүчний оролцооны түвшинг нийт дүнгээр болон хүйсээр задаргаа хийн тооцов. Харин хүснэгт 36-д 15, түүнээс дээш насны хүн амын АХОТ-г нийт дүнгээр үзүүлэв. Ажиллах хүчний оролцооны түвшин 15 -17 насанд 21.0 хувьтай байснаа даруй өсч, 25-29 насанд 83.0 хувь хүрч байна. 25-49 насанд энэ түвшин 80-90 хувьтай, харин түүнээс дээшхи насанд буурч эхэлж байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин ерөнхийдөө өндөр байгаа нь улсын хэмжээний ажиллах хүчний оролцооны түвшинд нөлөөлсөн. Бүх насны бүлэгт эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа бөгөөд хөдөө орон нутагт эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хот, суурингийнхаас өндөр гарч байна. Хөдөөгийн эрэгтэйчүүдийн АХОТ 25-49 насны хоорондох

бүлэгт 90-ээс дээш хувь, харин 35-39 насанд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хот, хөдөө аль алинд нь хамгийн өндөр байгаа нь сонирхол татаж байна. Энэ нь эмэгтэйчүүд залуу насандаа сурч боловсрох, гэрийн ажил



хийх, хүүхэд төрүүлж байдагтай холбоотой байж болох юм (Зураг 4,5-ыг үзнэ үү).


Насны бүлэг	Улсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
15-17	21.0	24.9	17.1	6.6	7.8	5.4	39.2	46.3	31.9
18-19	42.8	47.5	37.6	22.1	25.3	18.8	68.2	73.7	62.0
20-24	64.4	69.0	59.8	46.2	52.2	40.4	85.8	88.0	83.5
25-29	83.0	87.7	78.6	74.5	81.1	68.6	91.5	93.8	89.2
30-34	86.2	90.3	82.4	82.3	86.9	78.4	90.8	94.0	87.5
35-39	88.8	91.3	86.5	86.9	89.7	84.5	91.4	93.5	89.4
40-44	87.0	89.6	84.7	84.4	86.9	82.2	90.8	93.3	88.4
45-49	84.9	88.2	81.6	81.8	85.8	77.8	88.8	91.4	86.4
50-54	69.9	81.8	59.4	64.4	75.9	54.3	77.4	89.9	66.3
55-59	51.4	69.5	35.1	41.4	60.4	26.1	65.2	80.4	49.1
60-64	31.2	37.2	24.4	20.4	24.5	15.6	46.5	56.1	36.3
64-69	24.2	31.6	17.4	12.4	21.2	5.0	37.0	41.7	32.2
70 +	9.6	12.0	7.6	2.7	4.5	1.4	19.1	21.0	17.2
Улсын дундаж	65.3	69.7	61.1	56.4	60.6	52.6	76.3	80.6	72.1

Хүснэгт 36.

15, түүнээс дээш насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин тухайн насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр


Зураг 4.

Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр



Зураг 5.

Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр



5.9 Зураг 4-д насны бүлэг дэх АХОТ-г харуулав. Энэ зургаас харахад 25-49 насанд ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэй, эмэгтэй хүмүүст адилхан өндөр гарч, 90.0 хувьд хүрсэн байна. Эдгээр насны бүлэгт эмэгтэйчүүдийн оролцооны түвшин ерөнхийдөө өндөр, эрэгтэйчүүдийнхтэй харьцуулбал бага зэрэг доогуур байна.

5.10 Хөдөөгийн эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин өндөр байгаа нь улсын хэмжээний АХОТ-нд нөлөөлж байна. Хөдөө орон нутагт энэ түвшин өндөр байгаа тул тухайн үед эдийн засгийн идэвхигүй хүн ам нь хот, суурингийн эдийн засгийн идэвхигүй хүн амаас доогуур, түүний тэн хагаст ч хүрэхгүй байна. Хөдөө орон нутагт АХОТ хотынхоос өндөр байгаа нь өрхийн аж ахуйд суурилсан

нүүдлийн мал аж ахуйн онцлог, мөн сургууль боловсролын үйлчилгээний хүртээмж харьцангуй бага байдагтай холбоотой байж болох юм.

5.11 5-17 насны хүүхдүүдийн ажиллах хүчний оролцооны түвшингээс харахад (хүснэгт 37-г үзнэ үү) хөдөө орон нутагт 5-14 насныханд энэ түвшин 12.9-14.8 хувьтай, тэгэхдээ эрэгтэй хүүхдийн оролцооны түвшин арай өндөр гарч байна. Хөдөө орон нутагт 15-17 насны эрэгтэй хүүхдийн ажиллах хүчний оролцооны түвшин 46.3 хувь хүртэл нэмэгджээ. Харин хот, суурин газрын эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ажиллах хүчний оролцооны түвшин 5-14 насанд 3.0 хүрэхгүй хувьтай, 15-17 насанд 8.0 орчим хувь болж байна.

Насны бүлэг	Улсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
5-9	7.2	8.3	6.1	0.6	0.7	0.5	12.9	14.8	10.9
10-14	7.4	9.2	5.6	1.8	2.5	1.1	14.8	18.1	11.4
15-17	21.0	24.9	17.1	6.6	7.8	5.4	39.2	46.3	32.0
5-17	10.8	12.8	8.7	2.8	3.4	2.1	20.0	23.6	16.2

Хүснэгт 37.
5-17 настай хүүхдүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр


Эдийн засгийн идэвхигүй хүн ам

5.12 Сүүлийн 7 хоногт ажил хийгээгүй, ажил хайгаагүй, харин гэрийн ажилтай, өндөр насны тэтгэвэрт, сургуульд суралцдаг болон бусад шалтгааны улмаас идэвхигүй байсан нийт хүн амыг тухайн үеийн эдийн засгийн идэвхигүй хүн ам буюу ажиллах хүчнээс гадуурх хүн амд оруулдаг. Иймд сүүлийн 7 хоногт наад зах нь 1 цаг ажил хийгээгүй /эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй/, ажлын байргүй, ажил хийхэд бэлэн бус байсан хүмүүсийг тухайн үеийн эдийн засгийн идэвхигүй хүн амд тооцов.

5.13 Судалгаагаар нийт 534,400 хүн /227,400 эрэгтэй, 307,000 эмэгтэй/ тухайн үед эдийн засгийн идэвхигүй байна.

Зураг 6.

15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхигүй хүн амын бүтэц, шалтгаанаар



Эдийн засгийн идэвхигүй хүмүүсийн 372,500 нь хот, суурин газарт, 161,900 нь хөдөө орон нутагт байв. Хөдөө орон нутагт ажиллах хүчний оролцооны түвшин өндөр байгаа нь тухайн үеийн эдийн засгийн идэвхигүй хүн амын тоог бууруулахад нөлөөлжээ. Тухайн үеийн эдийн засгийн идэвхигүй байдлыг гэрийн ажилтай, сургуульд суралцдаг, өндөр насны тэтгэвэр, тахир дутуу, ажил хийхийг хүсээгүй, хүүхэд асардаг, өвчтэй байсан, хөдөлмөрийн насанд хүрээгүй, бусад гэсэн шалтгаанаар ангилан харуулав.

5.14 Нийт эрэгтэйчүүдийн 42.3 хувь, эмэгтэйчүүдийн 36.0 хувь нь сургуульд суралцаж байгаа гэж хариулсан нь эдийн засгийн идэвхигүй байгаагийн үндсэн шалтгаан болж байна. Эрэгтэйчүүдийн 26.0 хувь, эмэгтэйчүүдийн 30.4 хувь өндөр настай буюу тэтгэвэрт гарсан, 7.1 болон 12.4 хувь нь гэрийн ажилтай тул эдийн засгийн идэвхигүй байна. Хот, суурин газарт эдийн засгийн идэвхигүй байдлын үндсэн шалтгаан нь сурч боловсрох явдал /42.5 хувь/ байхад хөдөө орон нутагт өндөр насны тэтгэвэр /32.2 хувь/ зонхилох шалтгаан болжээ. Хот, суурин газрын эдийн засгийн идэвхигүй эрэгтэй хүн амын 46.4 хувь нь суралцаж буй тул ажил хийдэггүй, хийх боломжгүй гэж хариулжээ. Хүснэгт 38-аас үзэхэд хөдөө орон нутгийн эдийн засгийн идэвхигүй эмэгтэй хүн амын 20.9 хувь нь гэрийн ажилтай эсвэл хүүхэд асардаг тул ажил хийдэггүй, хийх боломжгүй гэж хариулсан. Ийнхүү эдийн засгийн идэвхигүй байгаагийн гол шалтгаануудад сургуульд суралцдаг, өндөр настай буюу тэтгэвэрт байгаа хоёр орж байна.

Шалтгаан	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэрийн ажил	10.2	7.1	12.4	8.8	5.6	11.3	13.2	10.7	15.0
Суралцдаг	38.7	42.3	36.0	42.5	46.4	39.5	30.0	32.3	28.3
Тэтгэвэр, өндөр настан	28.5	26.0	30.4	26.9	24.4	28.8	32.2	29.8	33.9
Тахир дутуу	5.1	6.4	4.0	4.7	6.2	3.6	5.8	7.0	4.9
Ажил хийхэд бэлэн бус	2.2	3.3	1.4	2.4	3.8	1.3	1.8	2.3	1.5
Хүүхэд асарсан	4.6	0.5	7.6	5.0	0.5	8.4	3.6	0.3	5.9
Өвчтэй байсан	2.9	3.5	2.4	2.8	3.5	2.3	3.0	3.3	2.7
Хөдөлмөрийн нас хүрээгүй	1.1	1.3	1.0	0.9	1.2	0.6	1.7	1.5	1.7
Бусад	6.7	9.6	4.8	6.0	8.4	4.2	8.7	12.8	6.1
Дүн %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	534,400	227,400	307,000	372,500	160,900	211,600	161,900	66,500	95,400

Хүснэгт 38.

15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхигүй хүн амын дүнд эзлэх хувь, идэвхигүй байгаа шалтгаан, хүйс, байршлаар

б ү л э г 6

ТУХАЙН ҮЕИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ



Бүлэг 6

ТУХАЙН ҮЕИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Ажил эрхлэлт

6.1 Ажиллах хүчний судалгаа нь Монгол Улсын хүн амын ажил эрхлэлтийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах зорилгыг агуулсан. Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдээс сүүлийн 7 хоногт эрхэлсэн ажил, түүнд хичнээн цаг зарцуулсан талаар асуув. Түүнчлэн өвчтэй, амралтаа авсан, чөлөөтэй байсан, цаг агаарын бэрхшээл, ажил хаялт, хөдөлмөрийн маргаан болон бусад шалтгааны улмаас ажлын байртай боловч сүүлийн 7 хоногт ажлаа хийгээгүй хүмүүсийг дээрх асуултаудад хамруулсан. Сүүлийн 7 хоногт наад зах нь нэг цаг ажилласан, эсвэл сүүлийн долоо

хоногт ажлын байртай боловч ямар нэг шалтгаанаар ажлаа түр хийгээгүй хүмүүсийг тухайн үед ажил эрхэлсэн гэж үзэв.

6.2 Улсын хэмжээнд нийт 897,100 хүн тухайн үед ажил эрхэлж, түүнээс 34,600 нь 6 сараас дээш хугацаанд өрхөөс гадуур амьдарч байв. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор нийт ажил эрхэлдэг хүн амын тоо 779,100 гэж гарчээ. Дор танилцуулж буй хүснэгтэнд тухайн үед ажил эрхэлсэн хүн амыг тооцохдоо өрхөөс гадуур амьдарч байгаа 34,600 хүнийг оруулаагүй болно.

Байршил/ бүс нутаг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	тоо	%	тоо	%
Хот	392,300	45.5	199,900	44.5	192,400	46.5
Хөдөө	470,200	54.5	249,000	55.5	221,200	53.5
Төв	167,300	19.4	86,600	19.3	80,700	19.5
Зүүн	68,200	7.9	36,400	8.1	31,800	7.7
Баруун	175,700	20.4	93,200	20.8	82,500	19.9
Хангай	233,300	27.0	122,000	27.2	111,300	26.9
Улаанбаатар	218,000	25.3	110,700	24.7	107,300	25.9
Дүн	862,500	100.0	448,900	100.0	413,600	100.0

Хүснэгт 39.

Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр

6.3 Хүснэгт 39-д сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн хүн амыг хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр харуулав. Тухайн үеийн ажиллагчдын 45.5 хувь нь хот, суурин газарт байгаа бөгөөд ажил эрхэлсэн хүний тоо бүс нутгуудаар ихээхэн ялгаатай байна. Ажил эрхэлсэн нийт хүмүүсийн дөрөвний нэгээс илүү хувь нь нийслэл хотод байна. Бүсээр авч үзэхэд Хангайн бүсэд ажиллагчдын тоо илүү өндөр буюу 27.0 хувьтай байхад Зүүн бүс нутагт 8.0 хүрэхгүй хувьтай байна. Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тоо ойролцоо гарчээ.

хөдөө аж ахуй болон хөдөө аж ахуйн бус салбарт ажиллах хүчний эрэлт улирлаар хэлбэлзэж байгаатай холбоотой юм.

Тухайн үеийн ажил эрхлэлт, улирлаар

6.4 Судалгааны 1 дүгээр улиралд ажил эрхэлсэн хүний тоо 822,300 (Хүснэгт 40) байсан бол судалгааны 4 дүгээр улиралд 83,7 мянгаар өсч, 906,000 болсноос эрэгтэйчүүд нь 37,1 мянга эмэгтэйчүүд нь 46,6 мянгаар тус тус өссөн байна. Энэхүү өсөлт нь голчлон хөдөө орон нутагт ажиглагдаж,



Байршил/бүс нутаг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
1-р улирал	822,300	100.0	433,900	52.8	388,400	47.2
2-р улирал	838,700	100.0	435,000	51.9	403,700	48.1
3-р улирал	885,600	100.0	455,900	51.5	429,700	48.5
4-р улирал	906,000	100.0	471,000	52.0	435,000	48.0
Судалгааны хугацаанд	862,500	100.0	448,900	100.0	413,600	100.0


Хүснэгт 40.

Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, хүйсээр

Ажиллагчдын тоог улирлаар тооцохдоо 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа хүмүүсийг оруулсныг Зураг 7-д үзүүлэв.

Зураг 7.

Ажиллагчдын тоо, улирлын тооцоогоор



Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

6.5 Тухайн үеийн ажиллагчдын тоог, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар гаргаж Хүснэгт 41-д үзүүллээ. Нийт ажил эрхэлсэн хүн амын 46.7 хувь буюу 402,700 түүний дотор 216,500 эрэгтэй, 186,200 эмэгтэйчүүд хөдөө аж ахуй, загас агнуурын аж ахуйн салбарт ажилласан байна. Мөн бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн засвар үйлчилгээний салбарт ажиллагчид нилээд хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл нийт ажил эрхлэгчдийн 11.4 хувь буюу 98,100 нь энэ салбарт ажиллаж байна. Эдгээрийн дараа боловсролын салбар /7.3 хувь/, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо /5.9 хувь/, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал /6.0 хувь/ зэрэг салбарууд илүү өндөр хувь эзэлж байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбарт нийт ажиллагчдын ердөө 5.4 хувь нь л ажиллажээ. Уул, уурхайн олборлох аж үйлдвэрийн салбарт нийт 23,300 хүн ажилласан байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	402,200	46.6	216,500	48.2	185,700	45.0
Загас агнуур	500	0.1	250	0.1	250	0.1
Уул уурхайн олборлох аж үйлдвэр	23,300	2.7	11,650	3.8	11,650	1.5
Боловсруулах аж үйлдвэр	46,200	5.4	23,100	4.7	23,100	6.1
Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж	15,800	1.8	7,900	2.5	7,900	1.1
Барилга	17,500	2.0	8,750	2.9	8,750	1.1
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ	98,100	11.4	49,050	9.6	49,050	13.3
Зочид буудал, зоогийн газар	13,700	1.6	6,850	1.0	6,850	2.2
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	51,000	5.9	25,500	8.4	25,500	3.2
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	6,300	0.7	3,150	0.7	3,150	0.8
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнес	10,100	1.2	5,050	1.4	5,050	1.0
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал	52,100	6.0	26,050	7.8	26,050	4.2
Боловсрол	63,300	7.3	31,650	4.5	31,650	10.4
Эрүүл мэнд, нийгмийн халамж	38,000	4.4	19,000	1.9	19,000	7.1
Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	22,300	2.6	11,150	2.4	11,150	2.7
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	900	0.1	450	0.1	450	0.1
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	1200	0.1	600	0.1	600	0.1
Дүн, %		100.0		100.0		100.0
Тоо	862,500		448,900		413,600	

Хүснэгт 41.

Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангиллаар

6.6 Хүснэгт 42-т тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоог ажил мэргэжлийн ангилалаар гаргаж харуулав. Нийтдээ

33,300 хүн хууль тогтоогч, удирдах ажилтан, менежерийн ажил хийсэн нь нийт ажилласан хүмүүсийн 3.9 хувьтай тэнцэж байна. Ажил хийсэн найман хүний нэг нь

мэргэжилтэн байна. Улсын хэмжээгээр нийт 103,300 мэргэжилтэн байгаагийн дийлэнх буюу 66,000 нь эмэгтэйчүүд байна. Нийт ажил хийсэн хүмүүсийн ихэнх буюу

392,000 /45.4 хувь, үүний 181,000 нь эмэгтэй/ нь хөдөө аж ахуйн болон загасны аж ахуйн холбогдолтой ажил эрхэлсэн байна.

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд		Эрэгтэй	Эмэгтэй
	Тоо	%	%	%
Хууль тогтоогч, удирдах ажилтан, менежер	33,300	3.9	5.0	2.6
Мэргэжилтэн	103,300	12.0	8.2	16.1
Инженер техникийн ажилтан	40,600	4.7	3.5	6.0
Бичиг хэргийн туслах ажилтан	17,600	2.0	1.1	3.1
Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч	97,600	11.3	8.0	14.9
ХАА ба загасны аж ахуйн мэргэшсэн ажилчин	392,000	45.4	47.0	43.8
Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	68,200	7.9	9.9	5.7
Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	56,400	6.5	11.6	1.1
Энгийн ажил	51,200	5.9	5.3	6.6
Бусад	2,300	0.4	0.4	0.1
Дүн, %		100.0	100.0	100.0
Тоо	862,500		448,900	413,600

Хүснэгт 42.

Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар

Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр, зах зээл дээр худалдаа эрхлэгчид нийт ажил эрхлэгчдийн 11.3 хувийг эзэлж байгаагийн дотор дийлэнх нь буюу 62,000 нь эмэгтэйчүүд байна. Үйлдвэрийн ба худалдааны чиглэлээр 68,200 хүн, машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагчаар 56,400 хүн ажилласан нь нийлээд сүүлийн 7 хоногт ажил хийсэн хүн амын 14.0 хувийг бүрдүүлжээ.


нийлээд 338,000/165,800 эрэгтэй, 172,800 эмэгтэй/ хүн байна (Хавсралт 1-ийн хүснэгт 10-аас харна уу). Зураг 8-аас харахад нийт ажиллагчдын зөвхөн 3.1 хувь нь иргэний гэрээгээр ажиллаж байна. Ажиллагчдын гуравны нэгээс илүү хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, дөрөвний нэг нь өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч байгаа бөгөөд энэ хоёр ангиллын хүмүүс нийлээд ажил эрхэлсэн хүн амын бараг 60.0 орчим хувийг эзэлж байна. Ажил хийсэн эмэгтэй хүн амын 31.0 хувь буюу 131,900 нь өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч байна. Түүнчлэн ажил олгогч нарын эзлэх хувь бага буюу 0,5 хувьтай л тэнцэж байгаа нь сонирхол татаж байна. Эндээс харахад жижиг, дунд оврын бизнесийн үйл ажиллагааны хэмжээ, тархалт бага байна.

Ажиллагчдын тоо, ажил эрхлэлтийн байдлаар

6.7 Ажил эрхлэлтийн байдлыг цалин хөлстэй ажил буюу хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч, иргэний гэрээгээр ажиллагч зэрэг нийт 7 ангилалд хуваав. Нийт ажиллагчдын таван хүний хоёр нь гэрээгээр ажиллагч байгаа бөгөөд

Зураг 8.

Тухайн үеийн ажиллагчдын ажил эрхлэлтийн байдлын бүтэц, хувиар



Ажиллагчдын тоо, байгууллагын төрлөөр

6.8 Хүснэгт 43-т ажиллагчдын тоог байгууллагын төрөл, бүс нутаг, хот, хөдөөгөөр харуулав. Нийт ажиллагчдын 56.1

хувь буюу 484,000 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч аж ахуйд, 10.0 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид ажиллаж байна. Нийт ажиллагчдын таван хүний нэг

(170,000) нь төрийн, төсөвт байгууллагад ажиллажээ. Төрийн, төсөвт байгууллагад ажиллагчдын арван хүний гурав нь хотод, нэг нь хөдөө орон нутагт ажиллаж байна. Хөдөө орон нутгийн нийт ажил эрхэлж буй хүн амын 80.0

хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид бүрдүүлж байна. Улаанбаатар хотод ажиллагчдын бараг гуравны нэг нь төрийн, төсөвт байгууллагад, арван хүний гурав нь ХХК-д ажиллаж байна.

Байгууллагын төрөл	Бүгд		Байршил/бүс нутаг						
	Тоо	%	Хот	Хөдөө	Төв	Зүүн	Баруун	Хангай	УБ
ХЭАА	33,100	3.8	2.9	4.6	5.7	1.5	1.3	7.6	1.2
Нөхөрлөл	2,600	0.3	0.6	0.1	0.2	0.3	0.1	0.3	0.6
Хоршоо	4,500	0.5	0.5	0.5	0.5	0.7	0.9	0.4	0.3
Хувьцаат компани	39,000	4.5	8.6	1.2	5.7	3.9	1.5	2.5	8.4
ХХК	84,000	9.7	19.4	1.7	6.1	2.8	2.2	2.3	28.8
УУГ	32,200	3.7	7.1	0.9	6.2	3.9	1.1	3.8	3.9
Төрийн төсөвт байгууллага	170,000	19.7	30.5	10.7	18.3	18.3	14.2	14.6	31.2
Төрийн бус байгууллага	13,100	1.5	3.0	0.3	1.8	0.7	0.6	0.6	3.3
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	484,000	56.1	27.4	80.0	55.6	67.9	78.1	68.1	22.3
Дүн, %		100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	862,500		392,300	470,200	167,300	68,300	175,600	233,300	218,000

Хүснэгт 43.

Тухайн үед ажил эрхэлсэн 15, түүнээс дээш насны хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, бүс нутгаар

Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангиллаар

6.9 Хүснэгт 44-д тухайн үед ажил эрхэлсэн хүн амыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар болон ажил мэргэжлийн



үндсэн ангиллаар бүлэглэн тооцов. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрээр хичнээн хүн ямар ажил мэргэжлийн ажил эрхэлсэн байв гэдгийг тодруулахыг зорьсон. Хэдийгээр ХАА, ан агнуур, ойн аж ахуйн салбарт нийт ажиллагчдын 46.6 хувь ногдож байгаа боловч энэ салбарт мэргэжилтэнүүдийн эзлэх хувь дөнгөж 0.8 хувь байна. Түүнчлэн хууль тогтоогч, удирдах ажилтан, менежерүүдийн дөрвөн хүн тутмын нэг, мэргэжилтэнүүдийн 11.6 хувь, инженер техникийн ажилтаны 24.6 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарт ажиллаж байна. Боловсролын салбарт мэргэжилтэн гурван хүн тутмын нэг, инженер, техникийн ажилтан найман хүн тутмын нэг нь байна. Доорх хүснэгтийг өнөө үед эдийн засгийн салбарт ажиллах хүчин хэрхэн хуваарилагдан ажиллаж байгаа талаар мэдээлэл өгөх зорилгоор боловсрууллаа.

Хүснэгт 44.

Тухайн үед ажил эрхэлсэн хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар

	Бүгд		Хууль тогтоогч, удирдах ажилтан, менежер	Мэргэжилтэн	Инженер, техникийн ажилтан	Туслах ажилтан	Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч	ХАА ба загасны аж ахуйн мэргэшсэн ажилтан	Үйлдвэр, худалдааны ажилтан	Машин тоног тохөөрөмжийн операторч, угсрагч	Энгийн ажил мэргэжил
	Тоо	%									
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	402,200	46.6	2.0	0.8	0.8	2.3	1.3	98.9	1.2	3.5	15.9
Загас агнуур	500	0.1	0.0	0.0	0.1	0.1	0.0	0.0	0.1	0.1	0.4
Уул уурхай, олборлох үйлдвэр	23,300	2.7	4.1	2.1	2.0	3.1	1.4	0.1	16.0	5.9	4.2
Боловсруулах үйлдвэр	46,200	5.4	10.1	3.6	3.3	7.2	2.2	0.2	40.6	5.5	5.5
Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж	15,800	1.8	2.6	2.4	1.8	5.2	0.2	0.0	8.7	4.6	3.6
Барилга	17,500	2.0	2.3	2.2	1.5	2.4	0.5	0.0	14.4	3.3	2.3
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	98,100	11.4	19.4	4.2	8.7	8.8	61.7	0.5	5.4	4.6	25.6
Зочид буудал, зоогийн газар	13,700	1.6	4.1	0.5	0.0	1.6	9.3	0.0	0.8	0.7	2.7
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	51,000	5.9	5.7	3.7	5.5	22.8	3.1	0.0	4.0	50.8	8.3
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	6,300	0.7	3.2	2.7	2.2	5.1	0.3	0.0	0.0	0.1	0.6
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнес	10,100	1.2	2.6	3.6	4.2	3.0	0.7	0.0	1.4	1.2	1.6
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал	52,100	6.0	26.8	11.6	24.6	18.1	6.6	0.1	3.0	8.3	8.3
Боловсрол	63,300	7.3	7.3	37.9	15.9	10.7	4.7	0.0	1.5	4.2	10.2
Эрүүл мэнд, нийгмийн халамж	38,000	4.4	2.2	18.0	23.5	3.4	3.2	0.0	1.0	4.3	4.1
Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	22,300	2.6	7.6	6.1	5.7	5.7	4.3	0.0	1.9	2.5	5.9
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	900	0.1	0.1	0.1	0.1	0.0	0.5	0.0	0.0	0.1	0.5
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	1,200	0.1	0.0	0.6	0.1	0.6	0.1	0.0	0.0	0.2	0.2
Дүн, %		100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	862,500		33,300	103,300	40,600	17,600	97,600	392,000	68,200	56,400	53,500

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд		Эрэгтэй	Эмэгтэй
	Тоо	%	%	%
Хууль тогтоогч, удирдах ажилтан, менежер	1,000	4.0	5.0	2.5
Мэргэжилтэн	2,200	9.4	7.9	11.7
Инженер техникийн ажилтан	900	3.8	3.0	5.1
Бичиг хэргийн туслах ажилтан	300	1.3	1.2	1.4
Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч	4,500	18.8	13.6	26.9
ХАА ба загасны аж ахуйн мэргэшсэн ажилчин	7,200	30.1	29.7	30.7
Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	3,800	15.7	16.5	14.5
Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	2,700	11.5	17.5	2.0
Энгийн ажил мэргэжил	1,200	5.2	5.5	4.7
Бусад	100	0.2	0.0	0.6
Дүн	23,900	100.0	100.0	100.0

Хүснэгт 45.

Давхар ажил эрхэлж буй хүн амын тоо, ажил мэргэжлийн ангилал, хүйсэр

Давхар ажил эрхлэлт

6.10 Судалгаагаар үндсэн ажлын хажуугаар давхар ажил эрхэлж буй хүн амын талаар мэдээлэл цуглуулсан. Нийт 23,900 хүн давхар ажил эрхэлж байгаа нь нийт хүний 3.0 хувьтай л тэнцэж байна. Үндсэн ажлын цаг урт, хатуу хүнд цаг агаар, эдийн засгийн өнөөгийн бүтэц зэргийн улмаас давхар ажил эрхлэх бололцоо хязгаарлагдмал байж

болзошгүй. Давхар ажил хийж буй хоёр хүний нэг нь үйлчилгээний ажилтан, дэлгүүр, зах зээл дээр худалдаа наймаа эрхлэгч, хөдөө аж ахуйн холбогдолтой ажил хийж буй хүмүүс байна. Түүнчлэн 2,200 хүн мэргэжилтэнээр, 1,000 хүн хууль тогтоогч, ахлах ажилтан, менежерийн ажлыг давхар хашсан байна.

Бүрэн бус ажил эрхлэлт

6.11 ОУХБ-ын 13-р Бага Хурлаас баталсан эдийн засгийн идэвхитэй хүн амын статистик тоо мэдээг гаргах тухай тогтоолд бүрэн бус ажил эрхлэлтийг дараах байдлаар тодорхойлжээ. Ажил мэргэжлийн түвшин, ур чадвартай (эзэмшсэн боловсрол, туршлага)-тай нь харьцуулахад доогуур түвшний ажил эсхүл тогтоосон норм (ажлын цаг)-д хүрэхгүй хэмжээнд ажил эрхэлж байвал бүрэн бус ажил эрхлэлт гэж үзнэ. Бүрэн бус ажил эрхлэлт нь ил, далд хоёр хэлбэрээр илэрнэ.

6.12 Ил хэлбэр нь ажиллах хүч болон бусад судалгаагаар шууд хэмжигддэг статистик ойлголт бөгөөд ажиллах хүчний нөөцийг оновчгүй хуваарилсан эсвэл хөдөлмөр болон бүтээгдэхүүний зөрүүг илтгэдэг. Иймд практик утгаар нь ил хэлбэрийн бүрэн бус ажил эрхлэлтийг л статистик аргачлалаар хэмжин тооцож болох юм.

6.13 ОУХБ-ын тодорхойлолтоор тогтоож өгсөн нормоос цөөн цагаар ажиллахад хүрч, улмаар нэмэгдэл ажил хийх боломжтой, нэмэгдэл ажил хайж буй цалин хөлстэй ажил эрхэлж буй хүмүүс, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг ил хэлбэрийн бүрэн бус ажил эрхэлж байна гэж үздэг.

6.14 Ил хэлбэрийн бүрэн бус ажил эрхлэлтийг хэмжихэд хоёр үзүүлэлтийг ашигладаг. Үүнд:
 - Ил хэлбэрээр бүрэн бус ажил эрхэлж буй хүмүүсийн тоо
 - Ил хэлбэрийн бүрэн бус ажил эрхлэлтийн тоо хэмжээ

6.15 Хүн амын ажил эрхлэлтийн талаар иж бүрэн дүр зурагтай болохын тулд нэмэгдэл ажил хийх хүсэл боломжтой байсан эсэх талаарх мэдээллийг цуглуулсан. Энэ асуултыг

сүүлийн 7 хоногт ажил хийсэн 5 ба түүнээс дээш насны бүх хүнээс асуусан. Ил хэлбэрийн бүрэн бус ажил эрхлэлтийг тодорхойлохын тулд сүүлийн 7 хоногт хэдэн цаг ажилласныг харгалзан үзэж, зөвхөн тогтоосон нормоос цөөн цагаар ажилласан хүмүүсийг нэмэлт ажил хайх, хийх боломжтой гэж үзэн хамруулах ёстой байдаг. Урт цагаар ажилласан хүмүүс нэмэлт ажил хайсан байлаа ч ил хэлбэрийн бүрэн бус ажил эрхлэлтийг хэмжихэд оруулдаггүй. Энэ нь бүрэн бус ажил эрхэлсэн хүн амын тоог хөөрөгдөхөд хүргэдэгтэй холбоотой. Ийм хүмүүсийн олж буй орлого доогуур, тогтоож өгсөн нормоос цөөн цагийг үндсэн ажилдаа зарцуулж буй тул нэмэгдэл ажил хийх хүсэл, боломжтой байсан байж болох юм.

6.16 Судалгаагаар сүүлийн 7 хоногт нэмэгдэл ажил хийх боломжтой байсан эсэх, нэмэгдэл ажил хэрхэн хайсан талаар мэдээлэл цуглуулсан.

6.17 Хүснэгт 46-д нэмэгдэл ажил хийх боломжтой гэж хариулсан хүмүүсийг хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр харуулав. 58,200 хүн /34,400 эрэгтэй, 23,800 эмэгтэй/ нэмэгдэл ажил хийх боломжтой, улмаар өөрсдийгөө бүрэн бус ажил эрхэлж байна гэж үзжээ. Үүнээс харахад өөрсдийгөө бүрэн бус ажил эрхэлж байна гэж харьцангуй цөөхөн хүн үзэж байгаа бөгөөд нийт ажиллагчдаас нэмэлт ажил хайсан хүмүүсийн эзлэх хувь ердөө 6.7 хувь /эрэгтэйчүүдийнх 7.7 хувь, эмэгтэйчүүдийнх 5.8 хувь/ байна. Гэхдээ ингэж хариулсан хүмүүсийн дотор долоо хоногт 40-өөс илүү цаг ажилласан хүмүүс орж байгаа тул Монгол Улсад албан ёсоор мөрдөгдөж буй ажлын цагийн нормоос хэтэрсэн тохиолдолд хасаж тооцох ёстой.

Байршил/бүс нутаг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хот	20,800	35.7	11,800	34.3	9,000	37.9
Хөдөө	37,400	64.3	22,600	65.7	14,800	62.1
Төв	21,700	37.3	13,100	38.2	8,600	35.9
Зүүн	13,000	22.4	8,000	23.3	5,000	21.2
Баруун	12,800	21.9	7,600	22.0	5,200	21.7
Хангай	3,300	5.7	1,900	5.6	1,400	5.9
Улаанбаатар	7,400	12.7	3,800	10.9	3,600	15.3
Улсын дүн	58,200	100.0	34,400	100.0	23,800	100.0

Хүснэгт 46.
 Бүрэн бус ажил эрхлэлт, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр

6.18 Хүснэгт 47-д нэмэгдэл ажил хийх хүсэл, боломжтой хүн амын тоог ажил эрхлэлтийн байдал, хүйсээр харуулав. Бүрэн бус ажил эрхлэгчдийн 31.4 хувь буюу 18,300 нь гэрээгээр ажиллагч, ажил олгогч, болон хоршооллын

гишүүд байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч хүмүүс нийлээд нэмэгдэл ажил хайсан гурван хүн тутмын хоёрыг бүрдүүлж байна.

Ажил эрхлэлтийн байдал	Бүгд		Эрэгтэй	Эмэгтэй
	Тоо	%	%	%
Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч	16,300	28.0	23.7	34.3
Иргэний гэрээгээр ажиллагч	1,500	2.6	3.1	1.8
Ажил олгогч	400	0.7	0.9	0.5
Хоршооллын гишүүн	100	0.1	0.2	0.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	23,200	39.9	48.6	27.2
Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	16,600	28.6	23.5	36.0
Бусад	100	0.1	0.0	0.2
Дүн	58,200	100.0	100.0	100.0

Хүснэгт 47.


Бүрэн бус ажил эрхлэлт, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр

6.19 Ажиллаж байгаа хүмүүс хэдийгээр үндсэн ажилдаа 40-өөс илүү цагаар ажилласан боловч олж буй орлого нь бага тул нэмэлт ажил хайсан байж болох юм. Ажилласан цаг дээр үндэслэн энэ тооцоог хийхийн тулд 40-өөс илүү цаг ажилласан хүмүүсийг оруулахгүй хасах ёстой. Нэмэлт ажил

хайгаагүй шалтгааныг нэмэлт ажил хийх боломжгүй гэж хариулсан хүмүүсийн хариултаас тодруулав. Ингэснээр 40-өөс бага цаг ажилласан хүмүүсийг нэмэлт ажил хайсан, хайгаагүй гэж хоёр бүлэгт хувааж үзэх боломжтой болсон юм.

б ү л э г 7

АЖИЛГҮЙДЭЛ



Бүлэг 7

АЖИЛГҮЙДЭЛ

7.1 ОУХБ-аас зөвлөмж болгож буй ажилгүйдлийн талаарх тодорхойлолт нь ажлын байргүй, ажил хийх боломжтой, ажил хайж буй гэсэн 3 жишиг үзүүлэлтэнд тулгуурладаг. Хөдөлмөрийн зах зээл төлөвшөөгүй, зохион байгуулалтгүй, итгэл алдарсан ажилчид байдаг ядуу буурай орнуудад ажил хайх шалгуур үзүүлэлтийг нэг их хэрэглэдэггүй байна. Энэхүү АХС-нд ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа болон тухайн 7 хоногт ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөр идэвхитэй хайсан хүмүүсийг ажилгүй хүн амд тооцсон. Түүнчлэн ажил хөдөлмөр эрхэлдэггүй ч ажил эрхлэх боломжтой, гэхдээ ажил олдохгүй гэж бодсон, эсхүл өвчтэй, тахир дутуу, мөн ажилд орох өргөдлөө өгсөн, ярилцлаганд орохоор хүлээж байгаа зэрэг шалтгааны улмаас ажил хайгаагүй хүмүүсийг ажилгүй хүн амд оруулж тооцов.

7.2 2002-2003 оны АХС-ны ажилгүйдлийн талаарх тоо мэдээг бусад судалгааны тоо мэдээтэй шууд харьцуулж болохгүй юм. Энэ нь бусад судалгаанд хэрэглэж байгаагүй ОУХБ-ын тодорхойлолт, аргачлалыг АХС-нд мөрдсөнтэй холбоотой. Тухайлбал, 2000 оны ХАОСТ-т сүүлийн 7 хоногт ажлын байргүй, ажил хийгээгүй, тооллогын үед ажил хайж байгаа хүмүүсийг ажилгүй гэж тодорхойлсны дагуу нийт 164,900 хүнийг ажилгүй гэж тоолсон билээ. АХС-д мөрдсөн тодорхойлолт аргачлалын дагуу ажил хийх боломжтой боловч ажил олдохгүй гэсэн шалтгаанаар ажил хайгаагүй, итгэл алдарсан ажилчдыг хамруулах замаар тооллоготой харьцуулахад ажилгүйчүүдийн тоог нэлээд өргөн хүрээнд тооцсон. Харин хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан болон ажилгүйчүүдийн сарын мэдээнд ҮСГ-ын дарга, НХХЯ-ны сайдын 2002 оны 10 дугаар сарын 207/103 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хүн амын хөдөлмөр эрхлэлт болон

ажиллах хүчний тухай үндсэн ойлголт, тодорхойлолт"-ын дагуу хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай, хөдөлмөр эрхлэх боломжтой, аймаг, нийслэлийн ХЭА-нд бүртгүүлж ажил идэвхитэй хайж байгаа хүнийг ажилгүй хүн гэж тодорхойлж байгаа бөгөөд 2003 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 33,300 байна. Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан, ажилгүйчүүдийн сарын мэдээнд ажилгүйчүүдийн тоонд зөвхөн бүртгэлтэй ажилгүйчүүдийг хамруулдаг тул хамгийн бага гарч байна.

Ажилгүйчүүдийн тоо

7.3 Судалгааны дүнг тархаасан тооцоогоор сүүлийн 7 хоногт ажил хийх боломжтой, ажил хайсан ажилгүйчүүдийн тоо 142,300 /74,600 нь эрэгтэй, 67,700 нь эмэгтэй/-д хүрч ажилгүйдлийн түвшин 14.2 байгаа бөгөөд хүйсээр задлан харвал эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 14.2 хувь, эмэгтэйчүүдийнх 14.1 хувь байна. Хот, суурин газарт эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс ялимгүй өндөр байгаа боловч хөдөө орон нутагт доогуур байна.

Ажилгүйчүүдийн тоо, хот хөдөөгөөр

7.4 Нийт ажилгүйчүүдийн 60.0 гаруй хувь нь хотод төвлөрчээ. Ялангуяа хот, суурин газарт эрэгтэйчүүдийн дунд ажилгүйдлийн түвшин илүү их, ойролцоогоор ажилгүй гурван хүний хоёр нь эрэгтэй байна. Ажилгүйдлийг бүс нутгаар авч үзвэл дөрвөн ажилгүй хүний нэг нь төвийн бүсэд, нийт ажилгүйчүүдийн зөвхөн 10.8 орчим хувь нь зүүн бүсэд байна. Нийт ажилгүйчүүдийн 22.0 орчим хувь буюу 31,200 ажилгүй хүн Улаанбаатар хотод байна. Ажилгүйдлийн түвшинг бүс нутгаар харахад эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байна.

Байршил /Бүс нутаг	Ажилгүйчүүдийн тоо						Ажилгүйдлийн түвшин		
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	%	%	%
Хот	90,300	63.5	47,900	64.2	42,400	62.7	18.7	19.3	18.1
Хөдөө	52,000	36.5	26,700	35.8	25,300	37.3	10.0	9.7	10.3
Төв	37,300	26.2	20,700	27.8	16,600	24.5	18.2	19.3	17.1
Зүүн	15,400	10.8	8,100	10.8	7,300	10.8	18.4	18.2	18.6
Баруун	21,200	14.9	10,500	14.0	10,700	15.9	10.8	10.1	11.5
Хангай	37,200	26.1	18,200	24.4	19,000	28.0	13.7	13.0	14.6
Улаанбаатар	31,200	22.0	17,100	23.0	14,100	20.8	12.5	13.4	11.6
Дүн	142,300	100.0	74,600	100.0	67,700	100.0	14.2	14.2	14.1

Хүснэгт 48.


Ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшин, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр

Ажилгүйдлийн түвшин

7.5 Ажил эрхлээгүй хүн амаар тооцсон ажилгүйдлийн түвшин судалгааны 1 дүгээр улиралд 18.0 хувь байснаа цаашид буурч 2, 3, 4-р улиралд 15.0, 13.2, 10.7 хувь болсон байна.

Ажилгүйдлийн түвшинг ийнхүү буурахад ажиллах хүчний улирлын хэлбэлзэл нөлөөлсөн. Зураг 9-өөс 2002 оны 10 дугаар сараас 2003 оны 9 дүгээр сарыг дуусталх хугацаанд 4 улирлын туршид ажиллах хүчний үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдсөнийг харж болох юм.

Зураг 9.
Ажилгүйдлийн түвшин, улирлаар



Түүнчлэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшингийн хоорондын ялгааг улирлаар харахад ойролцоо хувьтай байгаа юм.

Байршил/Бүс нутаг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Ажилгүйчүүдийн тоо			
Улсын хэмжээнд	142,300	74,600	67,700
Хот	90,300	47,900	42,400
Хөдөө	52,000	26,700	25,300
Ажилгүйдлийн түвшин, %			
Улсын хэмжээнд	14.2	14.2	14.1
Хот	18.7	19.3	18.1
Хөдөө	10.0	9.7	10.3
1-р улирал			
Улсын хэмжээнд	18.0	17.8	18.2
Хот	22.0	23.1	20.7
Хөдөө	14.0	12.6	15.6
2-р улирал			
Улсын хэмжээнд	15.0	15.4	14.5
Хот	19.4	20.9	18.0
Хөдөө	10.8	10.6	11.1
3-р улирал			
Улсын хэмжээнд	13.2	13.5	12.9
Хот	18.3	18.4	18.2
Хөдөө	8.6	9.1	8.1
4-р улирал			
Улсын хэмжээнд	10.7	10.4	10.9
Хот	15.1	14.8	15.4
Хөдөө	6.9	6.8	7.0

Хүснэгт 49.

Ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшин, хот, хөдөө, бүс нутаг, хүйсээр

Ажилгүйчүүдийн тоо, насны бүлгээр

7.6 Хүснэгт 50-д харуулсанаар нийт ажилгүйчүүдийн 57.3 хувийг 15-34 насны залуу хүмүүс, 35,9 хувийг 35-49 насныхан эзэлж байна. Эрэгтэй, эмэгтэй ажилгүйчүүдийн 18.4 хувь нь 20-24 насныхан байгаа бөгөөд ажилгүйчүүдийн тоо цаашид буурч, 45-49 насанд 12,100 болж байна. Эндээс харахад залуу хүмүүс ялангуяа ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орж буй хүмүүс ажилгүйдэлд илүүтэй өртөж байгаа ажээ.

7.7 Ажилгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн насны бүтэц ерөнхийдөө төстэй байна. Гэхдээ ажил эрхлээгүй өсвөр насны охид, хөвгүүдийн ажилгүйдлийн түвшин бусад насны ажилгүйчүүдийн түвшингээс өндөр байна. 15-17 насны эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 13.1 хувь, 18-19 насанд 25.3 хувь, харин 20-24 насанд 21.2 хувь болж буурч байна. Эрэгтэйчүүдийн хувьд ажилгүйдлийн түвшин 15-24 нас хүртэл өссөнөө 25 наснаас эхлэн эргээд буурч байна.

Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд ажилгүйдэлд нэрвэгдэж, 25-54 насанд тэдний ажилгүйдлийн түвшин 13-15 хувьд хүрчээ.

Ажилгүйдлийн ажилгүй байсан хугацаа

7.8 Хүснэгт 51-д харуулсанаар ажил эрхлээгүй хүмүүсийн дийлэнх нь богино хугацаагаар буюу таван ажилгүй хүний


Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй %	Эмэгтэй %
	Тоо	%		
15-17	4,400	3.1	3.3	2.8
18-19	9,300	6.5	6.8	6.3
20-24	26,200	18.4	18.8	17.9
25-29	21,400	15.0	15.0	15.1
30-34	20,400	14.3	13.8	15.0
35-39	22,300	15.7	13.0	18.7
40-44	17,000	12.0	11.7	12.3
45-49	12,100	8.5	9.6	7.3
50-54	5,600	3.9	4.9	2.8
55-59	2,000	1.4	1.6	1.1
60-64	1,200	0.9	1.2	0.6
65-69	300	0.2	0.2	0.1
70+	100	0.1	0.1	0.1
Дүн %		100.0	100.0	100.0
Тоо	142,300		74,600	67,700

Хүснэгт 50.

Ажилгүйдлийн насны бүтэц

Зураг 10.

Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр



бараг гурав нь сар хүрэхгүй хугацаанд ажилгүй байсан байна. Арван хоёр ажилгүй хүний нэг нь буюу 8.0 хувь нь 1 сараас 1 жилийн турш ажил хайж, гурван ажилгүй хүний нэг нь нэгээс илүү жилийн хугацаанд, түүн дотроо ажилгүйдлийн 22,8 гаруй хувь нь 3 жил илүүтэй хугацаанд ажилгүй байсан байна. Эндээс дүгнэхэд таван ажилгүй хүний нэг нь 3 жил гаруй ажлын байргүй, ажил хийгээгүй байна. Ажилгүй байсан хугацаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд нэг их ялгаагүй, нийт эрэгтэй ажилгүйдлийн 37,1 хувь, нийт эмэгтэйчүүдийн 32.9 хувь нь нэгээс илүү жилээр ажил хийгээгүй байна.

Ажилгүй байсан хугацаа	Улсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %
1 сар хүртэл	56.9	54.7	59.3	51.5	48.8	54.6	66.2	65.2	67.1
1-3 сар	2.0	2.1	1.8	2.1	2.3	1.7	1.9	2.0	1.9
4-6 сар	3.8	3.4	4.2	3.9	3.2	4.7	3.6	3.6	3.6
7-11 сар	2.3	2.7	1.8	3.0	3.5	2.5	1.0	1.3	0.7
1-2 жил	12.3	12.5	12.1	14.8	15.0	14.6	7.9	8.0	7.8
3+ жил	22.8	24.6	20.8	24.7	27.2	21.9	19.4	19.9	18.9
Дүн, %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	142,300	74,600	67,700	90,300	47,900	42,400	52,000	26,700	25,300

Хүснэгт 51.

Ажилгүйдлийн хөдөлмөр эрхлээгүй хугацаа, хот, хөдөө, хүйсээр

Ажилгүйдлийн боловсролын түвшин

7.9 Судалгааны тархаалтын тооцоогоор нийт ажилгүйдлийн дөрвөн хүний нэг нь тусгай мэргэжлийн дундаас дээш боловсролтой хүмүүс байна. Боловсролгүй,

бага боловсрол эзэмшсэн хүмүүс олдсон ажлыг голохгүй хийж байгаа тул тэдний дунд ажилгүйдлийн түвшин доогуур байна гэж үзэж болохоор байна. Хүснэгт 52-оос харахад

ажилгүй хүмүүсийн бараг 17.7 хувь тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус болон дээд сургуулийн дипломтой байна. Ажилгүй арван хоёр эрэгтэй хүний нэг нь дээд боловсрол эзэмшжээ. Энэ үзүүлэлтээр эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс арай өндөр буюу 10.0 хувийг эзэлж байна. Гэтэл ажилгүйчүүдийн дунд

боловсролгүй, бага боловсролтой хүний эзлэх хувь ердөө 9.0 хувь байна. 15, түүнээс дээш насны нийт хүн амын дунд боловсролгүй, бага боловсролтой хүмүүсийн эзлэх хувь 21,7 хувь байгаа нь ажилгүй нийт хүн амд ийм хүмүүсийн эзлэх хувиас даруй хоёр дахин их байна. (Хүснэгт 23-ыг үзнэ үү).

Боловсролын түвшин	Улсын хэмжээнд			Хот		Хөдөө	
	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Эрэгтэй %	Эмэгтэй %
Боловсролгүй	2.6	2.8	2.4	2.0	1.3	4.1	4.2
Бага	6.4	7.0	5.8	5.2	3.9	10.4	9.0
Бүрэн бус дунд	33.5	38.3	28.1	34.0	22.5	46.3	37.6
Бүрэн дунд	31.6	28.3	35.3	32.4	39.4	21.0	28.4
Техник мэргэжлийн анхан шатны	8.2	9.0	7.3	9.3	6.8	8.3	8.1
Тусгай мэргэжлийн дунд /бүрэн бус дээд	8.9	6.9	11.1	7.3	12.7	6.1	8.3
Дээд	8.8	7.7	10.0	9.8	13.4	3.8	4.4
Дүн, %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	142,300	74,600	67,700	47,900	42,400	26,700	25,300

Хүснэгт 52.

Ажилгүйчүүдийн боловсролын түвшин, хот, хөдөө, хүйсээр

Ажилгүйчүүдийн хийхийг хүсч байгаа ажил

7.10 Хүн амын ажил эрхлэлтийн байдалтай зэрэгцүүлж үзэхэд ажилгүйчүүдийн зүгээс ажил хийхийг хүсэж буй ажлууд ихээхэн ялгаатай байгааг Хүснэгт 53-т харуулав. Судалгаагаар ажилгүйчүүдийн зөвхөн 4,1 хувь нь хөдөө аж ахуй салбарт ажилламаар байна гэжээ. Ажил хийж буй хүн амыг ажил мэргэжлийн байдлаар харуулсан Хүснэгт 42-т нийт ажиллагчдын 45.0 хувь нь хөдөө аж ахуйн төрлийн ажил хийж байгаа бөгөөд эдгээр хүмүүс тэтгэвэрт гарах, нас барах үед ихэнх ажлын байр энэ салбарт чөлөөлөгдөн гарч болзошгүй юм. Ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орогчдын боловсролын түвшин өндөр болсон тул хөдөө аж ахуйн болон энгийн ажил хийхээсээ илүү худалдаа наймаа, үйлдвэр, үйлчилгээ, машин техникийн чиглэлээр ажиллах сонирхолтой болж байна. Эндээс харахад ажлын байр болон ажил хийх хүсэлтэй хүмүүсийн сонирхол, сонголт хоёрын хооронд зөрүү их байна. Ажилгүйчүүдийн 9,2 хувь буюу арван

нэгэн ажилгүй хүний нэг нь мэргэжлийн түвшинд ажиллах сонирхолтой байгаа бөгөөд ялангуяа ийм сонирхолтой эмэгтэйчүүдийн хувь өндөр, 13.0 хувьтай байна. Ажилгүйчүүдийн 19.3 хувь нь үйлчилгээ, худалдааны ажил хийх хүсэлтэй, түүний дотор ажилгүй гурван эмэгтэйн нэг нь энэ салбарт ажлын байр хайж байна. Ажилгүй эрэгтэйчүүдийн 61,2 хувь нь үйлдвэр, худалдаа, машин тоног, төхөөрөмжийн операторч, угсрагчийн ажлыг сонирхож байгаа боловч ийм ажил хийдэг хүн нийт ажиллагчдын 14,4 хувийг (хүснэгт 42-г үзнэ үү) эзэлж байна. Энэ бүгдээс харахад тэтгэвэр, нас баралт зэргийн улмаас гарах ажлын байрны хажуугаар дээр дурдсан эрэлт хэрэгцээг хангаж чадахуйц ажлын шинэ байр бий болгох хэрэгтэй байна. Хэдийгээр ажиллах хүчинд шинээр элсэн орогчдын боловсролын түвшин өндөр байгаа боловч таван эмэгтэй хүний нэг нь энгийн ажлыг ч гэсэн хийнэ гэж хариулжээ.

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хууль тогтоогч, удирдах ажилтан, менежер	1,100	0.8	800	1.1	300	0.4
Мэргэжилтэн	13,100	9.2	4,300	5.8	8800	13.0
Инженер техникийн ажилтан	5,500	3.9	2,500	3.3	3000	4.5
Бичиг хэргийн туслах ажилтан	3,900	2.7	1,200	1.5	2700	4.0
Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч	27,500	19.3	6,800	9.0	20700	30.6
ХАА ба загасны аж ахуйн мэргэшсэн ажилчин	5,900	4.1	3,500	4.7	2400	3.5
Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	36,100	25.4	20,900	28.1	15200	22.4
Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	26,400	18.6	24,700	33.2	1700	2.5
Энгийн ажил мэргэжил	22,700	15.9	9,800	13.2	12900	19.0
Бусад	100	0.1	100	0.1	0	0.1
Дүн	142,300	100.0	74,600	100.0	67,700	100.0

Хүснэгт 53.

Ажилгүйчүүдийн тоо, хийхийг хүсч буй ажил, ажил мэргэжлийн ангиллаар

Ажилгүйчүүдийн ажил хайсан хэлбэр

7.11 АХС-ны асуулгаар сүүлийн 30 хоногт ажилгүй байсан хүмүүс ажил хэрхэн хайсан талаар асууж судалсан юм. Нийт

142,300 ажилгүй хүний 44.0 хувь буюу 62,600 нь сүүлийн 30 хоногт ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан гэж хариулжээ.

Ажил хайсан хэлбэр	Улсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %
ХЭА-нд бүртгүүлсэн	11.8	11.8	11.9	9.5	9.1	10.0	17.6	18.7	16.4
Мэдээллийн зар, хэрэгслээр хайсан	22.4	21.9	23.0	29.8	28.7	31.4	3.6	3.8	3.5
Ажил олгогчдод өргөдөл гаргасан	8.2	7.3	9.2	5.2	4.6	5.9	15.7	14.8	16.7
Үйлдвэр, аж ахуйн газар, байгууллагуудаар явсан	23.0	23.2	22.7	22.6	23.1	22.0	23.9	23.5	24.3
Найз, нөхөд, хамаатан саднаас ажил сурагласан	30.3	31.1	29.3	28.7	29.7	27.5	34.4	34.9	33.7
Хувийн бизнес эрхлэхэд газар, санхүүгийн эх үүсвэр хайсан	2.7	2.8	2.6	2.6	2.9	2.1	3.1	2.5	3.8
Бусад	1.6	1.9	1.3	1.6	1.9	1.1	1.7	1.8	1.6
Дүн %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	62,600	34,500	28,100	44,800	25,100	19,700	17,800	9,400	8,400

Хүснэгт 54.

Ажилгүйчүүдийн ажил хайсан хэлбэр, хот, хөдөө, хүйсээр

Хүснэгт 54-өөс харахад ажилгүйчүүдийн 30.3 хувь нь найз нөхөд, хамаатан саднаасаа ажил сураглаж, 22.4 хувь нь мэдээллийн хэрэгслээр хайж, 23.0 хувь нь үйлдвэр, аж ахуйн газар байгууллагуудаар явж ажил хайсан байна. Арван хоёр ажилгүй хүний нэг нь Хөдөлмөр Эрхлэлтийн Алба (ХЭА)-нд бүртгүүлжээ. Хот, суурин газарт ХЭА-нд ердөө 9.5 хувь бүртгүүлсэн байхад хөдөө орон нутагт энэ хувь нэлээд өндөр 17.6 хувьтай байна.

хүмүүсийн 7.0 хувь нь улирлаас шалтгаалсан гэж хариулснаас хот, суурин газарт энэ хувь өндөр 8.9 хувьтай, харин хөдөө орон нутагт доогуур 4.6 хувьтай байна. Ажил хайгаагүй хүмүүсийн 4.9 хувь нь гэрийн ажилтай тул ажил хайгаагүй гэж хариулсны дотор хот, суурин газарт ийм хариулт өгсөн эмэгтэйчүүд 9.5 хувийг эзэлж, хөдөө орон нутагт 4.0 хувьтай байна.

Ажилгүйчүүдийн ажил хайгаагүй шалтгаан

7.12 Судалгаагаар сүүлийн 30 хоногт яагаад ажил хайгаагүй талаар асууж, энэ талаар мэдээлэл цуглуулсан. Нийт ажилгүйчүүдийн 55.9 хувь нь ажил хайгаагүй байна. Хүснэгт 55-аас харахад ажил хайгаагүй хүмүүсийн 68.9 хувь нь ажил олдохгүй гэж бодсон гэж хариулжээ.

Зураг 11.

Ажилгүйчүүдийн ажил хайгаагүй шалтгаан, бүтцээр

Энэ шалтгаанаар ажил хайгаагүй ажилгүй хүн хөдөө орон нутагт ажилгүйчүүдийн 80.2 хувьд хүрдэг ажээ. Хөдөлмөр эрхлэлтийн алба идэвхитэй ажилладаг хот, суурин газарт ч энэ хувь өндөр 60.4 хувьтай байна. Ер нь энэ талаар эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил төсөөлөлтэй байдаг аж. Ажил хайгаагүй



Ажил хайгаагүй шалтгаан	Улсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %	Бүгд %	Эрэгтэй %	Эмэгтэй %
Ажил олдохгүй гэж бодсон	68.9	69.9	67.9	60.4	61.4	59.4	80.2	81.0	79.4
Улирлаас шалтгаалсан	7.0	7.6	6.4	8.9	9.5	8.3	4.6	5.2	3.9
Мэргэжил, дадлага байхгүй	2.8	3.3	2.2	3.5	4.0	2.9	1.9	2.6	1.2
Гэрийн ажилтай	4.9	2.7	7.2	6.7	3.8	9.5	2.6	1.3	4.0
Суралцаж байсан	1.3	1.4	1.2	1.7	1.8	1.6	0.5	0.5	0.5
Хүсээгүй	3.0	3.3	2.7	3.8	4.4	3.3	1.9	1.8	2.0
Хөдөлмөрийн насанд хүрээгүй	0.1	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.3	0.6	0.0
Тэтгэвэрт	1.1	1.0	1.2	1.4	1.4	1.4	0.7	0.5	0.9
Бусад	10.9	10.6	11.2	13.6	13.7	13.6	7.3	6.5	8.1
Дүн %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	79,600	40,000	39,600	45,400	22,700	22,700	34,200	17,300	16,900

Хүснэгт 55.

Ажилгүйчүүдийн сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй шалтгаан, хот, хөдөө, хүйсээр

б ү л э г 8

БАЙНГЫН ИДЭВХИ



Бүлэг 8

БАЙНГЫН ИДЭВХИ

Нийтлэг зүйл

8.1 Ажиллах хүчний эрэлт хэрэгцээ, хангамжийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй болохын тулд ОУХБ-ын тодорхойлолтонд нийцүүлэн хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 12 сараар тооцов. Хөдөө аж ахуй, албан бус сектор зонхилж, ажил эрхлэлт нь улирлын чанартай хэлбэлзэж буй нөхцөлд эдийн засгийн идэвхийг сүүлийн 12 сараар хэмжиж тооцох нь ажил эрхлэлтийн байдлыг бодитойгоор тодорхойлоход нэн чухал ач холбогдолтой арга юм. Сүүлийн 12 сарын хугацаанд ажил хийж байсан, эсвэл ажил хийхэд бэлэн байсан, ажил хайж байсан хугацаа нь 6 сараас дээш байгаа хүмүүсийг байнгын идэвхитэй, 6 сар хүрэхгүй байгаа бол эдийн засгийн байнгын идэвхигүй хүн гэж тооцдог. Сүүлийн 12 сард ажил хийж байсан хугацаа нь ажилгүй байсан хугацаанаас урт байвал ажил эрхэлж байсан, богино байвал ажилгүй байсан гэж үзнэ.

8.2 Сүүлийн 12 сарын байдлаар эдийн засгийн идэвхийг хэмжих нь тухайн үеийн идэвхийг хэмжихээс зарим талаар ялгаатай байдаг. Үүнд: нэгэнт бүтэн жилийн хугацааг хамардаг тул байнгын идэвхийн хэмжүүрт улирлын байдал нөлөөлдөггүй байхад тухайн үеийн ажил эрхлэлт, ажилгүйдлийг хэмжих нь улирлын байдлаас ихээхэн хамааралтай байдаг. Түүнчлэн сүүлийн 12 сарын аль нэг хугацаанд ажил эрхэлж байсан боловч ажилгүй байсан хугацаа нь урт бол ажилгүй гэж тооцогддог тул сүүлийн 7 хоногт огт ажил хийгээгүй хүнийг ажил эрхлээгүй гэж үздэг. Байнгын болон тухайн үеийн байдлаар эдийн засгийн идэвхи болон идэвхигүй байдлыг харилцан адилгүй тодорхойлодог. Эдийн засгийн байнгын идэвхийн аргачлалаар тухайн хүн идэвхитэй, идэвхигүй байсныг эхлээд тодорхойлоод дараа нь нийлбэр хугацаанаас шалтгаалан ажилтай эсвэл ажилгүй хэмээн ангилдаг.

8.3 Хүснэгт 56-д 15, түүнээс дээш насны байнгын эдийн засгийн идэвхитэй хүн амын тоог харуулав. Тус хүснэгтээс харахад 941,500 /үүний 492,200 нь эрэгтэй, 449,300 нь эмэгтэй/ хүн байнгын идэвхитэй байна. Сүүлийн 12 сард ажил хийсэн хүний тоо 856,600 байгаа нь тухайн үед ажил эрхэлсэн хүний /862,500/ тоотой харьцуулахад 5900-гаар бага байна. Тухайн үеийн эдийн засгийн идэвхитэй харьцуулахад /тухайн

үеийн ажилгүйчүүд 142,300 байсан/ сүүлийн 12 сард ажилгүй хүн амын тоо үлэмж доогуур /84,900/ гарсан байна. Ийнхүү сүүлийн 12 сард ажилгүйчүүдийн тоо бага гарсан нь байнгын эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо өсч 597,800 болсонтой холбоотой. Эндээс харахад ажиллах хүчний тодорхойлолтоор ажилтай болон ажилгүй гэж тооцогдсон 63,400 хүн сүүлийн 12 сарын байдлаар байнгын идэвхигүй болон бусад ангиллын хүн амд тооцогдсон байна. Монгол Улсад урьд өмнө хийгдсэн судалгаануудад эдийн засгийн



байнгын идэвхийн тодорхойлолтыг ашиглаагүй тул энэ судалгааны дүнг харьцуулж болохуйц тоо мэдээ байхгүй юм.

Насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшин

8.4 Хүснэгт 57-д 15, түүнээс дээш насны байнгын идэвхитэй хүн амын ажиллах хүчний оролцооны түвшинг насны бүлэг, хүйс болон хот, хөдөөгөөр харуулав. Байнгын идэвхитэй хүн амын насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшин тухайн үеийн эдийн засгийн идэвхи буюу ажиллах хүчний ойлголтын хүрээнд тодорхойлогдсон оролцооны түвшнээс доогуур байна. Энэ нь сүүлийн 12 сард ажилгүй хүн ам багаар тооцогдож, улмаар эдийн засгийн байнгын идэвхигүй хүн ам нэмэгдэж гарсантай холбоотой. Сүүлийн 7 хоногт насны бүлэг дэх ажиллах хүчний оролцооны түвшин 25-49 насанд дунджаар 85.0 гаруй хувьтай байхад /Хүснэгт 36-г үзнэ үү/ сүүлийн 12 сард энэ түвшин 5 пунктээр доогуур гарчээ.

	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Улсын хэмжээнд						
Байнгын идэвхитэй хүн ам	941,500	61.2	492,200	65.5	449,300	57.0
Ажиллагчид	856,600	55.7	446,800	59.5	409,800	52.0
Ажилгүйчүүд	84,900	5.5	45,400	6.0	39,500	5.0
Байнгын идэвхигүй хүн ам	597,800	38.8	258,700	34.5	339,100	43.0
15, түүнээс дээш насны хүн ам	1,539,300	100.0	750,900	100.0	788,400	100.0
Хот						
Байнгын идэвхитэй хүн ам	446,700	52.2	230,300	56.3	216,400	48.5
Ажиллагчид	394,000	46.1	201,400	49.3	192,600	43.1
Ажилгүйчүүд	52,700	6.1	28,900	7.1	23,800	5.3
Байнгын идэвхигүй хүн ам	408,500	47.8	178,400	43.6	230,100	51.5
15, түүнээс дээш насны хүн ам	855,200	100.0	408,700	100.0	446,500	100.0
Хөдөө						
Байнгын идэвхитэй хүн ам	494,800	72.3	261,900	76.5	232,900	68.1
Ажиллагчид	462,600	67.6	245,400	71.7	217,200	63.5
Ажилгүйчүүд	32,200	4.7	16,500	4.8	15,700	4.6
Байнгын идэвхигүй хүн ам	189,300	27.7	80,300	23.5	109,000	31.9
15, түүнээс дээш насны хүн ам	684,100	100.0	342,200	100.0	341,900	100.0

Хүснэгт 56.

15, түүнээс дээш насны байнгын идэвхитэй хүн амын тоо, хот, хөдөө, хүйсээр

Насны бүлэг	Улсын хэмжээнд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
15-17	17.0	21.1	13.0	4.4	5.6	3.2	33.0	40.4	25.4
18-19	38.6	43.3	33.4	19.4	22.2	16.6	62.1	68.1	55.2
20-24	58.6	63.6	53.7	40.1	45.6	34.8	80.3	83.8	76.7
25-29	77.9	82.0	74.0	67.7	73.9	62.1	88.1	89.6	86.5
30-34	81.7	85.9	77.8	76.8	82.1	72.2	87.5	90.1	84.9
35-39	83.4	86.5	80.7	81.1	85.2	77.6	86.7	88.4	85.3
40-44	83.3	85.6	81.2	81.0	83.3	79.0	86.6	88.8	84.5
45-49	81.2	85.0	77.4	77.6	82.1	73.2	85.7	88.8	82.7
50-54	66.4	76.7	57.3	60.2	69.5	52.1	75.0	86.6	64.7
55-59	50.8	68.0	35.2	40.8	58.4	26.5	64.6	79.6	48.8
60-64	29.4	35.7	22.3	18.6	23.1	13.2	45.0	54.7	34.7
64-69	22.4	29.0	16.3	10.4	17.5	4.5	35.3	40.2	30.4
70 +	9.0	11.1	7.1	2.5	3.6	1.7	17.8	20.1	15.5
Улсын дундаж	61.2	65.5	57.0	52.2	56.3	48.5	72.3	76.5	68.1

Хүснэгт 57.

15, түүнээс дээш насны байнгын идэвхитэй хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр

Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

8.5 Хүснэгт 58-д сүүлийн 12 сард ажил эрхэлсэн 15, түүнээс дээш насны хүн амыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр харуулав. Хүснэгтээс харахад хоёр эрэгтэй ажиллагчдын бараг нэг нь, таван эмэгтэй ажиллагчдын хоёроос илүү нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж байна. Нийт ажиллагчдын 11.3 хувь буюу 42,400 эрэгтэй, 54,500 эмэгтэйчүүд бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллаж байхад боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ зэрэг салбарт ажиллагчид нийлээд 123,600 буюу нийт ажиллагчдын 14.4 хувийг эзэлж байна. Эдгээр салбарт ажиллагчдын дийлэнх нь эмэгтэйчүүд /83,500 эмэгтэй, 40,100 эрэгтэй/ байна. Төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгалын салбарт 53,700 хүн /нийт ажиллагчдын 6.3 хувь/ ажиллаж байгаагаас дийлэнх нь эрэгтэй байна

/36,200 эрэгтэй, 17,500 эмэгтэй/. Ажил эрхлэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар сүүлийн 12 сар болон сүүлийн 7 хоногоор харьцуулахад тоо, хувийн жингийн хувьд



Салбар	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	396,400	46.3	213,700	47.8	182,700	44.6
Загас агнуур	400	0.1	200	0.1	200	0.0
Уул уурхайн олборлох аж үйлдвэр	21,200	2.5	15,900	3.5	5,300	1.3
Боловсруулах аж үйлдвэр	47,400	5.5	21,200	4.7	26,200	6.4
Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж	16,200	1.9	11,800	2.6	4,400	1.1
Барилга	18,600	2.2	13,700	3.1	4,900	1.2
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар, үйлчилгээ	96,900	11.3	42,400	9.5	54,500	13.3
Зочид буудал, зоогийн газар	13,500	1.6	4,900	1.1	8,600	2.1
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	50,800	5.9	37,200	8.3	13,600	3.4
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	6,300	0.7	2,900	0.7	3,400	0.8
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнес	9,600	1.1	5,800	1.3	3,800	0.9
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал	53,700	6.3	36,200	8.1	17,500	4.3
Боловсрол	63,500	7.4	20,400	4.6	43,100	10.5
Эрүүл мэнд, нийгмийн халамж	38,100	4.4	8,900	2.0	29,200	7.1
Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	22,000	2.6	10,800	2.4	11,200	2.7
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	1,000	0.1	300	0.1	700	0.2
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	1,000	0.1	500	0.1	500	0.1
Дүн	856,600	100.0	446,800	100.0	409,800	100.0

Хүснэгт 58.

Сүүлийн 12 сардажигл эрхэлсэн 15, түүнээс дээш насны хүн амын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр

нэг их ялгаагүй, харин сүүлийн 12 сарын байдлаар боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж, барилгын салбарт ажиллагчдын тоо бага зэрэг илүү байна.

Ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангиллаар

8.6 Сүүлийн 12 сард ажил хийсэн хүний тоог, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр нь тооцсоныг Хүснэгт 59-д харуулав. Сүүлийн 7 хоногт ажил хийсэн ажиллагчдын тоог ажил мэргэжил, хүйсээр нь харуулсан хүснэгт 42-той харьцуулан харахад нэг их ялгаа ажиглагдсангүй.

Ажилгүйдэл

8.7 Сүүлийн 7 хоногтой харьцуулахад сүүлийн 12 сард ажилгүйдчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшин доогуур гарах

хандлагатай байдаг. Сүүлийн 12 сард ажилгүй байсан хугацаа нь ажил эрхэлсэн хугацаа болон эдийн засгийн идэвхигүй байсан хугацаанаас урт байвал ажилгүй гэж тооцогддог. Ийм ч учраас ажилгүй хүн амын тоо болон ажилгүйдлийн түвшин ялангуяа эдийн засгийн бүтэц, зохион байгуулалт сул, ажил эрхлэлт нь улирлын чанартай байгаа нөхцөлд ерөнхийдөө доогуур гардаг байна. Энэ нөхцөлд түр зуур тохиолдлын чанартай хийсэн ажлын хугацааг хооронд нь нэмснээр ажил эрхэлсэн хугацаа урт гарахад хүргэдэг. Түүнчлэн улирлын байдлаас хамааран ажил хийх боломж ихээхэн хэлбэлзэж байдагтай холбоотойгоор эдийн засгийн идэвхигүй байдлын хугацаа ч нэмэгдэхэд хүрдэг байна.

8.8 Сүүлийн 12 сард насны бүлэг дэх ажилгүйдлийн түвшин 18-19 насанд 18.1 хувь, 20-24 насанд 13.8 хувь, 25-29 насанд 8.4 хувьтай байхад сүүлийн 7 хоногт энэ түвшин 6.5, 18.4, 15.0 хувьтай (хүснэгт 50-иас харна уу) байна.

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хууль тогтоогч, удирдах ажилтан, менежер	33,100	3.9	22,700	5.1	10,400	2.5
Мэргэжилтэн	103,100	12.0	36,800	8.2	66,300	16.2
Инженер техникийн ажилтан	40,300	4.7	15,700	3.5	24,600	6.0
Бичиг хэргийн туслах ажилтан	17,500	2.0	4,800	1.1	12,700	3.1
Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч	100,000	11.7	38,100	8.5	61,900	15.1
ХАА ба загасны аж ахуйн мэргэшсэн ажилчин	385,300	45.0	207,800	46.5	177,500	43.3
Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	67,900	7.9	44,300	9.9	23,600	5.8
Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	57,800	6.7	52,700	11.8	4,900	1.2
Энгийн ажил мэргэжил	51,800	6.1	23,900	5.4	27,900	6.8
Дүн	856,600	100.0	446,800	100.0	409,800	100.0

Хүснэгт 59.

Сүүлийн 12 сард ажил эрхэлсэн хүн амын тоо, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр

Тухайн үеийн идэвхи болон байнгын идэвхийн уялдаа, холбоо

8.9 Хүн амын тухайн үеийн болон байнгын эдийн засгийн идэвхийн хоорондох уялдаа, холбоог харьцуулан тооцсоныг Хүснэгт 61-д харуулав. Хүснэгтээс харахад дийлэнх хүмүүсийн байнгын болон тухайн үеийн идэвхитэй болон идэвхигүй байдалд өөрчлөлт ороогүй байна. Тухайлбал,

сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн нийт 862,500 хүний 840,700 нь сүүлийн 12 сард ажилласан, 5,200 нь ажилгүй, 16,600 нь эдийн засгийн идэвхигүй гэж тодорхойлогджээ. Мөн сүүлийн 7 хоногт 142,300 хүн ажил эрхлээгүй бол энэ тоог сүүлийн 12 сарын байдлаар харахад 73,200 (51.4 хувь) нь ажил

Насны бүлэг	Ажилгүйдлийн түвшин		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
15-17	9.1	8.5	10.1
18-19	18.1	17.1	19.4
20-24	13.8	14.4	13.2
25-29	8.4	8.3	8.6
30-34	8.7	8.9	8.6
35-39	8.7	7.9	9.4
40-44	7.8	8.4	7.3
45-49	7.9	9.8	5.9
50-54	6.7	7.7	5.6
55-59	3.9	3.2	5.2
60-64	4.5	4.7	4.1
64-69	1.3	0.9	2.0
Улсын дундаж	9.0	9.2	8.8

Хүснэгт 60.

Байнгын идэвхитэй хүн амын ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр

эрхлээгүй, харин үлдсэн хүмүүсээс 58,400 (41.0 хувь) нь эдийн засгийн идэвхигүй, 10,700 нь ажил эрхэлсэн байна. Сүүлийн 7 хоног ажилгүй байсан хүмүүсээс сүүлийн 12 сарын байдлаар 58,400 хүнийг эдийн засгийн идэвхигүй гэж тодорхойлсон нь энэ хугацаан дахь ажилгүйчүүдийн тоо, ажилгүйдлийн түвшинг үлэмж бууруулахад хүргэсэн байна. Хүснэгт 61-ээс харахад байнгын идэвхигүй 597,700 хүн амын 75,000 нь ажил эрхлэлтийн тодорхойлолтоор сүүлийн 7 хоногт эдийн засгийн идэвхитэй гэсэн ангилалд орсон бөгөөд үүний улмаас байнгын идэвхигүй хүн амын тоо буурсан байна.

Хүүхдийн хөдөлмөр

8.10 Тус судалгаанд хүүхдийн хөдөлмөрийн талаархи асуулгыг хавсаргасны улмаас сүүлийн 12 сард ажил хийсэн эсэх, ажил хийх боломжтой байсан эсэх талаар асуултуудыг 5 ба түүнээс дээш насны хүмүүсээс асуусан. Сүүлийн 7 хоногт нэг цаг л ажил хийсэн бол тухайн хүүхдийг ажил эрхэлсэн гэж үздэг бол сүүлийн 12 сарын хугацаанд 6 сар ба түүнээс дээш хугацаанд ажил эрхэлсэн эсвэл ажил эрхлэхэд бэлэн, ажил хайж байсан хүүхдүүдийг байнгын идэвхитэйд тооцсон. Ийм ч учраас сүүлийн 12 сард хүүхдийн хөдөлмөр эрхлэлт сүүлийн 7 хоногийнхтой харьцуулахад бага гарсан байна.


Тухайн үеийн идэвхитэй хүн ам	Бүгд	Байнгын идэвхитэй хүн ам			Эдийн засгийн идэвхигүй
		Бүгд	Ажиллагчид	Ажилгүйчүүд	
Улсын хэмжээнд					
Тухайн үеийн идэвхитэй	1,004,800	929,800	851,400	78,400	75,000
Ажиллагчид	862,500	845,900	840,700	5,200	16,600
Ажилгүйчүүд	142,300	83,900	10,700	73,200	58,400
Тухайн үеийн идэвхигүй	534,400	11,700	5,200	6,500	522,700
Дүн	1,539,200	941,500	856,600	84,900	597,700
Эрэгтэй					
Тухайн үеийн идэвхитэй	523,500	486,800	444,600	42,200	36,700
Ажиллагчид	448,900	441,500	438,300	3,200	7,400
Ажилгүйчүүд	74,600	45,300	6,300	39,000	29,300
Тухайн үеийн идэвхигүй	227,400	5,400	2,200	3,200	222,000
Дүн	750,900	492,200	446,800	45,400	258,700
Эмэгтэй					
Тухайн үеийн идэвхитэй	481,300	443,000	406,800	36,200	38,300
Ажиллагчид	413,600	404,400	402,400	2,000	9,200
Ажилгүйчүүд	67,700	38,600	4,400	34,200	29,100
Тухайн үеийн идэвхигүй	307,000	6,300	3,000	3,300	300,700
Дүн	788,300	449,300	409,800	39,500	339,000

Хүснэгт 61.

15, түүнээс дээш насны хүн амын тоог тухайн үеийн болон байнгын идэвхийн байдлаар харьцуулан гаргасан нь

Зураг 12.

15, түүнээс дээш насны хүн амын тухайн үеийн болон байнгын эдийн засгийн идэвхийн хоорондох уялдаа, холбоо



Насны бүлэг	Бүгд	Эдийн засгийн идэвхитэй	Үүнээс:		Эдийн засгийн идэвхигүй
			Ажиллагчид	Ажилгүйчүүд	
Тухайн үеийн идэвхитэй					
Бүгд	679,000	73,500	68,600	4,900	605,500
5-9	212,100	15,300	15,300	-	196,800
10-14	294,900	21,900	21,400	500	273,000
15-17	172,000	36,300	31,900	4,400	135,700
Эрэгтэй	347,600	44,600	41,900	2,700	303,000
5-9	109,200	9,000	9,000	-	100,200
10-14	152,000	14,000	13,800	200	138,000
15-17	86,400	21,600	19,100	2,500	64,800
Эмэгтэй	331,400	28,900	26,700	2,200	302,500
5-9	102,900	6,300	6,300	-	96,600
10-14	142,900	7,900	7,600	300	135,000
15-17	85,600	14,700	12,800	1,900	70,900
Байнгын идэвхитэй					
Бүгд	679,000	52,000	48,900	3,100	627,000
5-9	212,100	9,100	9,000	100	203,000
10-14	294,900	13,600	13,300	300	281,300
15-17	172,000	29,300	26,700	2,600	142,700
Эрэгтэй	347,600	32,700	31,000	1,700	314,900
5-9	109,200	5,600	5,500	100	103,600
10-14	152,000	8,900	8,800	100	143,100
15-17	86,400	18,200	16,700	1,500	68,200
Эмэгтэй	331,400	19,300	18,000	1,300	312,100
5-9	102,900	3,500	3,500	-	99,400
10-14	142,900	4,700	4,500	200	138,200
15-17	85,600	11,100	10,000	1,100	74,500

Хүснэгт 62.

5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхи, сүүлийн 7 хоног болон 12 сарын байдлаар

б ү л э г 9

АЛБАН БУС СЕКТОР ДАХЬ АЖИЛ ЭРХЛЭЛТ



Бүлэг 9

АЛБАН БУС СЕКТОР ДАХЬ АЖИЛ ЭРХЛЭЛТ

Нийтлэг зүйл

9.1 Монгол Улсад албан бус сектор нь ажил эрхлэлт, орлогын эх үүсвэр бүрдүүлэлтийн нэлээд хэсгийг хангадаг. Иймд ойрын хугацаанд ажлын байраар хангахад чухал үүрэг гүйцэтгэж буйг нь харгалзан үзэж “Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан”-гаар цуглуулсан албан бус сектортэй холбогдож болох тоо мэдээнд дүн шинжилгээ хийснийг энэхүү бүлэгт танилцуулж байна. Гэхдээ асуулгыг боловсруулах үед албан бус секторын талаар онцгойлон үзэж асуудлуудыг оруулаагүй тул өнөөгийн шатанд цугларсан тоо мэдээллээс холбогдож болох хэсгийг нь сонгон авч дүн шинжилгээ хийснийг дурьдах нь зүйтэй.

9.2 1993 оны 1-р сард ОУХБ-аас зохион байгуулсан Хөдөлмөрийн Статистикчдийн Олон Улсын 15-р Бага Хурлаар батлагдсан тогтоолд албан бус секторыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: албан бус сектор нь хувийн сонирхлын үүднээс ажлын байр, орлогын эх үүсвэр бий болгох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй нэгжүүдээс бүрдэнэ. Албан бус сектор дэх үйлдвэрлэл, үйлчилгээ нь хөдөлмөр болон хөрөнгийн хуваарь байхгүй эсвэл маш бага хэмжээтэй байдаг өрхийн жижиг аж ахуйн хэлбэрээр ажилладаг.

Тодорхойлолт

9.3 Олон улсын статистикийн болон ҮТС-ийн ойлголт, тодорхойлолтод тусгагдсанаар албан бус сектор нь бүлэг аж ахуйн нэгж бөгөөд өрхийн аж ахуйн өрхийн үйлдвэрлэл буюу түүний эзэмшдэг хамтарсан бус аж ахуйн нэгж юм. Өрхийн аж ахуй нь (i) хувиараа хөдөлмөр эрхлэгчийн аж ахуй, (ii) албан бус секторт ажил олгогч эздийн аж ахуйгаас бүрдэнэ.

9.4 Албан бусаар хувиараа хөдөлмөр эрхлэгчийн аж ахуй гэдэг нь хувиараа хөдөлмөр эрхлэгч ганцаараа эсвэл өрхийн бусад гишүүд, өөр өрхтэй хамтран эрхэлж буй өрхийн аж ахуй бөгөөд өрхийн гишүүд болон түр хугацааны ажиллагчид хөлслөн ажиллуулдаг. Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн аж ахуй нь хөлсний ажилчныг тогтмол хугацаагаар ажиллуулдаггүй.

9.5 Албан бус секторт ажил олгогч эздийн аж ахуй гэдэг нь ганцаараа эсвэл бусадтай хамтран эрхэлж буй өрхийн аж ахуй бөгөөд нэг болон түүнээс дээш тооны ажиллагчдыг тогтмол ажиллуулдаг. Ийм аж ахуйг тухайн улс орны нөхцөл байдалтай уялдуулан ажиллагчдын тоо болон улсын бүртгэлд бүртгэгдээгүй зэрэгт үндэслэн тодорхойлдог.

9.6 Албан бус сектор дахь ажил эрхлэлтийг тооцохдоо зах зээлд борлуулах зорилгоор бус, өөрсдийн хэрэглээ, хэрэгцээнд зориулан эрхэлж буй өрхийн аж ахуйг хамруулдаггүй. Албан бус сектор нь хөдөө аж ахуйн бус чиглэлээр ажиллаж буй өрхийн аж ахуйд л хамааралтай байж болох юм. Түүнчлэн дээр дурьдсан тодорхойлолтонд нийцэж байвал эмч, хуульч, нябо, инженер зэрэг мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг албан бус секторт оруулах ёстой.

9.7 ОУХБ-ын зөвлөмж болгосноор албан бус секторын талаарх тоо мэдээг статистикийн тогтолцооны нэг хэсэг болгож тогтмол цуглуулах нь зүйтэй. Ингэснээр албан бус секторын цар хүрээ, хэмжээ, төлөв байдлын талаар байнгын мэдээлэлтэй болж, гарч буй өөрчлөлтөнд хяналт тавих боломжтой болох юм. АХС болон өрхийн бусад судалгаагаар албан бус сектор дахь ажил эрхлэлтийг хэмжих, энэ салбарт ажиллагчдын тоо, нийгэм, эдийн





засгийн үзүүлэлтүүд, ажлын нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулж авах нь хөрөнгө мөнгө хэмнэсэн чухал алхам болно. Өрхийн ийм судалгаануудаар цуглуулж авсан мэдээг аж ахуйн нэгжийн тооллого, эдийн засгийн үйл ажиллагааны тооллого, судалгаа зэрэг ажил эрхлэлт, албан бус секторын үйлдвэрлэл, үйлчилгээний талаарх бусад судалгааны дүнтэй уялдуулж баяжуулах хэрэгтэй.

ХАА-н салбарын ажил эрхлэлт

9.8 Буурай хөгжилтэй орнуудын хөдөө аж ахуйн салбар дахь албан бус секторын үйл ажиллагааг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг тул ОУХБ нь ХАА-н салбарыг албан бус

секторын хүрээнээс гаргаж, зөвхөн ХАА-н бус чиглэлийн үйл ажиллагааг тус секторт хамруулан тооцохоор тогтсон. Монгол Улсын нийт ажиллагчдын 46.6 хувийг шингээсэн ХАА-н салбар нь эдийн засгийн хамгийн том салбаруудын нэг бөгөөд ХАА-н салбар дахь үйл ажиллагаанд өрхийн жижиг аж ахуйн хэлбэр зонхилсон байдаг тул тус салбарыг албан бус секторт хамруулан тооцох ёсгүй юм. Ийм ч учраас ОУХБ-ын тодорхойлолтын дагуу ХАА-н бус салбар дахь ажил эрхлэлтийг ХАА-н салбар дах ажил эрхлэлтээс зааглаж, улмаар ХАА-н бус салбар дахь ажил эрхлэлтийг албан болон албан бус секторын гэж ангилан үзэх ёстой.

ХАА болон ХАА-н бус салбар дахь ажил эрхлэлт

9.9 ХАА болон ХАА-н бус салбарын ажил эрхлэлтийг хүснэгт 63-т харуулав. Нийт ажиллагчдын 46.6 хувь буюу 402,200 хүн хөдөө аж ахуй салбарт ажиллаж байгаа бөгөөд эдгээр хүмүүсийг албан бус секторын хүрээнд авч үзэхгүй. Гэсэн хэдий ч ХАА-н бус салбарт ажиллагчдын нэгэн адилаар ХАА-н салбарт ажиллагчдын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй авч, ажил эрхлэлт, түүний өсөлт бууралтыг судлах нь тус салбарын хамарч байгаа хүрээнээс харахад зайлшгүй шаардлагатай байна.

9.10 ХАА-н бус салбарт нийт ажиллагчдын тоо 460,300 / 53.4 хувь/ байгаагийн 20.0 орчим хувь нь л хөдөө орон нутагт, харин таван хүн тутмын дөрөв нь хот, суурин газарт төвлөрч байна. ХАА-н бус салбарт ажиллагчдын 45.0 гаруй хувь нь Улаанбаатар хотод байгаа нь энд албан бус хөдөлмөр эрхлэгчид их байгааг харуулж байна.

Байршил/Бүс	Улсын хэмжээнд			Үүнээс:			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	ХАА		ХАА-н бус	
				Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хот	392,300	199,900	192,400	15,300	12,800	184,600	179,600
Хөдөө	470,200	249,000	221,200	200,900	173,200	48,100	48,000
Төв	167,300	86,700	80,600	48,100	37,800	38,600	42,800
Зүүн	68,300	36,400	31,900	22,300	18,700	14,100	13,200
Баруун	175,600	93,100	82,500	63,900	55,900	29,200	26,600
Хангай	233,300	122,000	111,300	80,600	71,700	41,400	39,600
УБ	218,000	110,700	107,300	1,300	1,900	109,400	105,400
Дүн	862,500	448,900	413,600	216,200	186,000	232,700	227,600
	%	%	%	%	%	%	%
Хот	45.5	44.5	46.5	7.1	6.9	79.3	78.9
Хөдөө	54.5	55.5	53.5	92.9	93.1	20.7	21.1
Төв	19.4	19.3	19.5	22.2	20.4	16.6	18.8
Зүүн	7.9	8.1	7.7	10.3	10.0	6.0	5.8
Баруун	20.4	20.7	20.0	29.6	30.0	12.5	11.7
Хангай	27.0	27.2	26.9	37.3	38.5	17.8	17.4
УБ	25.3	24.7	25.9	0.6	1.0	47.0	46.3
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Хүснэгт 63.

ХАА болон ХАА-н бус салбарт тухайн үед ажиллаж байгаа 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо, хот, хөдөө, бус нутаг, хүйсээр

9.11 ХАА болон ХАА-н бус салбарт ажиллагчдын насны бүтцийг харахад залуу хүмүүсийн эзлэх хувь ХАА-н салбарт өндөр, тэдний ердөө 34.2-37.4 хувь нь 35-59 насныхан байна. ХАА-н бус салбарт энэ насныхны эзлэх хувийн жин эрэгтэй, эмэгтэйд адилхан 60.0 орчим хувь байна. ХАА-н бус салбарт ажиллаж байгаа 15-19 насныхны эзлэх хувь харьцангуй бага буюу 5,300 эрэгтэй, 4,000 эмэгтэй байгаа нь нийт ажил эрхэлсэн эрэгтэйчүүдийн 2.3, эмэгтэйчүүдийн 1.8 хувийг эзэлж байна. Харин 15-19 насны ажиллагчдын 13.2 хувь буюу 53,000 нь ХАА-н салбарт ажиллаж байна. Хөдөө орон нутагт сургуульд хамрагдалтын түвшин доогуур, өрхийн мал

аж ахуйг эрхлэхэд хүн хүч шаардлагатай байгаа нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа залуучуудын тоог нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.

Албан бус сектор дахь аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо

9.12 Байнгын орон тооны ажилчингүй, эсвэл 1-4 ажилчинтай улсын өмчийнх бус, томоохон хувийн хэвшлийн аж ахуйд харьяалагддаггүй хөдөө аж ахуйн бус чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйг албан бус секторт хамруулж болох юм.

Насны бүлэг	Улсын хэмжээнд			Үүнээс:			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	ХАА		ХАА-н бус	
				Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
15-19	62,300	37,000	25,300	31,700	21,300	5,300	4,000
20-24	97,200	52,200	45,000	33,000	28,400	19,200	16,600
25-34	257,400	130,900	126,500	63,800	56,500	67,100	70,000
35-59	415,400	210,100	205,300	73,800	69,700	136,300	135,600
60+	30,200	18,700	11,500	13,900	10,100	4,800	1,400
Дүн	862,500	448,900	413,600	216,200	186,000	232,700	227,600
	%	%	%	%	%	%	%
15-19	7.2	8.2	6.1	14.6	11.5	2.3	1.8
20-24	11.3	11.6	10.9	15.3	15.3	8.2	7.3
25-34	29.8	29.2	30.6	29.5	30.4	28.9	30.7
35-59	48.2	46.8	49.6	34.2	37.4	58.6	59.6
60+	3.5	4.2	2.8	6.4	5.5	2.1	0.6
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Хүснэгт 64.

ХАА болон ХАА-н бус салбарт тухайн үед ажиллаж байгаа 15, түүнээс дээш насны хүн амын тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр

9.13 Судалгаагаар ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчдаас ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагынх нь ажиллагчдын тооны талаар мэдээлэл

цуглуулсан. Тухайн үед ажил эрхэлж байгаа 15, түүнээс дээш насны хүн амын тоог аж ахуйн нэгж, байгууллагын төрлөөр гаргаж Хүснэгт 65-д үзүүлэв.

Байгууллагын төрөл	Бүгд	Үүнээс: ажиллагчдын тоогоор								
		Орон тооны бус ажилчинтай		1 - 4		5 - 9		10 ба түүнээс дээш		
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	
ХЭАА	33,100	3.8	22,600	4.6	6,600	12.7	1,800	5.3	2,100	0.7
Нөхөрлөл	2,600	0.3	100	0.0	1,000	1.9	500	1.5	1,000	0.3
Хоршоо	4,500	0.5	600	0.1	1,200	2.3	1,100	3.2	1,600	0.6
ХК	39,000	4.5	400	0.1	2,500	4.8	3,300	9.7	32,800	11.3
ХХК	84,000	9.7	700	0.1	10,100	19.4	10,600	31.3	62,600	21.6
УУГ	32,200	3.7	0	0.0	1,300	2.5	1,200	3.5	29,700	10.2
Төрийн, төсөвт байгууллага	169,900	19.7	0	0.0	12,000	23.0	10,800	31.9	147,100	50.8
ТББ	13,200	1.5	100	0.0	2,000	3.8	2,500	7.4	8,600	3.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	484,000	56.1	462,200	95.0	15,400	29.6	2,100	6.2	4,300	1.5
Дүн	862,500	100.0	486,700	100.0	52,100	100.0	33,900	100.0	289,800	100.0

Хүснэгт 65.

Тухайн үед ажил эрхэлж байгаа 15, түүнээс дээш насны хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, ажиллагчдын тоогоор

9.14 Хүснэгтээс харахад 5-9 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагад 33,900 хүн, 10 ба түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжид 298,800 хүн, харин 1-4 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагад 52,100 хүн, орон тооны бус ажилчинтай аж ахуйн нэгж, байгууллагад 486,700 хүн тус тус ажиллаж байна. Аж ахуйн нэгж, байгууллагыг ингэж

ажиллагчдынх нь тоогоор ангилснаар тухайн аж ахуйн нэгжийн албан болон албан бус секторын алинд нь хамаарагдахыг тодорхойлж болно.

9.15 Хувиараа хөдөлмөр эрхлэгчид 484,000 буюу нийт ажиллагчдын 56.1 хувийг бүрдүүлж байна. Түүний 95.4 хувь



нь (462,200) орон тооны бус ажилчинтай хувийн аж ахуйн нэгж байна. Төрийн, төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газар, хувьцаат компанид 241,100 хүн буюу нийт ажиллагчдын 28.0 хувь нь ажиллаж байна. 10 ба түүнээс дээш ажиллагчидтай дээр дурдсан томоохон аж ахуйн нэгж, байгууллагад 209,600 хүн буюу 72.3 хувь нь ажиллаж байна. Харин хувиараа эрхлэх аж ахуйд нийт ажиллагчдын 3.8 хувь буюу 33,100 хүн ажиллаж байна.

Албан бус секторыг судалгаанд тодорхойлсон байдал

9.16 Албан бус секторын талаар тодорхойлолт байхгүй тул албан бус сектор дахь ажил эрхлэлтийн талаар статистик мэдээ цуглуулахад бэрхшээлтэй байна. Түүнчлэн аливаа улс орон энэ чиглэлээр тоо мэдээг хэрхэн цуглуулж, тооцоход мөрдөн нийцүүлж болохуйц тодорхой зөвлөмж, чиглэлийг ОУХБ-ын зүгээс гаргаагүй байна. Энэхүү судалгааг явуулахдаа анхнаасаа албан бус секторын талаар мэдээлэл авах зорилгогүй байсан бөгөөд үр дүнгийн хүснэгтийг бэлтгэх, илтгэл бичихдээ л энэ сэдвийг оруулсан юм. Ийм ч учраас албан бус сектор дахь ажил эрхлэлтийн зөвхөн зарим нэг

асуудал л хамрагдсан тул ажил эрхлэлтийн тодорхойлолтыг үндэслэн судалгаанаас бололцоотой мэдээллийг гаргаж үзүүлээ. Цаашид энэ судалгааны мэдээллийг ашиглан албан бус секторын ойлголт, тодорхойлолтыг улам боловсронгуй болгох шаардлагатай юм.

9.17 Судалгаагаар ажиллагчдын ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, үйлдвэрлэлийн чиглэл, хот, хөдөө, бус нутгийн талаарх мэдээллийг цуглуулсан. Аж ахуйн нэгж, байгууллагын төрлийг ҮСГ-т мөрдөгдөж байгаа ангиллын дагуу авав. ХЭАА, нөхөрлөл, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь албан бус секторын үйл ажиллагаа явуулж болох юм гэж үзээд аж ахуйн нэгжид ажиллаж байгаа ажиллагчдын тооноос хамааран албан болон албан бус секторт хамруулахаар тогтсон. Орон тооны бус ажилчинтай болон 1-4 ажиллагчидтай аж ахуйн нэгжийг албан бус сектор, харин 5 ба түүнээс дээш ажиллагчидтайг албан сектор гэж тодорхойлсон. Албан бус секторын ажил эрхлэлтийг үндсэн болон давхар ажил эрхлэлтийн байдлаар нь тодорхойлсон.

9.18 Өмнө нь дурдсанчлан зөвхөн ХАА-н бус үйлдвэрлэл явуулж байгаа орон тооны бус ажилчинтай болон 1-4 ажиллагчидтай хувиараа хөдөлмөр эрхлэгч, ХЭАА, нөхөрлөл нь албан бус секторт хамрагдана.

Албан бус секторын ажил эрхлэлтийн тооцоо

9.19 Нийт 862,500 хүн ажил хөдөлмөр эрхэлж байгаагийн 402,200 нь ХАА-д, 460,300 нь /хүснэгт 64-өөс харна уу/ ХАА-н бус үйл ажиллагаа эрхэлж байна. Албан бус секторын тооцоонд ХАА-н үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн ам хамрагдаагүй. Хүснэгт 65-аас харахад 484,000 хүн хувиараа хөдөлмөр эрхлэгч, 33,100 нь ХЭАА-д, 2,600 нь нөхөрлөлд ажиллаж байна. Эдгээрээс 125,100 хүн ХАА-н бус секторт ажиллаж байна (хүснэгт 66-г харна уу).

Байгууллагын төрөл	Үүнээс: ажиллагчдын тоогоор									
	Бүгд		Орон тооны бус ажилчинтай		1 - 4		5 - 9		10 ба түүнээс дээш	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
ХАА-н бус										
ХЭАА	14,400	100.0	5,100	35.5	5,500	38.2	1,800	12.2	2,000	14.2
Нөхөрлөл	2,200	100.0	100	3.8	800	36.1	500	23.5	800	36.5
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	108,500	100.0	96,500	89.0	6,500	6.0	1,800	1.7	3,700	3.4
Дүн	125,100	100.0	101,700	81.3	12,800	10.2	4,100	3.3	6,500	5.2
ХАА										
ХЭАА	18,700	100.0	17,600	93.8	1,000	5.5	-	0.3	100	0.4
Нөхөрлөл	300	100.0	-	5.6	200	53.4	-	0.0	100	41.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	375,500	100.0	365,600	97.4	8,900	2.4	300	0.1	700	0.2
Дүн	394,500	100.0	383,200	97.1	10,100	2.6	300	0.1	900	0.2
Бүгд	519,600	100.0	484,900	93.3	22,900	4.4	4,400	0.9	7,400	1.4

Хүснэгт 66.

Тухайн үед ажил эрхэлж байгаа 15, түүнээс дээш насны хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, ажиллагчдын тоогоор

9.20 Энэ 3 төрлийн аж ахуйн нэгж, байгууллагын 5 ба түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа хүн амыг хасч албан бус секторт ажиллаж байгаа ажиллагчдыг тооцоход тус секторт үндсэн ажил эрхэлж байгаа хүн ам 114,500 болж байна. Харин давхар ажил эрхэлж байгаа хүн ам 11,500 байгааг нэмж оруулаад энэ салбарт нийтдээ 126,000 хүн ажиллаж байна гэсэн тооцоо гарч байна.

Үндсэн болон давхар ажил эрхлэлт, хүйсээр

9.21 Албан бус секторт ажиллаж байгаа хүн амыг ажил эрхэлж байгаа байгууллагын төрөл, үндсэн болон давхар ажил эрхлэлт, хүйсээр нь хүснэгт 67-д үзүүлэв. Нийт 126,000 хүн үндсэн болон давхар ажил эрхэлж байгаагийн 55.2 хувь буюу 69,600 нь эрэгтэй, 44.8 хувь буюу 56,400 нь эмэгтэйчүүд байна. Нийт ажиллагчдын 113,700 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 11,200 нь ХЭАА-д, үлдсэн 1,100 нь нөхөрлөлд ажиллаж байна.

	Бүгд	Албан бус сектор					
		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
		Тоо	%	Тоо	%	Тоо	%
ХАА-н бус	Бүгд	126,000	100.0	69,600	55.2	56,400	44.8
	Үндсэн ажил	114,500	100.0	62,500	54.6	52,000	45.4
	Давхар ажил	11,500	100.0	7,100	61.5	4,400	38.5
ХЭАА	Үндсэн ажил	10,600	100.0	5,200	49.6	5,400	50.4
	Давхар ажил	600	100.0	400	69.0	200	31.0
Нөхөрлөл	Үндсэн ажил	900	100.0	400	46.0	500	54.0
	Давхар ажил	200	100.0	100	49.9	100	50.1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Үндсэн ажил	103,000	100.0	56,900	55.2	46,100	44.8
	Давхар ажил	10,700	100.0	6,600	61.3	4,100	38.7

Хүснэгт 67.


Тухайн үед албан бус секторт ажиллаж байгаа ажиллагчдын тоо, байгууллагын төрөл, үндсэн болон давхар ажил эрхлэлтийн байдлаар

9.22 Албан бус секторт ажиллагчдыг байршлаар нь авч үзэхэд үндсэн болон давхар ажил эрхэлж байгаа 126,000 хүний 89,300 (70.9 хувь) нь хотод, 36,700 (29.1 хувь) нь хөдөөд ажил эрхэлж байна (Зураг 13). Хувиараа хөдөлмөр эрхлэгч,

ХЭАА, нөхөрлөлд ажиллаж байгаа арван хүн тутмын гурав нь хөдөө ажиллаж байна.

Зураг 13.

Албан бус секторт ажиллагчдын байршлын бүтэц, хувиар



Албан бус секторт ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангиллаар

9.23 Албан бус секторт ажиллаж байгаа нийт хүн амын 56,600 (44.9 хувь) нь үйлчилгээний ажилтан, 43,900 (34.9 хувь) нь үйлдвэрийн ба худалдааны ажилтан, машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагчийн ажил эрхэлж байна. Албан бус секторын нийт ажиллагчдын 80.0 орчим хувь нь дээр дурдсан үндсэн хоёр ажил хөдөлмөрийг эрхэлж байна. 1,200 хүн хууль тогтоогч, удирдах ажилтан, менежер, 3,000 хүн мэргэжилтэнээр ажиллаж байна.

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд		Албан бус сектор					
			ХЭАА		Нөхөрлөл		Хувиараа хөдөлмөр эрхлэгч	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хууль тогтоогч, удирдах ажилтан, менежер	1,200	1.0	300	2.7	0	0.0	900	0.8
Мэргэжилтэн	3,000	2.4	200	1.8	300	27.3	2,500	2.2
Инженер техникийн ажилтан	3,800	3.0	300	2.7	100	9.1	3,400	3.0
Бичиг хэргийн туслах ажилтан	1,000	0.8	200	1.8	0	0.0	800	0.7
Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч	56,600	44.9	4,600	41.1	100	9.1	51,900	45.6
ХАА ба загасны аж ахуйн мэргэшсэн ажилчин	3,100	2.5	500	4.5	0	0.0	2,600	2.3
Үйлдвэрийн ба худалдааны ажилтан	22,900	18.2	2,600	23.2	200	18.2	20,100	17.7
Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	21,000	16.7	1,500	13.4	200	18.2	19,300	17.0
Энгийн ажил мэргэжил	13,400	10.6	1,000	8.9	200	18.2	12,200	10.7
Дүн	126,000	100.0	11,200	100.0	1,100	100.0	113,700	100.0


Хүснэгт 68.

Албан бус секторт ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангилал, байгууллагын төрлөөр

Дээрх хүснэгтээс харахад 3,100 хүн хөдөө аж ахуйн ба загасны аж ахуйн холбогдолтой ажил хийсэн байна.

Зураг 14.

Албан бус секторт ажиллагчдын боловсролын түвшний бүтэц, хувиар



Албан бус секторт ажиллагчдын боловсролын түвшин

9.24 Хүснэгт 69-д албан бус секторт ажил эрхлэж байгаа хүмүүсийг боловсролын түвшинээр үзүүлэв. Албан бус секторт ажиллагчдын таван хүн тутмын хоёр нь бүрэн дунд боловсролтой байна. Арван хүн тутмын гурав нь буюу 37,100 хүн бүрэн бус дунд болон түүнээс доош боловсролтой байна.

9.25 Албан бус секторт ажиллагчдын 13,500 нь дээд боловсролтой, 17,400 нь тусгай мэргэжлийн дунд/бүрэн бус дээд боловсролтой хүмүүс байна.

		Албан бус сектор							
		Бүгд		ХЭАА		Нөхөрлөл		Хувиараа хөдөлмөр эрхлэгч	
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Албан бус сектор	Бүгд	126,000	100.0	11,200	8.9	1,100	0.9	113,700	90.3
	Үндсэн ажил	114,500	100.0	10,600	9.3	900	0.8	103,000	90.0
	Давхар ажил	11,500	100.0	600	4.8	200	1.5	10,700	93.7
Боловсролгүй	Үндсэн ажил	1,000	100.0	-	0.0	-	0.0	1,000	100.0
	Давхар ажил	500	100.0	-	0.0	-	0.0	500	100.0
Бага	Үндсэн ажил	5,300	100.0	500	9.4	-	0.0	4,800	90.6
	Давхар ажил	1,100	100.0	100	5.2	-	0.0	1,000	94.8
Бүрэн бус дунд	Үндсэн ажил	26,200	100.0	3,400	13.0	100	0.4	22,700	86.6
	Давхар ажил	3,000	100.0	-	1.9	100	2.4	2,900	95.7
Бүрэн дунд	Үндсэн ажил	44,100	100.0	3,600	8.2	500	1.1	40,000	90.7
	Давхар ажил	2,400	100.0	200	8.0	-	0.0	2,200	92.0
Техник мэргэжлийн анхан шатны	Үндсэн ажил	10,600	100.0	1,000	9.4	100	0.9	9,500	89.6
	Давхар ажил	900	100.0	-	0.0	-	0.0	900	100.0
Тусгай мэргэжлийн дунд/бүрэн бус дээд	Үндсэн ажил	15,300	100.0	1,600	10.5	100	0.7	13,600	88.9
	Давхар ажил	2,100	100.0	100	4.1	-	2.4	2,000	93.5
Дээд	Үндсэн ажил	12,000	100.0	500	4.2	100	0.8	11,400	95.0
	Давхар ажил	1,500	100.0	200	10.9	100	3.5	1,200	85.6

Хүснэгт 69.

Албан бус секторт ажиллагчдын тоо, боловсролын түвшин, байгууллагын төрлөөр

б ү л э г 10

ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ



Бүлэг 10

ХҮҮХДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ

Нийтлэг зүйл

10.1 АХС-ны асуулгын сүүлийн бүлэгт буюу хүүхдийн хөдөлмөрийн талаархи хавсарга судалгаагаар эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь хүүхдийн оролцоог судалсан. Мөн АХС-нд хамрагдсан өрхийн гишүүдийн насны доод хязгаарыг 5 гэж тогтоон АХС-гаар хүүхдийн хөдөлмөр, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх өргөн мэдээллийг тухайн болон байнгын идэвхийн байдлаар цуглуулсан билээ. Түүнчлэн хүүхдийн эдийн засгийн бус үйл ажиллагаа, тухайлбал гэрийн ажилд хэрхэн оролцож буй талаарх мэдээллийг ч авсан. Иймд ХХХС-гаар хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдал, тархац, холбогдох үзүүлэлтүүд, хүүхдийн хөдөлмөрийн үр дагаврын талаар мэдээлэл цуглуулснаар хөдөлмөр эрхлэх эрсдэлд орсон, тусламж дэмжлэг шаардлагатай байгаа хүүхдүүдийг тодорхойлон гаргаж ирэх боломжтой болов. ОУХБ-ын Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр нь УСГ-тай хамтран ХХХС-гаар цуглуулсан тоо, мэдээнд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн тайлан гаргах юм. Нэгэнт тусдаа тайлан гаргах тул хүүхдийн хөдөлмөрийн талаарх зарим мэдээллийг энэ бүлэгт товч танилцуулсан болно.



Сургууль завсардалт

10.2 Судалгаанд хамрагдсан 5-17 насны 679,049 хүүхдийн 25.2 хувь буюу 171,200 нь сургуульд хамрагдаагүй (Хавсралт 1-ээс харна уу) бөгөөд эдгээр хүүхдүүдээс яагаад сургуульд явахгүй байгаа шалтгааныг тодруулж, дүнг нь Хүснэгт 70-д танилцуулав.

Шалтгаан	5-17 нас			5-9	10-14	15-17
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Бүгд	Бүгд
Насанд хүрээгүй	64.3	60.6	68.8	94.4	0.5	0.4
Сургууль хол	1.6	1.7	1.5	0.8	4.1	3.0
Хичээлийн хэрэглэл, хувцас зэрэг зардлыг дааж чадаагүй	4.8	5.0	4.7	1.0	17.9	10.6
Сурлага муу, сурах сонирхолгүй	6.6	7.8	5.2	0.6	20.2	19.1
Өрхийн орлогод нэмэр болох	5.0	6.0	3.8	0.2	8.3	18.5
Гэрийн ажилд туслах	9.0	10.4	7.4	0.8	20.4	29.4
Өвчтэй	3.2	2.8	3.7	0.7	13.4	5.8
Тахир дутуу	1.7	2.1	1.3	0.4	8.0	2.8
Бусад	3.8	3.6	3.6	1.1	7.2	10.4
Дүн %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	171,200	94,400	76,800	116,300	18,400	36,400

Хүснэгт 70.

5-17 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүй шалтгааны дүнд эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр

Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 64.3 хувь /хөвгүүдийн 60.6 хувь, охидын 68.8 хувь/ нь сургуульд орох насанд хүрээгүй гэсэн гол шалтгаантай байв. Монгол Улсад 7 настайдаа сургуульд ордог бөгөөд судалгаанд 5-6 насны хүүхдүүдийг хамруулсан нь сургуульд хамрагдаагүй хүүхдийн тоог

өсгөхөд нөлөөлсөн. Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 14.0 орчим хувь нь гэр орныхоо орлогод нэмэр болох, эцэг эхдээ туслах зорилгоор, 4.8 хувь нь хичээлийн хэрэглэл, хувцас хунар зэрэг сурахтай холбоотой зардлыг төлж чадахгүй байсан тул сургуульд яваагүй гэж хариулжээ.

Түүнчлэн өвчтэй, тахир дутуугийн улмаас сургуульд яваагүй гэж хариулсан хүүхдүүд 4.9 хувийг эзэлж байна.

Эдийн засгийн тухайн үеийн үйл ажиллагаа

10.3 Хүснэгт 71-ээс харахад 5-17 насны 65,729 хүүхэд (үүний дотор 40,406 хөвгүүд, 25,323 охид) сүүлийн долоо хоногт эдийн

засгийн үйл ажиллагаанд оролцжээ. Нийт хүүхдийн 93.0 хувь нь мал аж ахуй, ойн аж ахуйн, газар тариалангийн, 4.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, төрөл бүрийн бизнесийн үйл ажиллагаанд оролцсон байна. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон нийт хүүхдийн 1.1 хувь буюу 706 хүүхэд /451 хөвгүүд, 254 охид/ цалин хөлстэй ажил эрхэлсэн байна.

Эдийн засгийн үйл ажиллагаа	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<i>A/ Тоогоор</i>			
Цалин хөлстэй ажил	706	451	254
Худалдаа, үйлчилгээ	3122	1809	1313
МАА, ан агнуур	58433	35759	22674
Газар тариалан	2536	1755	781
Ойн аж ахуй, мод бэлтгэх	45	45	0
Тээврийн үйлчилгээ	194	194	0
Ашигт алтмал олборлох	615	410	205
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх	157	0	157
Зочид буудал, зоогийн газар	525	151	374
Эд зүйлс, ахуйн жижиг засвар үйлчилгээ	70	70	0
Гар урлал	136	50	86
Барилга барих, их засварын үйлчилгээ	172	119	52
Хөлстэйгээр хүүхэд асрах болон хувиараа хичээл заах	17	0	17
Нийт хүүхдийн тоо	65,729	40,406	25,323
Цалин хөлстэй ажил	706	451	254
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	65,023	39,955	25,068
<i>Б/ Дүнд эзлэх хувь, %</i>			
Цалин хөлстэй ажил	1.1	1.1	1.0
Худалдаа, үйлчилгээ	4.7	4.5	5.2
МАА, ан агнуур	88.9	88.5	89.5
Газар тариалан	3.9	4.3	3.1
Ойн аж ахуй, мод бэлтгэх	0.1	0.1	0.0
Тээврийн үйлчилгээ	0.3	0.5	0.0
Ашигт алтмал олборлох	0.9	1.0	0.8
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх	0.2	0.0	0.6
Зочид буудал, зоогийн газар	0.8	0.4	1.5
Эд зүйлс, ахуйн жижиг засвар үйлчилгээ	0.1	0.2	0.0
Гар урлал	0.2	0.1	0.3
Барилга барих, их засварын үйлчилгээ	0.3	0.3	0.2
Хөлстэйгээр хүүхэд асрах болон хувиараа хичээл заах	0.0	0.0	0.1
Нийт (%)	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй ажил	1.1	1.1	1.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	98.9	98.9	99.0

Хүснэгт 71.

Сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн тоо, эзлэх хувь, хүйсээр

Эдийн засгийн бус үйл ажиллагаа

10.4 Хүснэгт 72-д харуулсанчлан 5-17 насны 567,400 хүүхэд сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцжээ. Эдгээр хүүхдийн 76.4 хувь нь сүүлийн 7 хоногт хоол цай хийн, аяга таваг угааж, охидын 85.8 хувь, хөвгүүдийн 62.5 хувь нь гэр орон цэвэрлэсэн байна. Нийт хүүхдийн 8.1 хувь /эрэгтэй 6.5, эмэгтэй 9.8/ нь хүүхэд асарсан бол 12.4 хувь нь гэрийн тэжээвэр амьтан арчлах, цэцэг тарих, олон нийтийн болон сайн дурын ажилд үнэ хөлсгүй оролцжээ.

10.5 Гэрийн ажил хийсэн нийт хүүхдийн 53.0 хувь, үүний дотор эрэгтэй хүүхдүүдийн 61.8 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 44.0 хувь нь ус авсан байна. Түлш, түлээ бэлтгэхэд 5-17 насны гэрийн ажил хийсэн хүүхдүүдийн 47.0 хувь /эрэгтэй

хүүхдүүдийн 56.0 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 37.0 хувь/ оролцжээ. Тухайн үеийн үйл ажиллагааны талаарх 5-р бүлэгт ус авах, түлээ, түлш бэлтгэх ажлыг НҮБ-аас зөвлөмж болгож буй ҮТС-ийн хүрэн дэх эдийн засгийн үйл ажиллагаанд оруулан тооцдог талаар өгүүлсэн билээ. 5-17 насны 300,400 хүүхэд ус авах, 265,100 хүүхэд түлээ, түлш бэлтгэх ажлыг хийсэн байна. (Хүснэгт 32, 33-ыг харна уу) Хэрвээ эдгээр ус авсан, түлээ, түлш бэлтгэсэн хүүхдүүдийг эдийн засгийн идэвхитэй гэж үзэн ажил эрхэлсэнд тооцох юм бол эдийн засгийн идэвхитэй хүүхдүүдийн тоог тухайн үеийн нийт ажиллах хүчний 30.0-40.0 хувийг эзлэх хүртэл эрс нэмэгдүүлэх болно.

Эдийн засгийн бус үйл ажиллагаа	Бүгд			5-9	10-14	15-17
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Бүгд	Бүгд
Хоол цай хийх, аяга таваг угаах	76.4	66.9	86.1	73.8	76.4	78.9
Гэр орон цэвэрлэх	74.1	62.5	85.8	67.3	76.7	76.0
Хувцас угаах, индүүдэх	45.8	35.7	56.1	15.0	48.9	68.7
Гэр байшин, эд хогшил сэргээн засах	5.9	9.1	2.7	2.0	5.1	10.8
Гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах	21.1	18.3	23.9	11.3	22.6	27.6
Хувцас бусад нэхмэл сүлжмэл эдлэл оёх, арчлах	5.8	2.1	9.5	1.2	5.5	10.2
Ус авах	53.0	61.8	44.0	39.5	57.2	58.2
Түлээ түлш бэлтгэх	46.7	56.3	37.1	40.5	47.0	52.0
Өндөр настан, өвчтэй хүн асрах	2.3	1.8	2.8	1.3	2.3	3.2
Хүүхэд асрах	8.1	6.5	9.8	12.4	7.4	5.4
Гэрийн тэжээвэр амьтан арчлах, цэцэг тарих	6.4	7.6	5.3	5.4	6.8	6.8
Олон нийтийн болон сайн дурын ажилд үнэ хөлсгүй оролцох	6.0	5.9	6.1	3.0	6.9	7.3
Дүн, %	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	567,400	285,500	281,900	144,800	262,700	159,900

Хүснэгт 72.

Сүүлийн 7 хоногт эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн тоо, эзлэх хувь, хүйсээр

Ингэснээр хүн амын ажилгүйдлийн тоог хиймлээр бууруулахын зэрэгцээ ажил мэргэжлийн ангиллын дагуу дээрх ус авах, түлээ түлш бэлтгэх энэ хоёр үйл ажиллагааг ямар салбарын үйл ажиллагаанд тооцох нь тодорхойгүй байгаа билээ. Иймд энэ хоёр үйл ажиллагааны талаарх тоо мэдээг тооцсон боловч эдийн засгийн үйл ажиллагааны ангилалд оруулаагүй бөгөөд тоо мэдээг хэрхэн ангилан ашиглахаа хэрэглэгч өөрсдийн зорилгод нийцүүлэн шийдэх нь зүйтэй.

Хүүхдийн хөдөлмөр

10.6 Сүүлийн 12 сард 5-17 насны нийт 73,484 хүүхэд эдийн засгийн идэвхитэй байгаагийн 68,580 нь ажил эрхэлж, 4,904 нь ажил хайсан байна. Хүснэгт 73-т 5-17 насны хүүхдүүдийн эдийн засгийн идэвхи буюу ажиллах хүчний байдлыг харуулав. Таван насандаа 2,482 хүүхэд хүүхдийн хөдөлмөр эрхэлж байснаа 17 насанд 12,355 болж нэмэгджээ. Нийт ажиллах хүчний 7.3 хувийг 15-17 насны хүүхдүүд бүрдүүлж байна. (Хавсралт 1-ээс харна уу)



10.7 Сүүлийн 7 хоногт 5-17 насны 68,580 хүүхэд, үүний дотор 41,874 хөвгүүд, 26,706 охид ажил хийсэн байна. 5-9 насанд ажил эрхэлж буй хүүхдийн тоо 15,320, 10-14 насанд 21,407 байхад 15-17 насанд 31,854 болсон байна. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн бараг 50.0 орчим хувь нь 15-17 насныхан байна.

Хүснэгт 73.

5-17 насны ажиллаж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, хүйсээр


Насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Ажиллах хүч			Ажиллагчид			Ажилгүйчүүд		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	679049	347652	331397	73484	44573	28911	68580	41874	26706	4904	2700	2204
5-9	212145	109205	102940	15344	9030	6315	15320	9005	6315	25	25	0
10-14	294841	151999	142843	21925	13990	7935	21407	13762	7645	518	229	289
15-17	172063	86449	85614	36215	21553	14661	31854	19107	12746	4361	2446	1915
Хот												
Бүгд	360750	184932	175818	9961	6232	3729	6894	4558	2336	3067	1674	1393
5-9	97575	50591	46984	585	353	231	560	328	231	25	25	0
10-14	167360	86365	80995	3042	2137	906	2662	2004	659	380	133	247
15-17	95816	47976	47839	6334	3742	2592	3672	2226	1446	2662	1516	1146
Хөдөө												
Бүгд	318299	162720	155579	63523	38341	25181	61686	37316	24370	1837	1026	811
5-9	114570	58614	55956	14760	8676	6083	14760	8676	6083	0	0	0
10-14	127482	65634	61848	18883	11854	7029	18745	11758	6987	138	96	42
15-17	76247	38472	37775	29880	17811	12069	28182	16882	11300	1699	930	769

Хүүхдийн хөдөлмөр, ажил мэргэжлийн ангиллаар

10.8 Зураг 15-д ажил хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн ажил мэргэжлийн бүтцийг харуулав. Нийт ажиллаж байгаа хүүхдүүдийн дийлэнх буюу 90,8 хувь хөдөө аж ахуйн болон түүний холбогдолтой ажил эрхэлж байна. Хөдөө аж ахуйн холбогдолтой ажил хийж байгаа хүүхдүүдийн 61,1 хувь нь эрэгтэй хүүхэд байна. Түүнчлэн нийт хүүхдийн 2,8 хувь нь янз бүрийн чиглэлээр энгийн ажил үүрэг гүйцэтгэжээ. Харин мэргэжилтэн, инженер техникийн ажил хийсэн гэж бүртгэгдсэн хүүхдийн тоо нь асуулга авах, бөглөх, кодлоход гарсан алдаатай холбоотой байж болзошгүй юм.

Зураг 15.

5-17 насны ажиллаж байгаа хүүхдийн дүнд эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллаар



Хүүхдийн ажил эрхлэлтийн байдал

10.9 Хүүхдийн ажил эрхлэлтийн байдлыг харахад 61,677 хүүхэд буюу 37,379 эрэгтэй, 24,298 эмэгтэй хүүхэд өрхийн бизнест цалин хөлсгүй оролцож байхад 5,688 хүүхэд хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. Хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдүүдийн тун бага ба 1.7 хувь буюу 1,154 нь гэрээгээр ажил эрхэлж байна (Хүснэгт 74-өөс харна уу). Хүүхдийн хөдөлмөрийн 89.9 хувь нь хөдөө орон нутагт төвлөрч байгаагаас харахад энэ нь тус газар нэлээд анхаарал татууштай асуудал болж байна. Хот, суурин газарт нийт 6,894 хүүхэд хөдөлмөр эрхэлж байна.



Ажил эрхлэлтийн байдал	5-17 нас			Бүгдээс: насны бүлгээр		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	5-9	10-14	15-17
Бүгд	68580	41874	26706	15320	21407	31854
Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч	694	440	254	0	38	657
Иргэний гэрээгээр ажиллагч	460	139	322	0	195	265
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	5688	3855	1832	119	1822	3747
Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	61677	37379	24298	15200	19291	27185
Бусад	61	61	0	0	61	0
Хот						
Бүгд	6894	4558	2336	560	2662	3672
Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч	568	350	218	0	38	531
Иргэний гэрээгээр ажиллагч	207	102	105	0	102	105
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	1020	776	245	0	621	399
Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	5098	3329	1769	560	1901	2638
Хөдөө						
Бүгд	61686	37316	24370	14760	18745	28182
Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч	126	90	36	0	0	126
Иргэний гэрээгээр ажиллагч	254	36	217	0	93	161
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	4667	3080	1588	119	1201	3347
Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	56579	34050	22529	14641	17391	24547
Бусад	61	61	0	0	61	0

Хүснэгт 74.

5-17 насны ажиллаж байгаа хүүхдийн ажил эрхлэлтийн байдал, хүйс, насны бүлгээр

Хүүхдийн хөдөлмөр, байнгын идэвхийн аргачлалаар

10.10 Сүүлийн 7 хоногт нэг цаг л ажил хийсэн бол тухайн хүүхдийг ажил эрхэлсэн гэж үздэг бол сүүлийн 12 сарын хугацаанд 6 сар ба түүнээс дээш хугацаанд ажил эрхэлсэн эсвэл ажил эрж хайж,

ажиллахад бэлэн байсан бол байнгын идэвхитэйд тооцдог. Ийм ч учраас сүүлийн 12 сарын хүүхдийн хөдөлмөр эрхлэлт сүүлийн долоо хоногийнхтой харьцуулахад бага гарсан байна.

10.11 Хүүхдийн хөдөлмөрийн асуулгыг АХС-нд хавсруулан явуулсан тул сүүлийн 12 сарын байдлаар хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллийг өрхийн 5 ба түүнээс дээш насны бүх гишүүдээс цуглуулсан. Хүснэгт 75-д сүүлийн 7 хоногт 5-17 насны 73,484 хүүхэд эдийн засгийн идэвхитэй байсны 68,580 нь ажил хийж, 4,904 хүүхэд ажил хайсан гэж гарсан бол сүүлийн 12 сарын байдлаар эдийн засгийн

идэвхитэй хүүхдийн тоо 52,024 болж буурчээ. Үүнээс 48,937 хүүхэд ажил эрхэлж, 3,087 хүүхэд ажил хайсан байна. Ийнхүү хүүхдийн хөдөлмөрийг сүүлийн 12 сарын байдлаар харахад эдийн засгийн идэвхитэй хүүхдийн тоо 29.2 хувиар, хөдөлмөр эрхэлсэн буюу ажил хийсэн хүүхдийн тоо 68,580-аас 48,937 болж, бараг 19,643 хүүхдээр буурсан байна.

Насны бүлэг	Бүгд	Үүнээс:			Эдийн засгийн идэвхигүй
		Эдийн засгийн идэвхитэй	Ажиллагчид	Ажилгүйчүүд	
Тухайн үеийн идэвхитэй					
Бүгд	679050	73484	68580	4904	605566
5-9	212145	15344	15320	25	196801
10-14	294842	21925	21407	518	272917
15-17	172063	36215	31854	4361	135848
Эрэгтэй	347653	44573	41874	2700	303080
5-9	109205	9030	9005	25	100175
10-14	151999	13990	13762	229	138009
15-17	86449	21553	19107	2446	64896
Эмэгтэй	331397	28911	26706	2204	302486
5-9	102940	6315	6315	0	96625
10-14	142843	7935	7645	289	134908
15-17	85614	14661	12746	1915	70953
Байнгын идэвхитэй					
Бүгд	679050	52024	48937	3087	627026
5-9	212145	9074	9017	57	203071
10-14	294842	13625	13274	351	281217
15-17	172063	29325	26646	2679	142738
Эрэгтэй	347653	32731	30978	1753	314922
5-9	109205	5590	5533	57	103615
10-14	151999	8943	8800	143	143056
15-17	86449	18198	16645	1553	68251
Эмэгтэй	331397	19293	17959	1334	312104
5-9	102940	3484	3484	0	99456
10-14	142843	4682	4474	208	138161
15-17	85614	11127	10001	1126	74487

Хүснэгт 75.

5-17 насны хүүхдийн ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, хүйс, сүүлийн 7 хоног болон 12 сарын байдлаар

Насны бүлэг	Бүгд	Үүнээс:			Эдийн засгийн идэвхигүй
		Эдийн засгийн идэвхитэй	Ажиллагчид	Ажилгүйчүүд	
Тухайн үеийн идэвхитэй					
Бүгд	679050	73484	68580	4904	605566
5-9	212145	15344	15320	25	196801
10-14	294842	21925	21407	518	272917
15-17	172063	36215	31854	4361	135848
Хот	360750	9961	6894	3067	350789
5-9	97575	585	560	25	96990
10-14	167360	3042	2662	380	164318
15-17	95816	6334	3672	2662	89482
Хөдөө	318299	63523	61686	1837	254776
5-9	114570	14760	14760	0	99811
10-14	127482	18883	18745	138	108599
15-17	76247	29880	28182	1699	46367
Байнгын идэвхитэй					
Бүгд	679050	52024	48937	3087	627026
5-9	212145	9074	9017	57	203071
10-14	294842	13625	13274	351	281217
15-17	172063	29325	26646	2679	142738
Хот	360750	6350	4692	1658	354400
5-9	97575	527	527	0	97048
10-14	167360	1625	1412	213	165735
15-17	95816	4198	2753	1445	91618
Хөдөө	318299	45673	44244	1429	272626
5-9	114570	8547	8490	57	106023
10-14	127482	12000	11862	138	115482
15-17	76247	25126	23892	1234	51121

Хүснэгт 76.

5-17 насны хүүхдийн ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг, байршил, сүүлийн 7 хоног болон 12 сарын байдлаар

б ү л э г 11

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ



Бүлэг 11

АЖИЛЛАХ ХÜЧНИЙ УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ

Нийтлэг зүйл

11.1 Тус судалгааны нэг зорилго нь ажиллах хүчний улирлын хэлбэлзлийг улсын хэмжээнд болон хот, хөдөөгөөр судлан гаргах явдал байв. Энэ зорилгын хүрээнд нийт түүврийн хэмжээг 4 улирлаар бүлэглэн тэнцүү хувааж, түүврийн сонголтыг 3 сар тутам буюу улирал бүрээр хангалттай хэмжээнд хийсэн болно. Нэг улиралд 3,200 өрх, 12,000 гаруй хүнийг түүвэрлэн хамруулж нийт дөрвөн улирлын тоо мэдээг нэгтгэн үндсэн үзүүлэлтүүдийг тооцов. Судалгаанд бүгд 49,948 өрхийн гишүүнийг хамруулж судалгааны эхний улирлын мэдээлэл цуглуулах ажлыг 2002 оны 10-12-р сар

дуусталх хугацаанд, 2, 3 дугаар улирлын судалгааг дараачийн саруудад 3, 3 сараар, 4 дүгээр улирлын судалгааг 2003 оны 7-9-р саруудад явуулж дуусгасан. Энэ бүлэгт хэд хэдэн гол үзүүлэлтүүдийг улирлаар тооцсон дүнг танилцуулж байна.

Хүн амын тоо, улирлаар

11.2 Судалгааны тооцоогоор Монгол Улсын хүн ам 2402,8¹ мянга байна (Хүснэгт 77).

	Судалгааны	1-р	2-р	3-р	4-р
	хугацаанд	улирал	улирал	улирал	улирал
	2002.X-2003.IX	X-XII	I-III	IV-VI	VII-IX
Нийт хүн ам	2,402,800	2,372,300	2,401,500	2,474,700	2,359,200
Өрхийн тоо	568,800	554,200	565,300	588,700	566,600
6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо	174,000	189,700	190,700	179,400	137,800
Үүнээс:					
Суралцаж байгаа	121,000	136,100	140,300	122,600	84,600
Ажиллаж байгаа	34,600	32,600	32,900	38,700	36,000
Бусад	18,400	21,000	17,500	18,100	17,200
Судалгаанд хамрагдсан хүний тоо	2,228,800	2,182,600	2,210,800	2,295,300	2,221,400
Эрэгтэй	1,106,100	1,080,100	1,099,200	1,137,300	1,107,000
Эмэгтэй	1,122,700	1,102,500	1,111,600	1,158,000	1,114,400
0-14 насны - бүгд	689,600	677,800	694,700	722,900	661,200
Эрэгтэй	355,300	348,900	358,200	373,000	341,600
Эмэгтэй	334,300	328,900	336,500	349,900	319,600
15, түүнээс дээш насны – бүгд	1,539,200	1,504,800	1,516,100	1,572,400	1,560,200
Эрэгтэй	750,800	731,200	741,000	764,300	765,400
Эмэгтэй	788,400	773,600	775,100	808,100	794,800
5-17 насны – бүгд	679,000	673,500	664,600	706,300	669,000
Эрэгтэй	347,600	343,900	346,600	355,800	346,000
Эмэгтэй	331,400	329,600	318,000	350,500	323,000

Хүснэгт 77.

Өрх, хүн амын тоо, улирлаар

¹ Энэ хүснэгтэд нийтийн байр болон 6 сараас дээш хугацаагаар түр эзгүй байгаа өрхийн гишүүдийг хамруулсангүй. Энэ нь нийт хүн амын тоог буурахад нөлөөлсөн.

Эдийн засгийн идэвхитэй хүн ам

11.3 Эдийн засгийн идэвхитэй хүн ам буюу ажиллах хүчийг улирлаар тооцож үзэхэд өвлийн цагт буюу судалгааны 2 дугаар улиралд доогуур 986,8 мянга байснаа хавар, зуны цагт өсч, 3 дугаар улирал гэхэд 1.020 мянга болжээ. Дөрвөн улирлын турш эдийн засгийн идэвхитэй хүн ам нэг их өөрчлөгдөлгүйгээр ойролцоогоор 1.0 сая байна.

Түүврийн алдааны нөлөөллөөс шалтгаалан энэхүү хэлбэлзэл нь байх боломжтой гэж үзэж байна.

11.4 Эдийн засгийн идэвхигүй хүн ам судалгааны 1 дүгээр улирлаас 3 дугаар улирал хүртэлх хугацаанд 50,000-иар нэмэгдсэнээс харахад өвлийн улиралд эдийн засгийн

	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	2002.X-2003.IX	X - XII сар	I - III сар	IV - VI сар	VII - IX сар
Ажиллах хүч	1,004,800	1,002,600	986,800	1,020,000	1,014,100
Эрэгтэй	523,500	527,700	514,500	526,800	525,900
Эмэгтэй	481,300	474,900	472,300	493,200	488,200
АХОТ, 15+	65.3	66.6	65.1	64.9	65.0
Эрэгтэй	69.7	72.2	69.4	68.9	68.7
Эмэгтэй	61.1	61.4	60.9	61.0	61.4
Хот	56.4	59.9	55.8	55.3	55.1
Хөдөө	76.3	75.1	77.1	76.8	76.8
Эдийн засгийн идэвхигүй хүн ам	534,400	502,200	529,300	552,400	546,100
Эрэгтэй	227,400	203,600	226,500	237,500	239,400
Эмэгтэй	307,000	298,600	302,800	314,900	306,700
Хот	372,500	337,400	378,000	389,600	380,500
Хөдөө	161,900	164,800	151,300	162,800	165,600

Хүснэгт 78.

15, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхи, улирлын тооцоогоор

идэвхигүй байсан хүмүүс хавар, зуны улиралд эдийн засгийн идэвхитэй болсон бус харин ч эсрэгээр байж болох юм. Судалгааны 3 дугаар улиралд ажиллах хүчний оролцооны түвшин 64.9 хувь, харин 1 дүгээр улиралд 66.6 хувь байв. Түүврийн алдааны нөлөөллөөс шалтгаалан энэхүү хэлбэлзэл гарч ирж болно.

Ажиллагчдын тоо

11.5 Хүснэгт 79-д ажиллах хүчний эрэлт хэрэгцээ нь улирлаар хэлбэлзэж буйг харуулж байна. Судалгааны 1 дүгээр улиралд ажил эрхэлсэн хүний тоо хамгийн бага 822,300 байснаа дараачийн улирлуудад аажмаар өсч, 4

дүгээр улиралд 906,000 болжээ. Эдийн засгийн идэвхитэй хүн амын тоон дахь хэлбэлзэл нь ажил эрхэлсэн хүн амын тооны өөрчлөлттэй холбоогүй бөгөөд ажилгүйчүүдийн тоо буурсан нь ажил эрхэлсэн хүмүүсийн тоог нэмэгдэхэд хүргэжээ. Ажиллах хүчний нэг хэсэг буюу эдийн засгийн идэвхитэй хүмүүс жилийн хэсэг хугацаанд эдийн засгийн идэвхигүй болж, тэдний орыг өөр хүмүүс эзэлж байж ч болох талтай. Гэхдээ энэ судалгааны тоо мэдээнд гүнгийрүүлсэн анализ хийх замаар ийм хөдөлгөөн, өөрчлөлтийн талаар бодитой дүгнэлт хийж болох юм. Гэхдээ л өвлийн улирал дуусахтай зэрэгцэн ажлын орон тоо гарч ажилгүй хүн амын нэг хэсэг ажил эрхлэн энэ нь ажил эрхлэгч хүн амын тоог нэмэгдүүлж байгаа нь тодорхой байна.

	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	2002.X-2003.IX	X - XII сар	I - III сар	IV - VI сар	VII - IX сар
Ажиллагчид – бүгд	897,100	854,900	871,600	924,300	942,000
Өрхөөс гадуур ажил эрхлэгчид	34,600	32,600	32,900	38,700	36,000
Тухайн үеийн ажиллагчдын тоо	862,500	822,300	838,700	885,600	906,000
Эрэгтэй	448,900	433,900	435,000	455,900	471,000
Эмэгтэй	413,600	388,400	403,700	429,700	435,000
Хот	392,300	393,700	384,700	393,500	395,900
Хөдөө	470,200	428,600	454,000	492,100	510,100
Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар					
Хөдөө аж ахуй	402,700	363,300	382,100	424,500	445,400
Үйлдвэрлэл	102,900	106,300	102,800	98,100	104,100
Үйлчилгээ	356,900	352,700	353,800	363,000	356,500
Ажил эрхлэлтийн байдлаар					
Гэрээгээр ажиллагч	338,600	350,000	343,400	339,400	321,800
Ажил олгогч	5,500	5,400	6,100	5,600	5,000
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	303,400	271,600	276,100	313,900	350,500
Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	215,000	195,300	213,100	226,700	228,700
Бүрэн бус ажил эрхлэлт – бүгд	58,200	78,500	53,100	58,900	42,400
Эрэгтэй	34,400	46,100	30,700	37,000	23,900
Эмэгтэй	23,800	32,400	22,400	21,900	18,500

Хүснэгт 79.

Тухайн үеийн идэвхээр тодорхойлогдсон 15, түүнээс дээш насны ажил эрхэлсэн хүн амын тоо, улирлаар



11.6 Хүн амын ажил эрхлэлтийн улирлын хэлбэлзэл ХАА-н бус салбарт бараг байхгүй, харин ХАА-н салбарт ихээхэн хэлбэлзэлтэй байна (Зураг 16). Судалгааны 1 дүгээр улиралд ХАА-н салбарт ажиллагчдын тоо 363,300 байсан бол аажмаар өсч, 2 дугаар улиралд 382,100, харин 4 дүгээр

улиралд 22.6 хувь буюу 82,100 хүнээр нэмэгдэж 445,400 болжээ. Ажиллах хүчний эрэлт хэрэгцээ улирлаар өсөх явдал хөдөө орон нутагт ажиглагдаж судалгааны 1 дүгээр улиралд ажиллагчдын тоо 428,600 байснаа 4 дүгээр улиралд 510,100 болтол нэмэгдсэн байна. Харин үйлдвэрлэл, үйлчилгээний

салбарт ажиллагчдын тоо улирлаар үндсэндээ өөрчлөгдөөгүй байгаа юм. Түүврийн алдааны нөлөөллөөс шалтгаалан энэхүү хэлбэлзэл нь байх боломжтой гэж үзэж байна.

Зураг 16.

Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, улирлаар



11.7 Сүүлийн 12 сард ажиллагчдын тоо судалгааны улирлын хооронд өссөн боловч энэ өсөлт нь сүүлийн 7 хоногийнхтой харьцуулахад тийм ч өндөр бус байна. Өсөлт нь ихэвчлэн судалгааны 1 дүгээр улиралд ХАА-н салбарт ажиллагчдын тоо 365,100 байснаа 4 дүгээр улиралд 426,900 болж нэмэгдсэнтэй холбоотой байна. Судалгааны нэг, дөрөвдүгээр улирлуудад үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллагчдын тоонд онцын их өөрчлөлт ажиглагдаагүй нь энэ салбарт ажил эрхлэлт улирлаар нэг их хэлбэлзэдэггүйг нотолж байна.

Үзүүлэлтүүд	Судалгааны хугацаанд	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
Байнгын идэвхитэй хүн ам	941,500	946,300	914,600	959,800	948,900
Эрэгтэй	492,200	502,600	475,000	498,000	494,000
Эмэгтэй	449,300	443,700	439,600	461,800	454,900
АХОТ, %	61.2	62.9	60.3	61.0	60.8
Эрэгтэй	65.5	68.7	64.1	65.2	64.5
Эмэгтэй	57.0	57.4	56.7	57.1	57.2
Байнгын идэвхи:					
Ажиллагчид – бүгд	856,600	827,200	836,000	877,600	887,000
Эрэгтэй	446,800	438,600	434,000	452,100	462,200
Эмэгтэй	409,800	388,600	402,000	425,500	424,800
Хот	394,000	400,800	383,800	393,100	396,100
Хөдөө	462,600	426,400	452,200	484,500	490,900
Эдийн засгийн үндсэн салбараар					
Хөдөө аж ахуй	396,800	365,100	381,900	416,800	426,900
Үйлдвэрлэл	103,500	108,900	103,300	98,300	103,300
Үйлчилгээ	356,300	353,200	350,800	362,500	356,800
Ажил эрхлэлтийн байдал					
Гэрээгээр ажиллагч	340,400	354,200	343,700	338,000	325,900
Ажил олгогч	8,100	12,200	7,900	7,100	4,900
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	281,400	232,700	246,400	306,900	339,400
Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч	226,700	228,100	238,000	225,600	216,800

Хүснэгт 80.

Байнгын идэвхээр тодорхойлогдсон 15, түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд, улирлаар


Ажил эрхлээгүй хүн ам

